



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ, ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО СУЛ, УЯЛДАА
ХОЛБОО АЛДАГДСАН БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН
ТОГТОЛЦОО, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: ГАГ-2025/10-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Д.Баттулга

Утас: 261639, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Энх-Амгалан

Утас: 263755, Цахим хаяг: enkhamgalankh@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Мөнхцэцэг

Утас: 263755, Цахим хаяг: munkhtsetsegba@audit.gov.mn

Аудитор М.Минжин

Утас: 263755, Цахим хаяг: minjinm@audit.gov.mn

Аудитор Б.Очмаа

Утас: 263755, Цахим хаяг: ochmaab@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 9/152

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх хэсэг, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3.Аудитаар тогтоосон албан шаардлага, өгсөн төлбөрийн актыг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (М.Бадамсүрэн)-д зөвлөсүгэй.

5.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор (Ч.Цэвэгдорж)-т даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 12 дугаар сарын 15 өдрийн 15 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСНИЙ ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	5
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ	6
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	6
Аудитын зорилт	6
Аудитын шалгуур үзүүлэлт	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.	10
1.1 Богино болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын зорилт, арга хэмжээ уялдаагүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нарийвчлан тусгаагүй байна.	10
1.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримталж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, үндсэн зорилгодоо хүрээгүй байна.	12
1.3 УИХ-ын 36 дугаар тогтоолын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тогтоогоогүйгээс зорилт арга хэмжээний хэрэгжилт тодорхойгүй байна.	14
1.4 Хүнсний аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ нотлох баримтад үндэслээгүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг бүрэн хийгээгүй, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.	14
1.5 Хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах чиг үүрэгтэй байгууллагуудын зарим чиг үүрэг давхардсан, хоорондын уялдаа холбоогүй, хуульд заасан эрх зүйн актыг одоог хүртэл батлаагүй байна.	15
1.6 Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, салбар хоорондын уялдаа, хяналт-шинжилгээний тогтолцоо сул байна.	17
1.7 Кодексын үндэсний зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас олон улсын хүнсний стандартыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажил удаашралтай байна.	18
1.8 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн ажиллах журмыг батлаагүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.	20
1.9 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээг тодорхой хүрээнд тогтоосон хэдий ч олон улсад хянаж, зохицуулдаг зарим бохирдуулагчдыг хянах стандарт, техникийн зохицуулалт байхгүй байна.	21
1.10 Стандартын улсын үзлэгийн зөвлөмжийн үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, хүнсний салбарын стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын 63 хувь нь хэрэгжээгүй байна.	22
1.11 Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоосон стандарт, шинжилгээний аргачлалын стандартууд болон аюулгүйн үзүүлэлтүүд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.	23
1.12 ХАБ-ийн шинжилгээ хийж буй лабораториуд нь шинжилгээний аргачлал болон багажийн хэрэглээний нийцлийг тогтмол үнэлэх, шинжилгээний арга зүйг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна.	23
БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ТОГТОЛЦОО БЭХЖЭЭГҮЙ, ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ АЛДАГДСАН БАЙНА.	24
2.1 Хүнсний чанар, аюулгүй байдлын зорилт, шинжилгээ хийж буй үндэсний лавлагаа лабораториуд хүнсний түүхий, эд бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг бүрэн шинжлэхгүй байна.	24
2.2 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг бүрэн хамруулан шинжилгээ хийх талаарх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.	25
2.3 Импортын болон дотоодын мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдлийг бүрэн хянаж, тодорхойлж чадахгүй байна.	26

2.4 Лабораториудын барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөц, арга зүйн болон чанарын удирдлагын тогтолцоо нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага хангахгүй байна.	27
2.5 Итгэмжлэгдээгүй лабораториуд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шинжилгээг гүйцэтгэж байгаа нь хууль, стандартын шаардлагыг зөрчиж, шинжилгээний үр дүнгийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлж байна.	28
2.6 Улсын төсөв, АХБ-ны санхүүжилтээр нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.	29
2.7 СХЗГ нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, лабораторийн тоног төхөөрөмж худалдан авч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасныг зөрчсөн байна.	31
2.8. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр мэдээллийг бүртгэх цахим системүүд уялдаагүй, нэгдсэн мэдээллийн сан үүсээгүй, хяналтын систем бүрдээгүй байна.	32
2.9 Систем хөгжүүлсэн компани төрийн байгууллагын системийг ашиглаж үйлчилгээний тариф тогтоон орлого олсон байна.	33
2.10 Хүнсний аюулгүй байдлын хангах лабораторийн нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна. ...	34
2.11 Лабораторийн шинжилгээний дүнг цахим системд засварлаж, өөрчлөх тохиолдол цөөнгүй байна.	36
2.12. Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, эм, хэрэгслийн аюулгүй байдлыг хянах, малын дархлаажуулалтын эм бэлдмэлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	36
2.13 Сүхбаатар, Ховд аймагт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт үр дүнгүй болж 280.8 сая төгрөгийн вакцин, бэлдмэл, 396.7 сая төгрөгийн үйлчилгээний хөлс, нийт 677,6 сая төгрөгийн хохирол учирсан байна.	37
2.14 Вакцин худалдан авахдаа хууль зөрчсөн байна.	39
2.15 Хүнсний сүлжээнээс түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах ажил хэрэгжихгүй байна.	40
2.16. Импортоор оруулж ирж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналт тогтолцооны өөрчлөлтөөс үүдэлтэй буурч, холбогдох хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажил удаашралтай байна.	41
2.17 Анхан болон давтан шинжилгээний үр дүнгийн зөрүүтэй байдал нь импортын хүнсний чанар аюулгүй байдлын хяналт, баталгаажуулалт алдаатай байгааг харуулж байна.	43
2.18 Гаалийн байгууллагад аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг шийдвэрлэх үе шатанд хяналт тавих тогтолцоо бүрдээгүйгээр хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл өндөр байна.	45
2.19 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	46
Дүгнэлт	48
Зөвлөмж:	50
Аудитын тайлангийн төсөлд холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:	54

ТОВЧИЛСОН ҮГСНИЙ ЖАГСААЛТ

Товчлол	Тайлал
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБТТУтХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
МУЗГҮАХХАХТ	Монгол Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй төсөл
МУХЖТ	Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХБАБтХ	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ОХУ	Оросын Холбооны улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
СТЗТҮИтХ	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
МАЭМтХ	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
ҮИТ	Үндэсний итгэмжлэлийн төв
ОУНБ	Олон улсын нисэх буудал
ГСЛ	Гаалийн салбар лаборатори
МЭГ	Мал эмнэлгийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Хүснэгт 1	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хувь
Хүснэгт 2	Гол нэрийн зарим барааны дундаж үнэ /Улаанбаатар хот/
Хүснэгт 3	Бодлогын баримт бичигт туссан зорилтын биелэлт
Хүснэгт 4	Бусад орны Чихэрлэг бүтээгдэхүүн болон давсны хэрэглээг бууруулах талаар төрөөс хэрэгжүүлсэн бодлого, түүний үр дүн
Хүснэгт 5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын чиглэл, ТАХ-ны тоо
Хүснэгт 6	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
Хүснэгт 7	“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хийсэн үнэлгээ
Хүснэгт 8	Хүнсний аюулгүй байдлын шинжилгээ хийж буй лабораториудын чиг үүрэг

Хүснэгт 9	Гаалийн Төв болон салбар лабораториуд, Мал эмнэлгийн сүлжээ лабораториудад улсын төсвөөс болон АХБ-ны санхүүжилтээр хийсэн хөрөнгө оруулалтын дүн /сая төгрөгөөр/
Хүснэгт 10	ХАБҮЛЛ-ийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон багаж, тоног төхөөрөмж, шинжилгээний үзүүлэлтүүд
Хүснэгт 11	Мал эмнэлгийн салбарт ашиглаж буй цахим систем
Хүснэгт 12	Дархлаажуулалтын зардал 2022-2023 он
Хүснэгт 13	2022-2024 онд малын бруцеллёз өвчнөөс сэргийлэх вакцинд хамрагдсан малын тоо, улсын төсвөөс зарцуулсан зардал
Хүснэгт 14	Малын бруцеллёз өвчний эсрэг дархлаажуулалтын дараах үр дүнд хийсэн тандалт судалгааны дүн. УМЭАЦТЛ, 2024 он
Хүснэгт 15	Худалдан авалтын мэдээлэл
Хүснэгт 16	Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын (CAIS) автомат системийн төлөв
Хүснэгт 17	Импортийн хүнсний өөрчлөлт /2022-2024 он/
Хүснэгт 18	Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хяналт шалгалтад хамрагдсан тоон үзүүлэлт. 2022-2024 он
Хүснэгт 19	Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хяналт шалгалтаар илрүүлсэн, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний шийдвэрлэлт. 2022-2024 он

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Дүрслэл 1	Хүнсний аюулгүй байдлыг хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын бүтэц чиг үүрэг

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, МУЕА-ын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудит хийв. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөр түүний хэрэгжилт үр дүнтэй эсэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хянах тогтолцоо, бүтэц чиг үүрэг оновчтой бөгөөд хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж байгаа төрийн тусгай болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллага, бүх шатны төрийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч байгууллага, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулсан. Үүнд:

- ХХААХҮЯ, Салбарын хяналтын газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Хөдөө, аж ахуйн газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, сүлжээ лаборатори;
- Эрүүл мэндийн яам, Салбарын хяналтын газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв;
- Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Хилийн боомтууд дахь гаалийн газар, Гаалийн төв лаборатори, сүлжээ лабораториуд;
- Үндэсний итгэмжлэлийн төв,
- Стандарт хэмжил зүйн газар, ХАБҮЛЛ;

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашигласан.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас

гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Хууль:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль;
- Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль;
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл ахуйн тухай хууль;
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай;
- Гаалийн тухай;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай
- Бусад холбогдох хуулиуд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Баттулга хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Энх-Амгалан, Б.Мөнхцэцэг, аудитор М.Минжин, Б.Очмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын бодлого эрх зүйн орчин нь УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл арга хэмжээ, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, УИХ-ын 2022 оны 36 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол болон хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад хууль, эрх зүйн актууд хэрэгжиж байна.

Монгол Улсын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ 2024 онд дотоодын үйлдвэрлэлээр 52.3 хувийг, импортоор 48.3 хувийг хангаж, дотоодын үйлдвэрлэлээс хангасан хувь нь 0.3 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хувь

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2022		2023		2024	
	Дотоодын үйлдвэрлэл	Импорт	Дотоодын үйлдвэрлэл	Импорт	Дотоодын үйлдвэрлэл	Импорт
Мах, махан бүтээгдэхүүн	95.6	4.4	94.1	5.9	90.4	9.6
Малын мах	99.6	0.4	99.3	0.7	98.9	1.1
Загас	0	100	0	100	0.0	100
Шувууны мах	1.6	98.4	0.6	99.4	1.5	98.5
Сүү	99.9	0.1	99.8	0.2	99.8	0.2
Сүүн бүтээгдэхүүн	52.2	47.8	51.2	48.8	58.2	41.8
Гурил, гурилан бүтээгдэхүүн	87.4	12.6	82.1	17.9	59.1	40.9
Гурил	98.8	1.2	91.2	8.8	58.3	41.7
Гурилан бүтээгдэхүүн	67.6	32.4	67.3	32.7	60.6	39.4
Төрөл бүрийн будаа	0	100	0	100	0.0	100
Төмс	96.2	3.8	95.9	4.1	95.9	4.1
Хүнсний ногоо	63.1	36.9	63.3	36.7	66.3	33.7
Буурцагт ургамал	100	0	51.2	48.8	99.98	0.02
Жимс, жимсгэнэ	3.2	96.8	3.7	96.3	2.9	97.1
Өндөг	55.6	44.4	59.2	40.8	70.6	29.4
Ургамлын тос	0	100	5.2	94.8	11.9	98.1
Цөцгийн тос, 72% тослогтой	3.9	96.1	3.3	96.7	2.8	97.2
Сахар, чихрийн зүйл	61.1	38.9	67	33	64.1	35.9
Дундаж хувь	54.7	45.2	52.0	48.1	52.3	48.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бүтээгдэхүүнүүд 2024 оны байдлаар малын махны хангамж 98.9%, мах махан бүтээгдэхүүн 90.4, сүүний хангамж 99.8%, гурилын хангамж 58.3%, төмсний хангамж 95.9%, гурил, гурилан бүтээгдэхүүний хангамж 59.1%, өндөгний хангамж 70.6%-ийг тус тус хангаж байна.

Импортоор загасыг 100%, төрөл бүрийн будаа 100%, шувууны мах 98.5%, жимс жимсгэнэ 97.1%, ургамлын тос 98.1%, цөцгийн тос 72% тослогтой 97.2%-ийг тус тус хангаж, импортын хамаарлын түвшин нийт 48.3% буюу “Хүнсний бие даасан байдал алдагдсан” хэвээр байна.

Хөдөөгийн хүн ам улсын дунджаас сүүн бүтээгдэхүүн 156.6 грамм, малын мах 116.2 грамм, гурил 107.2 грамм, сүү 46.1 грамм, төрөл бүрийн будаа 20.8 грамм, ургамлын тос 9.3 граммаар илүү хэрэглээтэй байна.

Хотын хүн ам улсын дунджаас гурилан бүтээгдэхүүн 23.3 грамм, хүнсний ногоо 8.1 грамм, өндөг 5.2 грамм, жимс, жимсгэнэ 4.4 грамм, шувууны мах 2.8 грамм, төмс 2.2 грамм, сахар чихрийн зүйл 1.4 грамм, цөцгийн тос 1.2 грамм, загас 0.1 грамм, буурцагт ургамал 0.1 граммаар илүү хэрэглэдэг байна.

УИХ-ын 2022 оны 36 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, хангамжийг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор баталсан ч импортын хамаарал 2023 онд 2.9 хувиар өссөн, дотоодын хангамж, үйлдвэрлэлийн өсөлт хангалтгүй байна.

Хүснэгт 2. Гол нэрийн зарим барааны дундаж үнэ /Улаанбаатар хот/

№	Барааны бүлэг	Барааны нэр	Улаанбаатар хот /дунджаар/			Өсөлт
			2022	2023	2024 /8 сарын байдлаар/	Үнийн харьцуулалт 2023-2024 /төгрөгөөр/
1	Гурил, гурилан бүтээгдэхүүн	Гурил, 1-р зэрэг	2,146	2,598	-	+452
2		Гурил, 2-р зэрэг	1,340	1,642	-	+302
3		Талх 600 гр	2,530	2,864	2,514	-350
4	Мах, махан бүтээгдэхүүн	Тахианы гуя, кг	11,399	10,753	9,554	-1,199
5		Үхрийн мах, цул гуя, кг	15,223	17,431	19,916	+2,485
6		Хонины мах, цул гуя, кг	11,867	14,062	15,655	+1,593
7	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Сүү, 500 гр	2,139	2,353	2,375	+22
8		Сүү хайрцагтай, 1 л	4,096	4,581	4,752	+171
9		Тараг, 900 гр	3,867	4,277	4,310	+33
10	Хүнсний ногоо	Амтат чинжүү, 1 кг	9,639	8,254	8,306	+52
11		Байцаа, 1 кг	2,084	1,874	2,101	+227
12		Төмс, 1 кг	1,492	1,666	2,267	+601
13		Хятад сонгино	3,101	2,933	2,857	-76

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх судалгаанаас харахад хүнсний бүтээгдэхүүний 2022-2024 онд дотоодын үйлдвэрлэлээр хангаж буй хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ нэмэгдсэн, харин импортоор нийлүүлэгдэж буй хүнсний бүтээгдэхүүний үнэ буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь дотоодын үйлдвэрлэлийн өртөг, үр ашиг, үнийн тогтвортой байдал хангалтгүй, салбарын бодлого, дэмжлэг үр нөлөөгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Богино болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын зорилт, арга хэмжээ уялдаагүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нарийвчлан тусгаагүй байна.

1.1.1 Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Улсын Их Хурлаас богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг салбарын яамд, Засгийн газарт даалгасан байна. Үүнд:

- Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол/
- “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл /УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол/
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол/
- Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, 2022-2024 он
- Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай /УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол/

1.1.2 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Хүнсний аюулгүй байдлыг хангах арга замыг тодорхойлж, “Алсын хараа- 2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тус тус хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зарим зорилт, арга хэмжээг тусгаж ирсэн байна.

Хүснэгт 3. Бодлогын баримт бичигт туссан зорилтын биелэлт

№	Бодлогын баримт бичиг	ТАХ-ны тоо	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Ү/Б	Үнэлгээний дундаж хувь
			100	70-100	30-70	0-30		
1	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	6	1	4	1			71.7
2	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	20	2	7	6	3	2	57.9
3	Монгол Улсын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	6	2	3		1		69.3
4	Монгол Улсын 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	6	3	2	1			85
5	Монгол Улсын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	8	2	4	1	1		72.2
Нийт		46	10	20	9	5	2	71.28

Эх сурвалж: УАГ-ын аудитын тайлан

1.1.3 Дээрх бодлогын баримт бичгүүдийн дараах зорилт арга хэмжээ хэрэгжээгүй, үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

- МУЗГҮАХХАХТ-ийн “Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” /3.3.3.2/ , “Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад

хүлээн зөвшөөрүүлнэ”/3.3.3.6/, “Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчилнэ” /3.3.8.1/

- МУХЖТ-ний “Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ”/2022 оны 3.3.14/, “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад ҮТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих” /2024 оны 5.1.1.2/

1.1.4 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд туссан “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана”, МУЗГҮАХХАХТ болон МУХЖТ-д туссан дараах хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.Тухайлбал;

- Өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйнууд байгуулж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг бууруулна /МУЗГҮАХХАХТ 3.3.1.5/
- Махны нөөц бүрдүүлнэ /МУЗГҮАХХАХТ 3.3.3.1/
- Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлнэ /МУЗГҮАХХАХТ 3.3.3.6/
- Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулна /МУЗГҮАХХАХТ 3.3.3.9/
- Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй, тайван байдлыг ДМАЭМБ-аар баталгаажуулна /МУЗГҮАХХАХТ 3.3.8.7/
- Шүлхий өвчингүй, тайван байдлыг баталгаажуулна /МУЗГҮАХХАХТ 3.3.8.8/
- Дотоодын мах, сүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэх (Нөөцөлж, борлуулах махны хэмжээ, мянган тонн) /МУХЖТ 2023 оны 2.5.2.3/
- Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй, тайван байдлыг ДМА ЭМБ-аар баталгаажуулах /МУХЖТ 2024 оны 1.3.2.2/

1.1.5 Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 469 дүгээр "Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх тухай" тогтоол батлагдсантай холбогдуулан хариуцан хэрэгжүүлэх байгууллага татан буугдаж дараах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнаагүй байна.

- Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. /МУЗГҮАХХАХТ 4.3.13.1, МУХЖТ 2022 оны 4.3.15/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлж Хүнсний аюулгүй байдлыг хангуулна” /МУЗГҮАХХАХТ 4.3.13.2, МУХЖТ 2022 оны 4.3.16/

1.1.6 “Алсын хараа-2050”-ын 2.5.17¹-т хилээр нэвтрүүлэх импортын хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулахаар тусгасан ч Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор худалдааг хөнгөвчлөх, гааль, хилийн хяналт шалгалтыг бууруулах импортын барааны нэвтрүүлэлтийг нэмэгдүүлэхээр заасан нь бодлогын уялдаа, нийцлийг хангаагүй байна. Тухайлбал:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 178 дугаар тогтоолын 3-т Гааль, хилийн мэргэжлийн хяналт, шалгалтыг багасгах, зарцуулах зардал, цаг хугацааг бууруулах, олон улсын жишигт нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ГЕГ-т даалгасан байна.
- Монгол Улсын Төсвийн тухай хуулийн ТЕЗ нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 22.2.9-д Худалдааг хөнгөвчилж гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг 5 хувиар бууруулахаар баталсан байна.

¹ Импортын хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэх, хяналтын лабораторийг байгуулж, чадавхжуулах, бүртгэлийн хяналтыг чангатгана.

1.1.7 Мөн “Алсын хараа-2050”-ын 2.5.14²-т илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг хязгаарлахаар тусгасан ч ХХААХҮЯ сахар, чихрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дотоодын хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны банкуудад хүүгийн хөнгөлөлттэй зээл олгож, тухайн чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлж бодлогын уялдааг хангахгүй нөхцлийг бүрдүүлсэн байна.

- УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын 5.4.4-т “Элсэн чихрийн боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх” арга хэмжээ тусгагдсан боловч чихрийн манжин тариалах, түүнийг боловсруулах замаар элсэн чихрийн үйлдвэр байгуулах ажил 2025 оны байдлаар огт хэрэгжээгүй байна. Харин энэхүү зорилтот ажлын оронд чихрийн төрлийн ундаа болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг зарим аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгосны үр дүнд чихрийн зүйлсийн үйлдвэрлэл 71 хувиар, импорт 13 хувиар тус тус өссөн байна.

1.1.8 Тус бодлогыг хэрэгжүүлснээр чихэрлэг бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх нөхцөл бий болж, чихрийн хэрэглээг бууруулах бодлогын арга хэмжээг татварын бодлогоор хязгаарлаагүй байна. Мөн хэрэгжүүлсэн арга хэмжээ нь элсэн чихэр боловсруулах дотоодын үйлдвэр байгуулахад чиглээгүй, үр дүнтэй арга хэмжээ хэрэгжээгүй тул Монгол Улс элсэн чихрийн түүхий эдийн хангамжийн хувьд импортын хамааралтай хэвээр байна.

1.1.9 Төрөөс баримталж буй урт хугацааны бодлогын арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал: Мексик, Чили, Их Британи зэрэг улсууд сахар, транс тос агуулсан бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байна.

Хүснэгт 4. Бусад орны Чихэрлэг бүтээгдэхүүн болон давсны хэрэглээг бууруулах талаар төрөөс хэрэгжүүлсэн бодлого, түүний үр дүн

Мексик Чихэрлэг ундааны татвар (2014)	Чили Чихэрлэг бүтээгдэхүүнд татвар (2014)	Их Британи Давсны хэрэглээг бууруулах хөтөлбөр (2003 оноос)
-Чихэрлэг ундаанд нэг литр тутамд нэг песогийн татвар ногдуулсан. -Нэг жилийн хугацаанд хэрэглээ дунджаар 6%-аар буурсан ³ .	-Чихэрлэг ундаанд татвар ногдуулсны үр дүнд борлуулалт 3.4%-иар буурсан ⁴ .	-Үйлдвэрлэгчдийн сайн дурын оролцоонд үндэслэн давсны хэрэглээг 15%-аар бууруулсан. -Цусны даралт буурч, зүрх судасны өвчлөл буурсан статистик бүртгэгдсэн ⁵ .

1.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримталж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, үндсэн зорилгодоо хүрээгүй байна.

1.2.1 Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор хүнсний хангамжийг тогтвортой байлгах, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд төрөөс тодорхой бодлогын арга хэмжээ авах зорилгоор “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан байна.

- *Хүнсний хангамж: Чанарын шаардлага хангасан дотоодын үйлдвэрийн болон импортын хүнс улсын түвшинд хангалттай тоо хэмжээгээр хүн амын хүнсний хангамжийг бүрдүүлэх хэмжээнд бэлтгэгдсэн байхыг;*
- *Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал: Хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын эрүүл ахуйн баталгаат байдлыг хангахыг хэлнэ.*

² Илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг татварын бодлогоор хязгаарлах, хүнсний аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх

³ UNC Gillings School of Global Public Health <https://sph.unc.edu>

⁴ National Institutes of Health (NIH) <https://pmc.ncbi.nlm.nih.gov>

⁵ National Institutes of Health <https://pmc.ncbi.nlm.nih.gov>

1.2.2 Тус тогтоолыг 2022-2026 онд 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр 5 тэргүүлэх чиглэл, 41 үйл ажиллагааг 1,749.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 60 төсөл арга хэмжээ, санхүүжилтгүй 50 төсөл арга хэмжээ, нийт 114 төсөл арга хэмжээг 40 гаруй байгууллага дангаар болон хамтран хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 5. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын чиглэл, ТАХ-ны тоо

№	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээний тоо	Төсөвгүй ажил	Төсөвтэй ажил	Мөнгөн дүн /сая. төгрөг/
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр	18	18	0	-
2	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:	17	10	7	7,900.0
3	Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр	25	4	21	1,022,278.0
4	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр	21	4	17	478,000.0
5	Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр	33	18	15	241,750.0
Нийт		114	54	60	1,749,928.0

1.2.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/61 дүгээр тушаалаар Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1⁶-д заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тогтоолын арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө баталсан байна.

1.2.4 Тус төлөвлөгөө нь ерөнхий тогтоолоос хэт өндөр, шалгуур үзүүлэлт, үндсэн хүрэх түвшинтэй уялдаагүйгээс хэрэгжилт бодит үр дүнд хүрээгүй, хамтран хэрэгжүүлэхээр туссан байгууллагууд хоорондын уялдаа, хэрэгжилтийг хангаагүй байна. Тухайлбал:

- УИХ-ын 36 дугаар тогтоолын 4.6.4 Вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох ТАХ-д Нийт 330 сумын мал эмнэлгийн тасгийг 2024 он гэхэд 50 хувийг, 2026 он гэхэд 100 хувь вакцины хөргүүртэй болгосон байхаар тусгасан байна. ХХААХҮЯ-ны баталсан нарийвчилсан төлөвлөгөөнд тус ТАХ-г хэрэгжүүлэхдээ “2023 онд 330 сумын МЭТ-т вакцин оношлуур хадгалах хөргөгч 1000 тонны МЭҮН-д машины хөргүүр нийлүүлэх”, “2024 онд Вакцин оношлуур тээвэрлэх зориулалтын автомашин төвийн түвшинд 2, 13 аймагт нийлүүлэх”, “2025 онд Вакцин оношлуур тээвэрлэх зориулалтын автомашин 9 аймагт, 21 аймгийн вакцин хадгалах хөргүүр шинээр барих”, “2026 онд Хүн ам олноор төвлөрсөн УБ хот, Орхон, Дархан-Уул аймаг, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ-ь сорьц, дээж хадгалах зориулалт бүхий гүн хөлдөөгч 8 ширхэг нийлүүлэх” гэж 36 дугаар тогтоолын хүрэх түвшинээс зөрүүтэй төлөвлөсөн бөгөөд бодит байдалд 13 сумыг зөвхөн зөөврийн хөргүүрээр хангасан байна.

1.2.5 Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэх 114 төсөл арга хэмжээнээс 2024 онд хэрэгжүүлж, үр дүнг тооцох 31 төсөл арга хэмжээ байгаагаас дараах үр дүнтэй байна. /Хавсралт 1/

Хүснэгт 6. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол

Д/Д	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээний тоо	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дүнгүй /0-30/	Үнэлгээ ний дундаж хувь
-----	------------------------	--------------------	-----------------	----------------------------------	----------------------------------	------------------	-------------------------

⁶ 7.1.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр	18	3	1	11	3	47.7
2	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр	1	1				100
3	Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр	2			2		30
4	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр	3			2	1	21.1
5	Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр	7	1	3	3		62.8
	Нийт	31	6	4	17	4	49.1

Эх сурвалж: Аудитын дүн

1.2.6 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 4 эрх зүйн баримт бичиг батлагдсан байна. Үүнд:

1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлаар;
2. Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан;
3. "Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/165 дугаар тушаалаар;
4. "Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам"-ын төслийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Журам батлах тухай" 344 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан байна.

1.2.7 Бусад 14 эрх зүйн баримт бичгийг батлаагүй үзэл баримтлал, хууль, журмын төслийг боловсруулах ажил хэрэгжээгүй байгаа нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, зохицуулалт хангалтгүй байна.

1.3 УИХ-ын 36 дугаар тогтоолын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тогтоогоогүйгээс зорилт арга хэмжээний хэрэгжилт тодорхойгүй байна.

1.3.1 Тус тогтоолыг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр баталсан ч суурь үзүүлэлт, хүрэх түвшинг он тус бүрээр нарийвчилж бодитой тусгаагүй нь тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байна. Тухайлбал:

- Нийслэл, 21 аймаг тус бүрд 500-2500 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны бүрэн автомат, механикжсан агуулах 4 жилийн хугацаанд байгуулахаар тусгасан боловч жил тус бүрээр тоон үзүүлэлт, хүрэх түвшнийг батлаагүйгээс хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжгүй,
- "Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх" /лаборатори/ арга хэмжээний хүрэх түвшнийг хэт ерөнхий байдлаар тодорхойлж хүний нөөцийн чадавхад гарсан өөрчлөлтийг хэмжих тодорхой шалгуур үзүүлэлтгүй байгаагаас үнэлэх боломжгүй байна.

1.3.2 Тогтоолыг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөсөн боловч 2027 онд дуусах 31, 2028 онд дуусах 2 ТАХ байгаа нь хүрэх үр дүн, хэрэгжүүлэх ажил тодорхойгүй байна.

1.4 Хүнсний аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ нотлох баримтад үндэслээгүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг бүрэн хийгээгүй, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

1.4.1 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолыг Хүнсний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага 2022-2025 оны хугацаанд 2 удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Хүснэгт 7. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хийсэн үнэлгээ

Ангилал	2023 оны 06 дугаар сар		2025 оны 03 дугаар сар	
	Арга хэмжээний тоо	Нийт арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Нийт арга хэмжээ
Арга хэмжээ бүрэн хэрэгжсэн /100%/	8	7%	48	43.2%
Арга хэмжээ хэрэгжих шатанд /70%/	28	24.6%	36	32.4%
Арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй /30%/	68	59.6%	24	21.6%
Арга хэмжээ хэрэгжээгүй /0%/	7	6%	3	2.7%
Хугацаа болоогүй			3	-
Дүн	114	43.8%	114	72.4%

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын тайлан

1.4.2 ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолын 2⁷, 5.2.3⁸, 5.2.4⁹-т тус тус заасан ХШҮ-ний журмыг батлаагүй, нотлох баримтад үндэслээгүй, мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгаагүй байгаа нь бодитой үнэлгээ болоогүй байна.

1.4.3 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” гэсэн тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг “Хүнсний аюулгүй байдлын индекс”-ийн үзүүлэлтээр үр дүнг тооцохоор баталсан ч манай улсад Хүнсний аюулгүй байдлын индекс тооцох аргачлал байхгүйгээс дээрх үр дүнг тооцох, үнэлэх боломжгүй байна. ХХААХҮЯ уг аргачлалын саналыг боловсруулан ҮСХ-нд хүргүүлэн батлуулах шаардлагатай байна¹⁰.

1.4.4 Тогтоолд туссан зарим ТАХ-ны үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын оролцоо тодорхойгүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл бүрэн бус, үр дүнг нэгтгэн тайлагнаагүй нь хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.

1.5 Хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах чиг үүрэгтэй байгууллагуудын зарим чиг үүрэг давхардсан, хоорондын уялдаа холбоогүй, хуульд заасан эрх зүйн актыг одоог хүртэл батлаагүй байна.

1.5.1 Монгол Улсад хүнсний аюулгүй байдлыг хянах чиг үүргийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын чиг үүргийг тодорхойлж харилцааг зохицуулсан.

1.5.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн баримт бичгүүдээр уг тогтолцоонд оролцогч байгууллагууд болох Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори болон сүлжээ лабораторийн чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлсон байна.

1.5.3 ХБАБТХ-ийн 18.1¹¹ дүгээр зүйлд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавих төрийн чиг үүргийг Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр хуульчилсан боловч тус чиг үүргийг Эрүүл мэндийн асуудал

⁷ “Энэ журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

⁸ “хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах”

⁹ тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах

¹⁰ Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл аудитын тайлан


¹¹ Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд дараах байдлаар хяналт тавина:

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл ахуй халдвар хамгаалалтын хяналтыг хэрэгжүүлэхдээ хяналт шалгалтын давхардал үүсгэсэн байна. Тухайлбал:

- ЭМС-ын 2025 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан 10.11.2 кодтой “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудсаар ижил төрлийн хяналт шалгалт хийх зохицуулалт давхардаж, чиг үүргийн уялдаа холбоо алдагдсан байна. Тус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт, үйлдвэрийн барилга байгууламжид тавих шаардлага болон ХБАБХтХ-ийн 10.1, ХтХ-ийн 10 дугаар зүйлд заасан “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага болон ХБАБХтХ-ийн 18.1.2-т заасан хяналт шалгалт хийх үндэслэл, чиг үүргийн давхардал үүссэн байна.

1.5.4 Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын бүтцийг зургаар харуулбал:

Дүрслэл 1. Хүнсний аюулгүй байдлыг хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын бүтэц чиг үүрэг



1.5.5 Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 4, 5 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжүүлсэн байна.

1.5.6 Гаалийн тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 269¹ дүгээр зүйлийн 269^{1.11} “улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх” заалт орсноор хилийн мэргэжлийн хяналтын чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэн байна.

1.5.7 Тус зохицуулалтын дагуу улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслээр дамжин ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хортон шавж, хог ургамал, мэрэгч амьтан, мал, амьтны гоц халдварт өвчин хил дамжин тархахаас сэргийлэх, эрүүл ахуй, чанарын тохирол, бүтээгдэхүүний стандарт шаардлагыг хангуулахаар хорио цээрийн хяналт шалгалтыг Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хэлтэс удирдан зохион байгуулж хэрэгжүүлж байна.

1.5.8 Гаалийн тухай хуульд нэмэлт орсонтой холбогдуулан 12 хуульд, тухайлбал төрийн хяналт шалгалт, хилийн аюулгүй байдал, хорио цээр, стандарт, мансууруулах бодис, ургамал, амьтны эрүүл мэнд зэрэгтэй холбоотой хуулиудад холбогдох заалтуудыг шинэчлэн найруулсан байна.

1.5.9 ГЕГ-ын даргын 2022 оны А/19 тоот тушаалаар “Улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хэрэгжүүлэх түр заавар”-ыг, 34-р тушаалаар “Эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас болон хяналтын хуудасны загварыг түр баталсан байна.

1.5.10 ГЕГ-ын даргын 2023 оны А/300 тоот тушаалаар “Экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянаж шийдвэрлэх журам”, “Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл олгох боомтын жагсаалт”-ыг батлуулсан.

1.5.11 Харин Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тарифын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “хорио цээрийн хяналтын бүлэг”-ийг боловсруулсан боловч тус хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулаагүй, хорио цээрийн хяналтыг зохицуулсан заалтууд хуульд тусгагдаагүй байна.

1.5.12 Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлд¹² хүнсний аюулгүй байдлын талаар тодорхойлж мөн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргах журмыг тус тус хуульчилсан.

1.5.13 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5¹³-д Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг зохицуулсан журмыг батлахаар заасан ба журмыг ХХААХҮС-ын 2016 оны А/37 дугаар тушаалаар хүчингүй болгосон ч одоог хүртэл шинэчлэн батлаагүй байна.

1.5.14 ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д заасан “Хяналтын байгууллага энэ хуулийн 8.2-т заасны дагуу татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ” гэж заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй, мэдээллийн сан бүрдүүлээгүй, нийтэд мэдээлээгүй байна.

1.5.15 Эрүүл мэндийн яам Хүнсний тухай хуулийн 9.1.3-т зааснаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журам” батлах үүрэгтэй боловч өнөөг хүртэл батлаагүй байна.

1.6 Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, салбар хоорондын уялдаа, хяналт-шинжилгээний тогтолцоо сул байна.

1.6.1 Монгол улсад хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий төр хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл Засгийн газрын газрын дэргэд ажиллаж байна. Хүнсний тухай хуулийн 18 дугаар зүйлд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргаж, тэдгээрийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

¹² 3.1.2.“хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг;

¹³ “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

- Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- Хүнсний аюулгүй байдлын талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлж, чиглэл өгөх;
- Хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар жил бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;
- Хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын талаарх тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах.

1.6.2 Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл нь хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шийдвэр гаргах, төрийн захиргааны төв байгууллагуудад зөвлөмж, чиглэл өгөх үүрэгтэй боловч Хүнсний тухай хуулийн 6.7¹⁴, Зөвлөлийн дүрмийн 3.1.5¹⁵-т заасны дагуу зөвхөн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож байна.

1.6.3 Тус зөвлөл нь 2021-2024 онд нийт 14 удаа хуралдаж, зөвхөн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг хэлэлцэж 15 зөвлөмж гаргасан байна.

1.6.4 Хүнсний тухай хуулийн 18.3¹⁶-т заасан мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн багийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дэргэд байгуулаагүй байна.

1.6.5 Мөн Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрмийн 3-т заасан дараах ажлуудыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- 3.1.1. олон улсын хүнсний хангамж, үнийн өсөлт, дотоодын хүнсний аюулгүй байдлын өнөөгийн байдал, цаашдын төлөвийг хүн амын өсөлт, эрүүл мэндийн үзүүлэлт, насны бүлэг бүрийн хоол тэжээлийн байдал, өрхийн орлого, хүнсний хэрэглээний бүтэц, зардал зэрэгтэй уялдуулсан хүнсний хангамж, хүртээмжийн талаархи судалгаа захиалж гүйцэтгүүлэн хэлэлцэж Үндэсний зөвлөлийн зөвлөмж гаргаж, холбогдох яам, байгууллагад хүргүүлэн бодлого, үйл ажиллагааг уялдуулах;
- 3.1.2. хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд эрсдэл үүссэн тохиолдолд холбогдох асуудлыг яаралтай хэлэлцэн шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар холбогдох яам, байгууллагад чиглэл өгөх;
- 3.1.3. хүн амын нягтаршил ихтэй хот, суурин газрын ойролцоо хөгжүүлэх эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хүнс, хоол үйлдвэрлэлийн хөгжлийн төлөвлөлт, зориулалтын тээврийн хэрэгсэл, агуулах, зоорийн хангамж, хүртээмжтэй холбоотой асуудлын талаар хэлэлцэн, зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх;
- 3.1.4. хүн амын дунд хүнснээс шалтгаалах халдварт бус болон хоол хүнсээр дамжих өвчин, хүнсний бохирдол, нөлөөллийн хүчин зүйлс, эрсдэлийн талаархи судалгаа захиалгаар гүйцэтгүүлж, дүнг хэлэлцэн зөвлөмж гарган хэрэгжүүлэх;

1.6.6 Засгийн газрын 2013 оны 78 дугаар тогтоолоор “Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолын 34 дүгээр хавсралтаар үндэсний зөвлөлийг 20 хүний бүрэлдэхүүнтэй байхаар шинэчлэн, үндэсний зөвлөлийн даргаар Ерөнхий сайд, дэд даргаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд байхаар баталжээ.

1.7 Кодексын үндэсний зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас олон улсын хүнсний стандартыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажил удаашралтай байна.

¹⁴ Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно.

¹⁵ тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг хэлэлцэж Үндэсний зөвлөлийн зөвлөмж гаргах

¹⁶ Үндэсний зөвлөл нь мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн багтай байж болно

1.7.1 Кодексын үндэсний зөвлөл нь хүнсний салбарын хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох чиглэлээр Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хороог төлөөлөн ажиллах чиг үүрэгтэй.

1.7.2 Монгол улс Олон улсын Хүнсний хууль эрх зүйн хорооны гишүүн орноор элсэж 2004 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй “Кодексын үндэсний баг”-ийг томилж тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 удаа шинэчлэн баталжээ.

- *ҮХААЯ-ны ТНБД-ын 2013 оны Б/50 дугаар тушаалаар тус зөвлөлийн Зохицуулагчийг томилсон боловч томилсон ажилтан нь өөрчлөгдөж, хариуцах хүнгүй болсон;*
- *ҮХААЯ-ны ТНБД-ын 2013 оны А/92 дугаар тушаалаар тус зөвлөлийн орон тооны бус нарийн бичгийн дарга нарыг томилсон боловч зохицуулагч байхгүйгээс холбогдох байгууллагуудад томилогдсон орон тооны бус нарийн бичгийн дарга нар ажиллах эсэх нь тодорхойгүй болсон;*
- *ХХААС-ын 2016 оны А/77 дугаар тушаалаар тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан боловч үйл ажиллагаа явуулаагүй;*
- *ХХААХҮС-ын 2018 оны А/151 дүгээр тушаалаар тус зөвлөлийг 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, үндэсний зохицуулагчаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, нарийн бичгийн даргаар тус яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжлийн бус буюу физикч мэргэжилтэй хүн байснаас шалтгаалан ажлууд үр дүнд хүрээгүй,*
- *ХХААХҮС-ын 2022 оны А/100 дугаар тушаалаар тус зөвлөлийг Засгийн газрын холбогдох яамд, шинжлэх ухааны болон бусад байгууллага, хүнсний судалгаа, хөгжлийн зэрэг 16 байгууллагын төлөөлөл болох 21 хүн, 4 нарийн бичгийн дарга, нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй байхаар шинэчлэн баталсан.*

1.7.3 ХХААХҮС-ын 2022 оны А/100 дугаар тушаалаар баталсан Кодексын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл, бараа бүтээгдэхүүний Кодексын үндэсний салбар зөвлөлүүд байгуулагдаагүй байна.

1.7.4 Тус зөвлөлийн үйл ажиллагаа нь улсын хэмжээнд хүнсний хууль, эрх зүйн зохицуулалт болон түүний хэрэгжилтийг боловсронгуй болгох замаар хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, экспортод чиглэсэн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мөн импортын хүнсэнд тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэх зорилготой юм.

1.7.5 Уг зорилгын хүрээнд тус зөвлөл нь “Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооны үйл ажиллагааны журам”-д заасан дараах үүргүүдийг хүлээсэн байна.Үүнд:

- *Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооны Нарийн бичгийн дарга нарын газартай нягт хамтран ажиллах, үндэсний ажлын алба, нарийн бичгийн дарга буюу Contact Point-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах;*
- *Зөвлөлийн баримт бичиг, олон улсад хэлэлцэж буй стандартын төсөл, хуралдаанд үндэсний санал боловсруулж, байр суурийг илэрхийлэх, Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хороонд саналаа хүргүүлэх;*
- *Засгийн газарт бодлогын зөвлөгөө өгч, Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооны үйл ажиллагаанд оролцоход тусалцаа үзүүлэх;*
- *Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооноос явуулж буй үйл ажиллагааг өөрийн оронд явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах;*
- *Өөрийн оронд хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчид, хэрэглэгчид болон хуулийн бусад этгээдийн уялдаа, хамтын ажиллагааг зохицуулах;*
- *Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооны гишүүн бусад оронтой харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах;*
- *Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооны хуралд төлөөлөгч оролцуулах асуудлыг зохион байгуулах*
- *Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хороонд мэдээллийн сан ажиллуулах*

1.7.6 Олон улсад Кодексыг үндэсний түвшинд хэрэгжүүлэхдээ бүс нутгаас эрхлэн гаргасан стандартыг үйл ажиллагааны журмын хамт хэрэгжүүлдэг бол Монгол улсад “Кодексын үндэсний зөвлөл болон кодексын зохицуулагч нарт зориулсан Азийн бүсийн удирдамж ”MNS CAC GL 57:2025 стандарт 2025 оны 3 сард шинээр батлагдсан. Тус стандартад заасны дагуу Кодексын үндэсний зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- *Техникийн асуудлыг судлах, хэлэлцэхэд туслах дэд хороодыг байгуулах;*

- ХХААБ/ДЭМБ-ын Хүнсний стандартын нэгдсэн хөтөлбөртэй хамтран ажиллаж, Кодексын хуралд оролцох төлөөлөгчдийг нэр дэвшүүлэх;
- Кодексын баримт бичгүүдийг судалж, технологи, эдийн засаг, эрүүл мэнд, хяналтын тогтолцоотой холбоотой бүх мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийн Кодексын стандартыг хүлээн зөвшөөрөх үндэслэлийг боловсруулах;
- Засгийн газарт олон улсын хүнсний стандартыг хүлээн зөвшөөрөх арга замыг, мөн байгууллагуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааг зөвлөх;
- Хүнсний стандарттай холбоотой үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын бусад байгууллагатай хамтран ажиллах;
- Засгийн газраас хариуцуулсан болон холбогдох бусад ажил.

1.7.7 Кодексын үндэсний зохицуулагчаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга томилогдсон бөгөөд Кодексоос ирсэн албан захидалд хариу бичих, пестицидийн үлдэгдэл, хүнсний бохирдол, малын эмийн үлдэгдэл гэх мэт салбар бүрийн мэргэшсэн байгууллага, мэргэжилтэнд мэдээлэл хүргэх ажил хангалтгүй, одоогоор стандартыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

1.7.8 Олон улсад хүнсний аюулгүй байдлыг хангахдаа Кодексын стандарт, зөвлөмжийг үндэсний хэмжээнд нутагшуулж, тогтолцоотойгоор хэрэгжүүлдэг. Гэвч Монгол Улсад энэ ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- БНХАУ-д Кодексын үйл ажиллагааг өдөр тутам удирдан зохицуулдаг тусгай хэлтэс, бүтэц зохион байгуулалттайгаар ажилладаг. Тус улс 2009 оноос хойш Кодексын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, пестицидийн үлдэгдэл, хүнсний бохирдол зэрэг асуудлаар бүсийн зохицуулагчаар ажиллаж байна.
- Япон Улсад Кодексын асуудлыг хариуцсан бие даасан алба Хүнс, эрүүл ахуйн яамны дэргэд байршиж, мэдээлэл солилцоо, оролцооны хурд, чанар өндөр түвшинд хэрэгждэг.
- Тайланд Улсад Үндэсний Кодексын хороо болон түүний салбар хороодын дэмжлэгтэйгээр тусгайлсан албан тушаалтан өдөр тутмын зохицуулалт болон олон улсын оролцоог хариуцан ажилладаг.

1.7.9 Кодексын үндэсний зөвлөл нь орон тооны бус бүтэцтэй, өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэргүй, олон улсын стандарт, удирдамжийг нутагшуулах, үндэсний хэмжээнд зохицуулалт хийх чиглэлээр өнөөг хүртэл ямар нэгэн бодит ажил, үр дүн гаргаагүй байгаа нь дараах хүндрэл, саад бэрхшээлийг дагуулсаар байна. Үүнд:

- Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хорооны (Кодексын хорооны) стандарт, удирдамж, зөвлөмж, гарын авлагыг монгол хэлэнд орчуулах, мэргэжлийн түвшинд хянах, үндэсний стандарт болгон батлуулах, хэвлэн түгээх;
- Баталсан стандартыг үндэсний үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, хэрэглээг дэмжих үйл ажиллагаа;
- Олон улсын стандартын төсөлд Монгол Улсын байр суурийг цаг хугацаанд нь бүрдүүлж илэрхийлэх боломжгүй байх зэрэг асуудлууд хэвээр байна.

1.7.10 Зөвлөлийн бүтэц орон тооны бус байдлаар бүрдсэн, өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалт хангалтгүй, эрх зүйн үндэс дутмаг байгаа зэрэг нь энэ байдалд голлон нөлөөлсөн. Мөн тус зөвлөлийн ажиллах дүрэм одоог хүртэл батлагдаагүй нь үндэсний хэмжээнд Кодексын стандартыг хэрэгжүүлэх, зохицуулах суурь нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна.

1.7.11 Тогтолцооны болон санхүүгийн хүндрэлүүд байгаа хэдий ч Монгол Улс анх удаа “Чацарганы тос”-ны кодексын олон улсын стандартыг шинээр боловсруулах санаачилгыг гаргаж, уг ажлыг хэрэгжүүлэх хүрээнд ХХААХҮС-ын 2024 оны А/757 дугаар тушаалаар “Ингэний сүү болон чацарганы тосны кодексын олон улсын стандарт боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулан, үйл ажиллагааны төлөвлөгөөг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан байна.

1.8 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн ажиллах журмыг батлаагүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

1.8.1 Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 18 дугаар хавсралтаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батлахаар заасан боловч тус журмыг батлаагүйгээс зөвлөлийн чиг үүрэг хэрэгжихгүй, нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

1.9 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээг тодорхой хүрээнд тогтоосон хэдий ч олон улсад хянаж, зохицуулдаг зарим бохирдуулагчдыг хянах стандарт, техникийн зохицуулалт байхгүй байна.

1.9.1 Монгол улсад хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийн¹⁷ зөвшөөрөгдөх хэмжээг дараах эрх бүхий байгууллагын баталсан журам, жагсаалтыг үндэслэн мөрдөж байна. Үүнд:

- ЭМС-ын 2014 оны 384 тоот тушаалаар хүнсний бүтээгдэхүүний хими, нян судлал, хүнд металлын аюулгүйн үзүүлэлтүүдийг,
- 2019 оны 200 дугаар тушаалаар “ургамлын эрүүл ахуй, хорио цээр, цацрагийн аюулгүйн үзүүлэлт”-ийг,
- ХХААС-ын 2013 оны А/31 тоот тушаалаар “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-г тус тус баталсан.

1.9.2 Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, органик бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, эмийн бодисын үлдэгдэл, пестицид, орчны бохирдолтой холбоотойгоор болон сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилждэг хортой бодис үзүүлэлтүүдийг зохицуулсан Монгол улсын олон улсын стандартууд шинэчлэгдэх ажил удаашралтай байна.

1.9.3 Үүний улмаас Монгол Улсад хяналт, зохицуулалтгүй бохирдуулагчдыг шинжлэхгүй байх нөхцөл бүрдэж, хүнсний аюулгүй байдлын хяналт, баталгаажуулалтын үр нөлөө буурч байна. Тухайлбал:

- Шингэн хүнс, усны сав, хүүхдийн хооллох хэрэгсэл зэрэг сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилждэг Бисфенол А ба бусад бисфенолууд (BPA/BPS/BPF)-ийн зөвшөөрөгдөх дээд хязгаарыг тогтоогоогүй,
- Хийжүүлсэн ундаа, жимсний ундаа, цайн ундаа, амтлаг усанд агуулагдах хадгалалтыг уртасгах зориулалттай натрийн бензоат (E211), калийн сорбат (E202), чихэр орлуулах зориулалттай ацесульфам калий (E950), аспартам (E951), үл исэлдүүлэх зориулалттай Витамин С (E300)-ийн агууламжийг “Хүнсний нэмэлт MNS CAC 192:2015” стандартад тусгаагүй,
- Кофе, гурилан бүтээгдэхүүн, чипс зэрэг цардуул агуулсан бүтээгдэхүүнүүдийг өндөр температурт шарах, жигнэх, хайрах явцад үүсдэг химийн бохирдуулагч болох акриламид (Acrylamide)-ийг хянах зохицуулалт байхгүй.

1.9.5 Харин Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон олон улсын хүнсний байгууллага /FAO/-аас батлан гаргадаг (Codex Alimentarius Commission – Хүнсний кодексын комисс) CAC 192:2015 стандарт нь хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэж болох нэмэлтүүд, тэдгээрийн технологийн зориулалт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг шинжлэх ухааны судалгаанд үндэслэн зарим хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх дээд хэмжээг бууруулж, хязгаарлаж, эсвэл нэмж бүртгэх зэргээр тогтмол шинэчилж байна.

1.9.6 Мөн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17.2.2 “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох”, 17.2.3 “хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшинг тогтоож, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох,” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.9.7 Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/384 дүгээр тушаалаар баталсан “Хүнсний бүтээгдэхүүний хүнд металлын аюулгүйн үзүүлэлт” нь ОХУ, БНХАУ, Малайз, Унгар, САС, Украин, Канад зэрэг орны стандартыг харьцуулсан хэлбэртэй боловч Монгол Улсад нэг мөр мөрдөх, зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоогоогүй байна. Мөн бохирдуулагчдын нэр төрөл, зөвшөөрөгдөх хэмжээ нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, олон улсын стандарт, зөвлөмжийн түвшинд нийцэхгүй байна.

¹⁷ ХБАБХТХ-ийн 4.1.18 хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт” гэж хүнсэн дэх физик, хими, биологийн бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээг

1.10 Стандартын улсын үзлэгийн зөвлөмжийн үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, хүнсний салбарын стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын 63 хувь нь хэрэгжээгүй байна.

1.10.1 Хүнсний салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үндэсний стандартыг СТЗТҮИтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3¹⁸, 5 дугаар зүйлийн 5.1¹⁹, 5.2²⁰-д тус тус заасны дагуу заавал дагаж мөрдөхөөр хуульчилсан байна. Мөн хуулийн 8 дугаар зүйлд Стандартчиллын баримт бичгийг дараах төрлөөр ангилсан байна. Үүнд:

- *Үндэсний стандарт,*
- *Байгууллагын стандарт,*
- *Олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, түүнд нийцүүлэн гаргасан гадаад улсын стандарт,*
- *Хотын стандарт.*

1.10.2 Улсын хэмжээнд мөрдөгдөж буй стандартын хэрэгжилтэд хяналт хийх зорилгоор 2022 онд хийсэн "Стандартын улсын үзлэг"-ээр хүнсний аюулгүй байдалтай холбоотой нийт 683 стандарт /уснаас бусад/-аас 34% буюу 232 стандартыг шинэчлэх, шинээр батлах болон хүчингүй болгох шаардлагатай гэж дүгнэсэн байна.

1.10.3 Тус дүгнэлтийн дагуу хүчингүйд тооцох 7, шинээр боловсруулах 16, шинэчлэн сайжруулах шаардлагатай 123 стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага одоог хүртэл шийдвэрлээгүй СТЗТҮИтХ-ийн 9.1²¹-д заасныг хэрэгжүүлээгүй тул алдаа, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.10.4 Үндэсний стандартын санд 11.220 кодтой мал эмнэлгийн бүлэгт нийт 17 стандарт бүртгэлтэй байгаагаас 9 нь бүтэц, үйл ажиллагааны, 1 нь өвчний оношилгооны, 3 нь шинжилгээний арга, 4 нь бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагын стандарт байна.

1.10.5 Стандартын улсын үзлэгийн дүгнэлтээр мал эмнэлгийн лавлагаа болон сүлжээ лабораториудад хийдэг шинжилгээний 14 стандартын арга хүчингүй болсон, 28 стандарт аргачлалыг шинэчлэх шаардлагатай талаар зөвлөмж хүргүүлсэн боловч одоог хүртэл шинэчилж батлуулаагүй, хүчингүй болсон стандарт аргачлалаар шинжилгээ хийж байна.

1.10.6 Мөн өвчний оношилгоо, эмийн үлдэгдлийн шинжилгээнд ашиглаж байгаа, шинээр боловсруулсан арга зүйн заавруудыг Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлж батлуулах, мэдээллийн санд бүртгэх ажиллагаа хийгдээгүй байна. Үүний улмаас УМЭАЦТЛ болон Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул аймгийн мал эмнэлгийн сүлжээ лабораториуд хүчингүй болсон стандарт, аргачлалаар шинжилгээ хийж байна.

1.10.7 Үндэсний стандартын цахим сангаас хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан стандартуудыг хасаагүй байгаа нь СТЗТҮИтХ-ийн 9.2-т заасан "Үндэсний стандартын үзүүлэлт, шаардлага нь олон улс, бүс нутгийн стандартын шаардлагад нийцсэн байна" гэснийг зөрчиж байна. Тухайлбал:

- Навчит байцаа MNS MNS 0263:1982, тарвас MNS 0281:1982, Этилийн спирт шинжлэх арга. MNS 0987:1986, Хүнсний бүтээгдэхүүнд зориулсан хуванцар сав MNS 1010:1986 зэрэг хүчинтэй хугацаа дууссан стандартууд байна.

1.10.8 Үндэсний стандартын цахим сангийн мэдээлэлд бүрэн хяналт, үнэлгээ хийгээгүйгээс хуучирсан, хүчингүйд тооцох стандартууд хүчин төгөлдөр хэвээр ашиглагдаж байна. Энэ нь

¹⁸ "техникийн зохицуулалт" гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг"

¹⁹ Техникийн зохицуулалтын зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино

²⁰ Техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөнө

²¹ Үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

стандартыг олон улсын түвшинд нийцүүлэх, хэрэглэгчдийг баталгаатай эх сурвалжаас мэдээлэл авах боломжоор хангах, хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулахад сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд стандарт шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, хугацаа дууссан, хуучирсан стандартуудыг зохих журмын дагуу хүчингүйд тооцох шаардлагатай байна.

1.11 Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоосон стандарт, шинжилгээний аргачлалын стандартууд болон аюулгүйн үзүүлэлтүүд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

1.11.1 Монгол улсад Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/31 дугаар тушаалаар “Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5868:2008” стандартад заасан 167 нэр төрлийн зөвлөмж хэмжээг баталсан.

1.11.2 Харин ЭМС-ын 2014 оны 384 дүгээр тушаалаар “Хүнсний бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлт”-д заасан 21 нэр төрлийн пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоож, 146 нэр төрлийн пестицидийг аюулгүйн үзүүлэлтэд тусгаагүй байна.

1.11.3 Хүнсний ногоон дахь органик фосфат болон карбамат пестицидийн үлдэгдлийг тодорхойлох биологийн хурдавчилсан арга MNS:NY/T 448:2009, MNS:GB/T 5009-199:2009 гэсэн шинжилгээний аргын стандартуудыг мөрдөж байна.

1.11.4 Гэвч дээрх батлагдсан аюулгүйн үзүүлэлтээр цөөн нэр төрлийн пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг хянан зохицуулж, аргачлалын стандарт нь үр дүнгийн нарийвчлал багатай, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Олон улсад хянаж зохицуулж байгаа пестицид төрлийг дурдвал:

- Европын холбоо -670
- ОХУ-571
- БНХАУ -417
- Кодекс алментарус -245
- Монгол Улс -167 нэр төрлийн пестицидын үлдэгдлийг хянах зохицуулалттай.

1.11.5 Улаанбаатар хотын Амгалан, Баялаг-Ундраа, Лавай, Хүчит шонхор зэрэг 6 зах, худалдааны төвд борлуулагдаж байсан жимс, хүнсний ногооны 26 дээжид хурдавчилсан болон баталгаажуулах шинжилгээ хийхэд 44 нэр төрөл /давхардсан тоогоор 96 нэр төрөл/-ийн пестицидийн үлдэгдэл бага агууламжтай буюу зөвшөөрөгдөх хэмжээнд илэрсэн бол саримсанд илэрсэн 11 нэр төрлийн пестицидийн үлдэгдлийн хэмжээ нь Европын холбооны зөвлөмж хэмжээнээс хэтэрсэн байна. Эх сурвалж: /ХАБҮЛЛ-ийн тандалт судалгааны 2024 оны тайлан/

1.11.6 Европын Холбоо алиманд 521 төрлийн пестицидийн үлдэгдлийг хянаж, зохицуулж байхад Монгол Улс MNS 5868:2008 стандартаар 31 буюу 6 хувийг хянаж байгаа нь олон улсын түвшнээс 16 дахин бага байна.

1.11.7 Иймд хүнсний аюулгүй байдлыг хангах, хяналт тавих эрх зүйн орчныг сайжруулах, техникийн зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд хүнсний салбарын стандартыг шинэчлэх, сайжруулах ажлыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

1.12 ХАБ-ийн шинжилгээ хийж буй лабораториуд нь шинжилгээний аргачлал болон багажийн хэрэглээний нийцлийг тогтмол үнэлэх, шинжилгээний арга зүйг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна.

1.12.1 Малын өвчний оношилгоо, мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийх аргачлалын стандартуудыг шинэчлэх, шинээр батлуулах ажил удаашралтай байна.

1.12.2 Стандартын 2022 онд хийсэн үзлэгээр малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд шинжилгээ хийдэг 25 шинжилгээний аргын стандарт хүчингүй болсон ба сүүлийн 3 жилд МЭЭГ, УМЭАЦТЛ-аас стандарт батлуулах, шинэчлэхээр СХЗГ-т санал хүргүүлээгүй байна. Эмийн болон пестицидийн үлдэгдлийн шинжилгээнд 51 нэр төрлийн стандарт ажлын заавар, 120 гаруй нэр төрлийн стандартчилагдсан загвар ашиглан гүйцэтгэж байна.

1.12.3 УМЭАЦТЛ нь малын гаралтай хүнсний түүхий эд, үлдэгдэл бодисын шинжилгээнд ашиглаж буй арга зүй, загвар, шинжилгээний аргачлалуудыг Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулаагүй байна. Үүний улмаас мал эмнэлгийн сүлжээ лабораториудын

шинжилгээний дүнгийн зөрүүтэй байдал үүсэх, ОУ-ын худалдаа, тохирлын баталгаажуулалтын шинжилгээ үр дүн хүлээн зөвшөөрөгдөхгүй байх, лаборатори хоорондын үнэн зөв байдал алдагдах, улмаар итгэмжлэлийн шалгалтын явцад үл тохирол гарах эрсдэл үүсгэж байна.

1.12.4 УИТ нь УМЭАЦТЛ болон МЭ-ийн сүлжээ лабораториудыг итгэмжлэхдээ хүчингүй болсон стандарт аргачлалаар итгэмжилсэн байгаа нь ISO/IEC 17025:2018 стандартын 7.2.1.3-д заасан лаборатори нь тохирохгүй эсвэл боломжгүй байхаас бусад тохиолдолд хамгийн сүүлийн үед батлагдан хэвлэгдсэн, хүчин төгөлдөр стандартыг ашиглах ёстой гэсэн шаардлага нийцээгүй, ХАБ-ийн хяналтын тогтолцоонд шинжилгээний үнэн зөв бодитой байх, иргэдийн лабораторийн үр дүнд итгэх итгэлийг бууруулах сөрөг үр дагавар үүсгэж байна. Тухайлбал:

- Сэлэнгэ аймгийн МЭ-ийн сүлжээ лаборатори нь 2024 оны гуравдугаар сард УИТ-өөс 5 төрлийн хүнсний бүтээгдэхүүнд 21 үзүүлэлтээр, үүнээс аюулгүй байдлын 9 үзүүлэлтээр итгэмжлэгдсэн боловч шинжилгээнд ашиглаж буй аргачлалын ихэнх нь буюу 7 үзүүлэлт нь (77.78%) шаардлага хангахгүй, тайлагналын агуулга стандартын шаардлагыг бүрэн хангаагүй, зарим үзүүлэлтээр шинжилгээ хийгдээгүй, дүгнэлт нь тодорхой бус байгаагаас гадна “25-529” дугаартай ааруулын шинжилгээнд итгэмжлэлийн хүрээнд байхгүй аргачлал ашигласан, “Хүнсэнд тэнцэнэ: сөрөг” гэх мэт ойлгомжгүй дүгнэлт гаргаж байна.

БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ТОГТОЛЦОО БЭХЖЭЭГҮЙ, ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ АЛДАГДСАН БАЙНА.

2.1 Хүнсний чанар, аюулгүй байдлын сорилт, шинжилгээ хийж буй үндэсний лавлагаа лабораториуд хүнсний түүхий, эд бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг бүрэн шинжлэхгүй байна

2.1.1 Монгол улсад хүнсний түүхий, эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулах, магадлах шинжилгээ хийж буй лабораториуд нь бүтээгдэхүүний нэр төрөл, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлон үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 8. Хүнсний аюулгүй байдлын шинжилгээ хийж буй лабораториудын чиг үүрэг

Д/д	Лабораторийн нэр	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хэрэгжилт	Хэрэгжээгүй шалтгаан
1	ХАБҮЛЛ - Аймаг нийслэлийн 23 сүлжээ лаборатори (ХБАБХтХ-ийн 15.2, 15.3)	Бүх төрлийн хүнс, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сав баглаа боодолд чанар, аюулгүй байдлын дээжийн шинжилгээ хийх /Боловсруулаагүй мал, амьтны гаралтай түүхий эдээс бусад/	Батлагдсан аюулгүйн 240 үзүүлэлтээс - ХАБҮЛЛ 80% /192/ - Нийслэлийн лаборатори 45% /108/ - Аймаг, орон нутаггийн сүлжээ лабораториуд -15%-30% /36-72/	Итгэмжлэлийн хүрээнд заагаагүй Тоног төхөөрөмж, хүний нөөц, урвалж оношлуур дутагдалтай
2	УМЭАЦТЛ Аймаг нийслэлийн 23 сүлжээ лаборатори (МАЭМтХ-ийн 29 зүйл, ХБАБХтХ-ийн 15.2)	Бүх төрлийн мал амьтны гаралтай хүнс, хүнсний түүхий эд бүтээгдэхүүнд чанар, аюулгүй байдлын дээжийн шинжилгээ хийх	Батлагдсан 111 үзүүлэлт /хүнд металл, пестицид, эмийн үлдэгдлийн, микотоксин, бичил биетэн, бусад бохирдуулагч/-ээс - УМЭАЦТЛ-60% - Аймаг, нийслэлийн МЭ сүлжээ лабораториуд -15%	Тоног төхөөрөмжийг ашиглаагүй, бүрэн суурилуулаагүй, хүний нөөцийг сургаагүй
3	Гаалийн төв лаборатори , Гаалийн газрын салбар лабораториуд (ГтХ-ийн 252 зүйл)	Импорт, экспортын хүнсний бүтээгдэхүүнд магадлан шинжилгээ хийх	Батлагдсан аюулгүйн 240 үзүүлэлт, + эмийн үлдэгдлийн 53 нэр төрөл, нийт 293 үзүүлэлтээс - Гаалийн төв лаборатори -0% - Замын-үүд дэх ГСЛ -30% - Бусад ГСЛ-0%	Итгэмжлэгдээгүй, тоног төхөөрөмжийг ашиглаагүй, Хүний нөөцийн дутагдалтай, Нян судлалын шинжилгээнд хугацаа их шаарддаг
4	НЭМҮТ – (ХтХ-ийн 9.1.1, НЭМТҮтХ-ийн 5.1.7, 5.5.2 , 5.8)	Хүн амын хоол тэжээлийн зохистой байдлыг тогтоох Хүнсний химийн хордлогын шалтгаан тогтоох Шим тэжээлийн тандалт, судалгаа хийх	Батлагдсан аюулгүйн 240 үзүүлэлтээс НЭМҮТ-ийн Лавлагаа лаборатори -1.6%	Нян судлалын лаборатори итгэмжлэгдээгүй, Лабораторийн байргүй Тоног төхөөрөмж, хүний нөөцийн дутагдалтай

2.1.2 Дээрх лабораториуд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийхдээ эрх бүхий байгууллагаас баталсан аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг бүрэн хамруулахгүй байна.

2.1.3 ЭМС-ын 2014 оны 384 болон 2019 оны А/200 дугаар тушаалаар 240 орчим бохирдуулагчийн жагсаалтыг баталснаас ХАБҮЛЛ нь 192 үзүүлэлтийг шинжлэхээр магадлан итгэмжлэгдсэн байна.

2.1.4 Үүнээс хүнсний бүтээгдэхүүнд аюулгүй байдлын хамгийн олон үзүүлэлт²²-ийг ХАБҮЛЛ шинжлэхээр магадлан итгэмжлэгдсэн боловч батлагдсан үзүүлэлтийн 20 орчим хувийг шинжлэхгүй байна. Тухайлбал,

- Хүнсний бүтээгдэхүүнд шинжилж буй аюулгүйн үзүүлэлтүүдээс нийт үзүүлэлтийн 54% /104/-ийг ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн үзүүлэлтүүд эзэлж, харин хүн амын эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй хүнд металл (10), микотоксин (13), пестицид (21) зэрэг үзүүлэлтүүдийн тоо харьцангуй цөөн байна.

2.1.5 Codex Alimentarius буюу Хүнсний дүрэм-ийн стандарт болон Европын комиссын журам (ЕС No.1881/2006, ЕС No.2073/2005)-д заасан пестицидын үлдэгдэл, малын эмийн үлдэгдэл, мөн сав баглаа боодлоос хүнсэнд шилжих түгээмэл хорт нэгдлүүдийн аюулгүйн үзүүлэлт, зөвлөмж хэмжээ зэрэг бохирдуудалагчдаас 60 хувийг шинжлэхгүй байна.

2.1.6 СХЗГ болон Мал эмнэлгийн харьяа аймаг, орон нутгийн сүлжээ лабораториуд батлагдсан аюулгүйн үзүүлэлтийн 75–85 хувьд шинжилгээ хийж чадахгүй байна.

2.1.7 Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавигдах аюулгүйн үзүүлэлтүүдийн 70 орчим хувийг Замын-Үүд дэх Гаалийн салбар лаборатори шинжилдэггүй, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн салбар лаборатори нь шинжилгээ хийж байгаа ч магадлан итгэмжлэгдээгүй байна.

2.1.8 Мөн Гаалийн төв лаборатори болон Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн салбар лаборатори нь хүнсний бүтээгдэхүүнд аюулгүйн үзүүлэлтээр шинжилгээ хийгээгүй, итгэмжлэгдээгүй, НЭМҮТ-ийн лавлагаа лаборатори нь нян судлалын аюулгүйн үзүүлэлтүүдээр магадлан итгэмжлэгдээгүй байна.

2.2 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг бүрэн хамруулан шинжилгээ хийх талаарх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна

2.2.1 Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний 2022–2024 оны дундаж үзүүлэлтээр жилд ХАБҮЛЛ нь 63,856 сорьцонд 154,778 үзүүлэлт, УМЭАЦТЛ-ийн хүнсний ариун цэвэр, үлдэгдлийн лаборатори нь 6,978 сорьцонд 55,894 үзүүлэлтээр шинжилсэн байна. УМЭАЦТЛ-ийн ХЭАҮШЛ нь 1 сорьцонд ХАБҮЛЛ-иос 3.2 дахин олон үзүүлэлт шинжилсэн боловч эерэг сорьцын илрүүлэлт 2.8 дахин цөөн байна. /Хавсралт 2/

2.2.2 Дээжийн шинжилгээний үзүүлэлтүүд нь тухайн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг үнэлэхэд шаардлагатай техникийн зохицуулалт, үндэсний болон олон улсын стандартад заасан нөхцөл, шаардлагуудыг бүрэн төлөөлж чадахгүй, харьцангуй цөөн үзүүлэлт байна. Тухайлбал: ХАБҮЛЛ нь

- Ундаа, жүүс зэрэг бүтээгдэхүүнд хүнсний нэмэлт, химийн, хүнд металл, хор судлал, нян судлалын чиглэлээр нийтдээ 40 орчим аюулгүйн үзүүлэлтээр шинжилгээ хийх итгэмжлэлтэй ч “Super C” дархлаа дэмжих ундаанд зөвхөн Афлатоксин В1, В2; Витамин С; Salmonella spp; Колититр гэсэн 5 аюулгүйн үзүүлэлтийг шинжилсэн байгаа нь итгэмжлэлд заасан аюулгүйн үзүүлэлтийн 15 хувийг;
- Цагаан будаанд 15 төрлийн пестицид, 6 төрлийн токсин, 4 төрлийн хүнд металлын бохирдол буюу 25 төрлийн аюулгүйн үзүүлэлт, 6 төрлийн чанарын үзүүлэлт нийт 31 төрлийн үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийхээр магадлан итгэмжлэгдсэн боловч аюулгүйн 6 үзүүлэлт буюу хог, ургамал, хорио цээртэй хөнөөлт шавж, хачиг, 4 нэр төрлийн пестицидын үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийсэн байх ба энэ нь итгэмжлэлд заасан аюулгүйн үзүүлэлтийн 19 хувийг хамруулсан байна.

²² Батлагдсан аюулгүйн 240 үзүүлэлтээс 192 үзүүлэлтийг шинжлэхээр магадлан итгэмжлэгдсэн.

2.2.3 Дээрх нөхцөл байдлаар лабораториуд бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийхдээ итгэмжлэлийн хүрээнд заасан аюулгүйн үзүүлэлтийн 15-19 хувийг хамруулан сорилт шинжилгээ хийж байна.

2.2.4 Бүтээгдэхүүний 1 дээжид УМЭАЦТЛ нь ХАБҮЛЛ-той харьцуулахад олон буюу 2-3 төрлийн үзүүлэлт²³ илүү шинжилж байгаа ч илрүүлсэн шаардлага хангаагүй үзүүлэлтүүдийн тоо нь 2.6 дахин бага байна. Эдгээр шинжилсэн үзүүлэлтийн хэдэн хувь нь аюулгүй байдлын үзүүлэлт болох нь тодорхойгүй, бүтээгдэхүүний бохирдуулагчдад 2022 оноос хойш эрсдэлийн үнэлгээ хийгээгүй байна.

2.2.5 Мөн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд пестицид, токсин, хүнд металл, сав баглаа боодлоос бүтээгдэхүүнд шилждэг химийн хорт нэгдэл, нян, мөөгөнцрийн гаралтай хорт бодисын үзүүлэлтүүдийг шинжлэхгүй байна.

2.2.6 Энэ нь эрсдэл өндөртэй бохирдуулагч илрэхгүй үлдэх, улмаар тухайн бүтээгдэхүүний техникийн зохицуулалт, үндэсний стандарт болон аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэх талаар бодитой, иж бүрэн дүгнэх боломжгүй болж, хүнсний аюулгүй байдлын хяналт үр дүнгүй болох эрсдэл үүсэж байна.

2.2.7 Иймд Үндэсний лавлагаа лабораториуд нь бүтээгдэхүүний бохирдлын түвшинд тогтмол эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүйн үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, батлуулах шаардлагатай. Мөн батлагдсан аюулгүйн үзүүлэлтүүдийг бүтээгдэхүүний дээжид бүрэн хамруулан шинжилж, үнэлгээ дүгнэлт хийх хяналт-шинжилгээний зохицуулалтыг шинэчлэх шаардлагатай байна.

2.2.8 Мөн лабораториудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж бүтээгдэхүүний бохирдуулагчдын түвшинд эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаа хийх боломж нөхцөлийг бүрдүүлэх, лабораториудын хяналт-шинжилгээ, маргаан бүхий дээжийг магадлах, дүгнэх эрх мэдлийн хязгаарыг тогтоох шаардлагатай байна.

2.3 Импортын болон дотоодын мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдлийг бүрэн хянаж, тодорхойлж чадахгүй байна.

2.3.1 “Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ – MNS 5868:2008” стандартад зааснаар

- *алиманд 31,*
- *цагаан будаанд 8,*
- *төмсөнд 60,*
- *өндөгөнд 74*
- *сүүнд 72 нэр төрлийн пестицидийн үлдэгдлийн хэмжээг хянах зохицуулалт байна.*

2.3.2 Гэвч УМЭАЦТЛ нь мал амьтны гаралтай бүтээгдэхүүнд **51**, ХАБҮЛЛ нь ургамлын гаралтай бүтээгдэхүүнд 23 нэр төрөл, аймаг нийслэлийн сүлжээ лабораториуд 2, Замын-Үүд дэх Гаалийн газрын салбар лаборатори 16 нэр төрлийн пестицидийн үлдэгдлийг тодорхойлохоор тус тус магадлан итгэмжлэгдсэн боловч итгэмжлэлийн хүрээнд заасан пестицидийн үлдэгдлийг бүрэн хамруулан шинжлэхгүй байна. Тухайлбал:

- Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын лабораториудад анхан шатны түргэвчилсэн илрүүлэг шинжилгээний багажаар, УМЭАЦТЛ өндөр нарийвчлалтай хэмжих, баталгаажуулах шинжилгээний ХХ/МС, ШХ/МС/МС тоног төхөөрөмжөөр хангагдсан боловч 2022-2024 оны хооронд *пестицидийн үлдэгдэл илрүүлэх, баталгаажуулах шинжилгээг огт хийгээгүй* байна.
- СХЗГ-ын харьяа аймаг, нийслэлийн сүлжээ лабораториуд нь пестицидийн үлдэгдэл шинжлэх орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангагдаагүйгээс цөөн үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийж байна. Тухайлбал: Аймаг, нийслэлийн лабораториуд нь ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд зөвхөн *хлорорганик болон фосфорорганик пестицидийг шинжилгээний үр дүнгийн нарийвчлал багатай, олон улсын шаардлагад нийцэхгүй аргаар шинжилж* байна.

²³ УМЭАЦТЛ болон ХАБҮЛЛ-ийн шинжилгээний нэгдсэн системийн 2022-2024 оны тоон үзүүлэлтийн дундаж

- Гаалийн төв лаборатори болон хилийн боомтууд дахь салбар лабораториуд нь өндөр нарийвчлалтай ХХ/МС, ШХ/МС/МС зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдсан боловч тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийлгээгүй, бүрэн суурилуулаагүй огт шинжилгээ хийгээгүй, нийлүүлэгдсэн урвалж оношлуурын хадгалах хугацаа дууссан байна. Сэлэнгэ аймаг болон Замын Үүд дэх Гаалийн газрын салбар лабораториуд 4 нэр төрлийг пестицидийг нарийвчлал, давтамж багатай, орчин үеийн шаардлага хангахгүй аргаар шинжилж байна.

2.3.3 Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг MNS 5868:2008 стандартад зохицуулсан боловч, энэ нь аюулгүйн үзүүлэлтүүдийн жагсаалтад бүрэн тусгагдаагүй байна.

2.3.4 Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, шинжилгээний аргын стандартууд үндэсний хэмжээнд дутагдалтай, Гаалийн болон мал эмнэлгийн лабораториудад тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байгаагаас шалтгаалан пестицидийн үлдэгдлийг бүрэн хянаж тодорхойлж чадахгүй байна.

2.3.5 Сүүлийн жилүүдэд төрөл бүрийн нийлэг хальсан уут хуванцар болон бүрхүүлтэй сав, хооллох хэрэгслийн хэрэглээ огцом нэмэгдэж байгаа боловч хүнсний сав баглаа боодол, нийлэг хальс, усны сав, хүүхдийн тоглоом нийтлэг хэрэглээтэй материалд хүнсэнд шилжиж болзошгүй фталатуудын агууламжийг илрүүлэх шинжилгээг огт хийхгүй байна. Мөн лаазалсан хүнсний доторлогооны бүрхүүл, хуванцар аяга, хүүхдийн тэжээлийн сав, лаазалсан хүнсэнд агуулагддаг Bisphenol A (BPA), нэг удаагийн аяга, сав, хөөсөнцөр материалд агуулагддаг Styrene бодисуудыг огт шинжлэхгүй байна. Тухайлбал,

- Европын Холбоо (EU), АНУ (FDA) хүүхдийн сүүний сав болон хооллох хэрэгсэлд хэрэглэхийг Bisphenol A (BPA)-г хэрэглэхийг хориглосон бол зарим улсад BPA-ын хүнсний савлагаанаас хүнсэнд шилжих дээд хэмжээг 0.05 мг/кг-аас хэтрүүлэхгүй байхаар зохицуулсан байна.

2.3.6 Гэтэл Монгол улсад хүнсний сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилждэг, түгээмэл тохиолддог дээрх нэр төрлийн бодисуудыг огт шинжилдэггүй, хооллох хэрэгсэл, усны сав, нийлэг хальсан уут, нэг удаагийн болон давтан хэрэглэгддэг хооллох сав хэрэгслийн хяналт огт байхгүй байна.

2.3.7 Иймд лабораториудын уялдаа холбоог сайжруулах, хөрөнгө оруулалтын үр нөлөөг сайжруулах, тоног төхөөрөмжийг хяналт шинжилгээнд бүрэн ашиглах, тухайн дэвшилтэд тоног төхөөрөмж дээр ажиллах хүний нөөцийг сургаж дадлагажуулах шаардлагатай байна.

2.4 Лабораториудын барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөц, арга зүйн болон чанарын удирдлагын тогтолцоо нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага хангахгүй байна.

2.4.1 Аудитын хүрээнд ХАБҮЛЛ, СХЗГ-ын харьяа Нийслэлийн лаборатори, Сэлэнгэ аймгийн СХЗХ-ийн лаборатори, Дархан-Уул аймгийн СХЗХ-ийн лаборатори, Дорноговь аймгийн СХЗХ-ийн лаборатори, УМЭАЦТЛ, Сэлэнгэ аймгийн МЭГ-ын лаборатори, Дархан-Уул аймгийн МЭГ-ын лаборатори, Дорноговь аймгийн МЭГ-ын лаборатори, Гаалийн төв лаборатори, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын салбар лаборатори, Замын-Үүд дэх Гаалийн газрын салбар лаборатори, НЭМҮТ-ийн лавлагаа лаборатори, Чингис хаан ОУНБ дахь Гаалийн газрын салбар лаборатори гэсэн 14 лабораторид үнэлгээ хийхэд дараах нийтлэг дутагдал илэрсэн. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийж буй лабораториуд нь чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлдэггүй, батлагдсан аюулгүйн үзүүлэлтүүдийг бүрэн шинжилдэггүй /100%/
- Үндэсний итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэгдээгүй /30,8%/
- Лабораторийн барилга байгууламж, ажлын байрны орчин нөхцөл нь MNS ISO/IEC 7025:2018 стандартын 6.3 дахь шаардлагад нийцээгүй, /61,5%/
- Шинжилгээний арга зүйг тогтмол сайжруулж, баталгаажуулдаггүй /84,6%/
- Багаж тоног төхөөрөмжийн хүчин чадал шинжилгээний аргуудтай нийцэж байгаа эсэхийг тогтмол шалгаж баталгаажуулдаггүй /84,6%/
- Тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийн бүртгэл, засвар үйлчилгээний төлөвлөгөөгүй, тоног төхөөрөмжийн инженергүй /76,9%/
- Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох, зайлшгүй үзэх шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлж, бүрэн хамруулж шинжилгээ хийдэггүй /100%/

- Бодисуудын хүчинтэй хугацааг тогтмол шалгадаггүй, хугацаа хэтэрсэн урвалжийг устгах зааврыг мөрдөж ажилладаггүй /61,5%/
- Сэлэнгэ, Дорноговь аймгийн СХЗХ-ийн сорилтын лаборатори, Дархан-Уул амийгийн МЭГ-ийн лабораторийн бүсүүд хоорондоо бүрэн тусгаарлагдаагүй, барилга байгууламж, ажлын байрны орчин нөхцөл нь MNS ISO/IEC 7025:2018 стандартын 6.3 дахь шаардлагыг болон Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1²⁴ дэх заалтад нийцээгүй
- УМЭАЦТЛ, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорноговь аймгийн МЭГ-ын лабораториуд нь хугацаа дууссан урвалж оношлуурыг дотоод хяналт болон сургалтын зориулалтаар ашигладаг, үл тохирлыг залруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.4.2 Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд хүнсний бүтээгдэхүүний сорилт шинжилгээ хийж буй лабораториудын барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавх, арга зүйн хэрэгжилт нь MNS ISO/IEC 17025:2018 стандартад нийцээгүй, үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

2.4.3 Энэ нь хүнсний аюулгүй байдлыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, хяналт тавих тогтолцоо үйл ажиллагааны болон чанарын хувьд доголдож, хэрэглэгчийн эрх ашиг, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

2.5 Итгэмжлэгдээгүй лабораториуд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шинжилгээг гүйцэтгэж байгаа нь хууль, стандартын шаардлагыг зөрчиж, шинжилгээний үр дүнгийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлж байна.

2.5.1 Үндэсний итгэмжлэлийн төв нь “Сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” олон улсын стандартад нийцүүлэн, СТЗТҮИТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасан үндэслэлээр тохирлын үнэлгээний байгууллага болох лабораториудын чадавхыг тогтоох, итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаа явуулж байна.

2.5.2 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээг зөвхөн итгэмжлэгдсэн лаборатори гүйцэтгэх шаардлагыг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- ХБАБХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээ хийхэд оролцоно” гэж;
- СТЗТҮИТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Энэ хуулийн 13.2-т заасан бүтээгдэхүүнд зөвхөн итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага тохирлын үнэлгээ хийнэ” гэж ;
- Мөн Засгийн газрын 2018 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Баталгаажилт хийх зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д: 100 орчим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, 4 төрлийн үйл ажиллагааг итгэмжлэгдсэн лаборатори буюу тохирлын үнэлгээний байгууллагаар сорилт, шинжилгээ хийхээр тус тус зохицуулсан байна.

2.5.3 Гэтэл Дорноговь аймгийн МЭГ-ын лаборатори, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын лаборатори, НЭМҮТ-ийн лавлагаа лабораторийн нян судлал, хими, хор судлалын зарим итгэмжлэгдээгүй үзүүлэлтүүдээр сорилт шинжилгээ хийж байна.Тухайлбал,

- НЭМҮТ-ийн лавлагаа лаборатори нь ҮИТ-ийн даргын 2022 оны А/28 тоот тушаалаар MNS ISO 17025:2018 стандартын хүрээнд хими, хүнд металлын 65 үзүүлэлтээр шинжилгээ хийх эрхтэйгээр итгэмжлэгдсэн боловч ундны усанд бичил биетний ерөнхий тоо тоолох, Escherichia coli нян илрүүлэх, шээсэнд иодын агууламж тодорхойлох зэрэг итгэмжлэгдээгүй үзүүлэлтээр шинжилгээ хийж байна.
- Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын салбар лаборатори нь бүхэлдээ итгэмжлэгдээгүй хэдий ч импортын хүнсний бүтээгдэхүүнд магадлан шинжилгээ хийж байна.
- Дорноговь аймгийн МЭГ-ын лаборатори нь итгэмжлэлийн хугацаа дууссан бөгөөд хугацаагаа сунгуулаагүй байхад мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийж байна

2.5.4 НЭМҮТ-ийн лавлагаа лабораторийн зарим үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, эрх зүйн шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал:

²⁴ 7.1.Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан зураг төслийн дагуу баригдсан, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.

- Тус лаборатори нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасан зохицуулалтыг зөрчиж, батлагдсан жишиг хэмжээнээс давсан шинжилгээний тарифыг байгууллагын шийдвэрээр дангаар тогтоон, төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн байна.
- Хүн амын хоол тэжээлийн тандалт судалгаа хийх чиг үүргийн хүрээнд шаардагдах барилга байгууламж, тоног төхөөрөмж, орчны нөхцөл шаардлага хангахгүй, лабораторийн зарим чиглэлийн (нян судлал, хими хор судлалын) үйл ажиллагаа итгэмжлэлгүй явагдаж байна.
- НЭМҮТ-ийн дэргэдэх “Нялхас болон хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хоолны хяналтын орон тооны бус зөвлөл” нь нярай, хүүхдийн сүүн тэжээлийн чанар, аюулгүй байдалд үнэлгээ хийхдээ заавал шинжлүүлэх бохирдуулагчдыг бүрэн шинжлүүлээгүй, холбогдох стандарт, зөвлөмж хэмжээг баримтлаагүй байна.
- Хүн амын хоол тэжээлийн байдлын тандалт судалгаанд ач холбогдолтой үзүүлэлтүүд болох Д аминдэмийн агууламж, төмөр болон А аминдэмийн дутагдал, үрэвслийн биомаркер үзүүлэлтүүдийг шинжлэх тоног төхөөрөмжөөр хангагдаагүй байна.
- Итгэмжлэгдээгүй үзүүлэлтийн хүрээнд сорилт шинжилгээ хийж, үр дүнг итгэмжлэгдсэн болон итгэмжлэгдээгүй үзүүлэлтээр ялгаатай загвараар тайлагнаж буй нь MNS ISO/IEC 17025:2018 стандарт болон ХБАБХТХ-ийн 15.3-т заасан шаардлагыг зөрчиж байна.

2.5.5 Энэ нь шинжилгээний үр дүнгийн найдвартай байдалд эргэлзээ төрүүлж, хүнсний аюулгүй байдлын хяналт-шинжилгээ, тандалт судалгааны үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

2.5.6 Иймд НЭМҮТ-ийн лавлагаа лабораторийн хууль тогтоомжийн үл нийцлийг засаж сайжруулах, хүн амын хоол тэжээлийн байдлын тандалт судалгаа хийх чадамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.6 Улсын төсөв, АХБ-ны санхүүжилтээр нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

2.6.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон АХБ-ны төслийн санхүүжилтээр 2022-2024 оны хооронд Гаалийн төв болон салбар лабораториуд, Мал эмнэлгийн сүлжээ лабораториудад зориулалтын барилга, байгууламж, багаж тоног төхөөрөмж нийлүүлж хүчин чадлыг нэмэгдүүлсэн боловч зарим лабораториуд шинжилгээ хийгээгүй, тоног төхөөрөмжийг ашиглаагүйгээс урвалж оношлуурын хугацаа дуусаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Тухайлбал:

- Чингис хаан ОУНБ дахь ГСЛ, Гаалийн төв лабораториуд сорилт, шинжилгээ огт хийгээгүй, Сэлэнгэ аймаг дахь ГСЛ, Замын-Үүд дэх ГСЛ нь хүнсний микробиологийн автомат анализатор, атомын шингээлтийн спектрометр, газ хроматографи/масс спектрофотометр, шингэний хроматографи зэрэг өндөр өртөгтэй тоног төхөөрөмжүүдийг ашиглаагүйгээс урвалж оношлуурын хугацаа дууссан байна.
- Сэлэнгэ, Дорноговь аймгийн МЭГ-т нийлүүлэгдсэн өндөр хүчин чадал бүхий зарим тоног төхөөрөмжийг ашиглаагүй, УМЭАЦТЛ-ийн 2022 оны 12 сарын 30 нд хөрөнгийн дахин үнэлгээ хийж ашиглах жил дуусаагүй 99.3 сая төгрөгийн 3 тоног төхөөрөмж /AAS, элизагийн плат уншигч, автоклав series-200/-ийг ашиглаагүй, актлах хөрөнгийн жагсаалтад оруулсан байна.

2.6.2 Лабораториудын ашиглаагүй тоног төхөөрөмж болон хугацаа дуусаж ашиглалтын шаардлага хангахгүй болсон урвалж оношлуур зэрэг үр ашиггүй зарцуулсан хөрөнгө оруулалтыг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 9. Гаалийн Төв болон салбар лабораториуд, Мал эмнэлгийн сүлжээ лабораториудад улсын төсвөөс болон АХБ-ны санхүүжилтээр хийсэн хөрөнгө оруулалтын дүн /сая төгрөгөөр/

№	Лабораториудын нэр	Тоног төхөөрөмж	Урвалж оношлуур	Лабораторийн туслах, дагалдах хэрэгсэл	Нийт
1	Гаалийн төв лаборатори	928.7	76.4		1,005.0
2	Замын-Үүд дэх ГСЛ	2,160.6	61.5	85.0	2,307.1
3	Сэлэнгэ аймаг дахь ГСЛ	2,898.9	67.1	45.4	3,011.4
4	ЧХОУНБ дахь ГСЛ	1,466.1	56.4	43.7	1,566.3
	Гаалийн төв болон ГСЛ-иудын нийт дүн	7,454.3	261.4	174.1	7,889.7
5	УМЭАЦТЛ	122.8	17.3		140.1

6	Сэлэнгэ аймгийн МЭГ-ын лаборатори	920.4			920.4
7	Дорноговь аймгийн МЭГ-ын лаборатори	591.4	9.5		600.9
	УМЭАЦТЛ болон МЭ-ийн сүлжээ лабораториудын нийт дүн	1,634.6	26.8		1,661.4
	Нийт дүн	9,088.9	288.2	1,74.1	9,551.1

2.6.3 Нийт 9,551.1 сая төгрөгийн үнэ бүхий бүхий тоног төхөөрөмжийн туршилт тохируулга хийгээгүй, урвалж оношлуур, дагалдах хэрэгслийг ашиглаагүй, үүнээс 288.2 сая төгрөгийн урвалж оношлуурын хугацаа дуусаж ашиглах боломжгүй болсон байна.

2.6.4 Үүнээс Гаалийн төв болон салбар лабораториудад хамгийн өндөр дүнтэй буюу нийт 7,889.7 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, урвалж оношлуураар шинжилгээ хийгээгүй байна.

2.6.5 Мөн УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн лабораториуд нь хүнсний бүтээгдэхүүн дэх зарим төрлийн химийн бохирдол илрүүлэх шинжилгээг огт хийхгүй байгаагаас өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг ашиглаагүй, урвалж оношлуурын хугацаа дууссан байна. Тухайлбал:

- Хүнсний бүтээгдэхүүнд хүнд металл болон пестицидийн үлдэгдлийн шинжилгээг хийхгүй байгаагаас тухайн шинжилгээний тоног төхөөрөмжүүд болон дагалдах хэрэгслийн ашиглаагүйгээс тухайн шинжилгээний урвалж оношлуурын хугацаа дууссан;
- Эмийн үлдэгдлийн шинжилгээний болон бичил биетэн илрүүлэх, ялгах урвалж оношлуурын захиалгыг оновчтой төлөвлөөгүйгээс өндөр өртөг бүхий оношлууруудын хугацаа дууссан;
- ус цэвэршүүлэгч, ус ионжуулагч, босоо гүн хөлдөөгч, өндөр, атомын шингээлтийн спектрометр, газ болон хийн хроматографи /масс спектрофотометр/, хүнсний микробиологийн анализатор зэрэг зарим өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг суурилуулж шалгалт тохируулга хийгээгүй, оношлуур, дээж хадгалах зориулалттай хөргүүрүүд эвдэрхий байснаас огт ашиглаагүй байна.

2.6.6 ХАБҮЛЛ-т 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,496.7 сая төгрөгийн үнэ бүхий хийн хроматографи-масс спектрометр (GC-MS/MS) иж бүрдэл, шингэний хроматографи (HPLC) иж бүрдэл, атом шингээлтийн спектрометр (AAS) иж бүрдэл, НҮБ-ын ХХААБ-ын төслийн хүрээнд пестицидийн явуулын шинжилгээний хурдавчилсан 1 иж бүрдэл багаж нийлүүлэгдэж тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн боловч аюулгүйн үзүүлэлтүүдийг иж бүрэн шинжилж чадахгүй хэвээр байна.

2.6.7 Шинжилгээний багаж, тоног төхөөрөмж эвдэрч ашиглалтын шаардлага хангахгүй болсноос зарим аюулгүйн үзүүлэлтүүдийг шинжилж чадахгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. ХАБҮЛЛ-ийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон багаж, тоног төхөөрөмж, шинжилгээний үзүүлэлтүүд

№	Багажийн нэр	Шинжилгээний үзүүлэлтүүд
1	Ион хроматограф (Ion Chromatograph, IC)	Ус, шингэн орчны дээжид агуулагдах анион, катион (ионууд)-ыг ялгаж, тодорхойлох
2	Хийн хроматограф (Gas Chromatograph, GC)	Спирт, хүнсний нэмэлт, үнэр амтлагч, галд тэсвэртэй бодис, утаа, угаар, дэгдэмхий бодисын найрлага тодорхойлох
3	Шингэний хроматограф (HPLC)	Органик ба органик бус хорт бодисуудыг тодорхойлох, хэмжих
4	Пивоны агууламжийн тодорхойлогч	Пивоны найрлагын хэмжилт хийх
5	Хүнсний уургийн агууламж тодорхойлогч	Хүнсний бүтээгдэхүүний уургийн агууламж тодорхойлох
6	Лактосон (Lactoscan)	Сүүнд агуулагдах найрлагын үндсэн үзүүлэлтийг хурдан, нарийвчлалтай тодорхойлох
7	Туслах төхөөрөмжүүд: хатаагч, шатаах зуух, тог баригч, термостат гэх мэт	Туршилт, бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх туслах багажууд

2.6.8 Дээрх IC, GC, HPLC зэрэг хроматографийн өндөр нарийвчлалтай багажууд нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй химийн хортой бохирдуулагчийг илрүүлэхэд өргөнөөр ашиглагддаг.

2.6.9 Эдгээр багаж нь хүнсний аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай, хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металл, ионы найрлага, дэгдэмхий органик нэгдлүүд, хорт бодис, спиртийн агууламж, уураг, лактозын хэмжээг тодорхойлох чадамжтай.

2.6.10 Гэвч ашиглалтын шаардлага хангахгүй, тоног төхөөрөмжийн дутагдалтай байгаагаас ХАБҮЛЛ нь түгээмэл тохиолддог, эрсдэл өндөр бохирдуулагчдыг шинжлэх боломжгүй, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тодорхойлох, баталгаажуулах шинжилгээ хийх чиг үүргээ хэрэгжүүлэхэд боломжгүй байна.

2.7 СХЗГ нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, лабораторийн тоног төхөөрөмж худалдан авч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасныг зөрчсөн байна.

2.7.1 СХЗГ нь 2024 онд сүлжээ лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор 13 нэр төрлийн 3,004 тэрбум үнэ бүхий тоног төхөөрөмж нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан байна.

2.7.2 Уг худалдан авах ажиллагааны хүрээнд 2024 онд иммунологийн бүрэн автомат анализатор /иж бүрдэл/ худалдан авахаар УТ2400900250 кодтой НТШ зарлаж 64 сая төгрөгөөр БНХАУ-д үйлдвэрлэсэн Microbial ID/AST System/Microbial Detection Instrument төхөөрөмж болон БНСУ-д үйлдвэрлэсэн бичил биетэн өсгөвөрлөх зориулалттай 42 литрийн багтаамжтай термостат 2 ширхэг, нийт 2 төрлийн 3 тоног төхөөрөмж худалдан авч Орхон аймгийн СХЗХ-ын лабораторид нийлүүлсэн байна.

2.7.3 Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана” гэж заасныг зөрчсөн байна.

2.7.4 НЭМҮТ-ийн лавлагаа лаборатори нь сүүлийн 5 жилд хүнс, орчны шинжилгээ хийж байгаа лабораторид техник, технологийн шинэчлэл хийгдээгүй, 2020 онд хийн хроматографийн тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

2.7.5 Итгэмжлэлийн байгууллага болох УИТ нь УМЭАЦТЛ болон мал эмнэлгийн (МЭ)-ийн сүлжээ лабораториудыг хүчингүй болсон стандарт аргачлалаар итгэмжилсэн нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын 8.5.1^[1] болон 7.11.3^[2] заалтуудыг зөрчиж байна. Тухайлбал:

- Сэлэнгэ аймгийн МЭГ-ын ариун цэврийн магадлан шинжилгээний лабораторийг 2024 онд 5 төрлийн хүнсний бүтээгдэхүүнд 21, үүнээс аюулгүйн 9 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийхээр итгэмжлэгдсэн боловч дээрх аюулгүйн үзүүлэлтүүдийн 77.78% /7/-ийг хүчингүй шинжилгээний аргачлалаар итгэмжилсэн байна.

2.7.6 Дээрх нөхцөл байдлаас харахад итгэмжлэлийн байгууллага нь лабораториудыг итгэмжлэхдээ ашиглаж буй стандарт аргачлалын хүчинтэй, үнэн зөв байдлыг шалгаагүй, мөн тухайн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадвартай эсэхийг бодит нотолгоонд тулгуурлан үнэлээгүй байна.

2.7.7 Шинжилгээний аргын стандарт, аргачлалын талаарх буруу мэдээлэл нь хэрэглэгчид болон иргэдийн лабораторийн үр дүнд итгэх итгэлийг бууруулах, олон улсын экспортын баталгаажуулалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2.7.8 Иймд лабораториудад хийсэн итгэмжлэлийн үнэлгээг дахин хийх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, лабораториудын чадамжийг үнэн зөв бодитоор үнэлэх замаар хүнсний аюулгүй байдлын хяналт арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

2.8. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр мэдээллийг бүртгэх цахим системүүд уялдаагүй, нэгдсэн мэдээллийн сан үүсээгүй, хяналтын систем бүрдээгүй байна.

2.8.1 Хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах чиг үүрэг бүхий яам, агентлагууд хүнсний аюулгүй байдлын талаарх нэгдсэн мэдээллийн тогтолцоог бүрдүүлээгүй²⁵, тус тусдаа бие даасан системүүдийг ашиглаж байна.

2.8.2 Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар нь тус бүр бүртгэл, хяналтын системтэй боловч тэдгээрийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийх боломж бүрдээгүй²⁶ байна.

2.8.3 Мал аж ахуйн салбар 2018-2024 онд 1,026.8 сая төгрөгөөр дараах цахим мэдээллийн системүүдийг хөгжүүлсэн байна.

Хүснэгт 11. Мал эмнэлгийн салбарт ашиглаж буй цахим систем

№	Системийн нэр	Ашиглалтанд орсон он	Хөгжүүлсэн компани	Системийн үнэ
1	Мал эмнэлгийн гэрчилгээний систем	2018	Дижитал Медик ХХК	36,000,000.0
2	Мал амьтны эм, вакцины үйлдвэрлэл, мониторингийн мэдээллийн систем	2019		21,450,000.0
3	Эрүүл хүнс платформ			18,000,000.0
4	Малын өвчлөлийн талаар мэдээлэл цуглуулах, нэгтгэх веб болон хөдөлгөөнт программ			54,000,000.0
5	Мал эмнэлгийн эмийн бүртгэл, нэгдсэн мэдээллийн сан, хэрэглээний хяналт, зохистой хэрэглээг сайжруулах тогтолцоог бий болгох, малын эмийн систем	2020	Оол линк ХХК	79,585,000.0
6	Мал эмнэлгийн нэгдсэн системийн сайжруулалт, тайлангийн модуль	2021	Дижитал Медик ХХК	51,590,000.0
7	Олон улсын цахим мал эмнэлгийн гэрчилгээний систем			55,960,000.0
8	Мал эмнэлгийн нэгдсэн системийн өргөтгөл /МЭНС 2.0/			511,934,000.0
9	Махны үйлдвэрийн систем	79,500,000.0		
10	Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд олгож буй экспорт, импортын гэрчилгээний цахим систем	2024	Дижитал Медик ХХК	19,800,000.0
11	Мал, эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн бүртгэлийн систем	2024		99,000,000.0
Нийт дүн				1,026,819,000.0

2.8.4 Дээрх системүүдийн аюулгүй байдлын шаардлага хангалтгүй, тусад нь хөгжүүлсэн, мэдээлэл солилцох API хамгаалалт дутуу, уялдаа холбоогүй, хандах эрхийн зохицуулалт, үүрэг оролцоог тодорхойлоогүй байна. Тухайлбал,

- “Мал аж ахуйн нэгдсэн систем”-тэй “Мал эмнэлгийн гэрчилгээний систем”-ийг холболт хийсэн боловч малын тоо толгойтой уялдуулан мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг цахимаар тодорхойлж гэрчилгээ олгох үйл явц системийн холболт, хэрэглэгчийн мэдээлэл оруулалт зэргээс хамааран бодит бус, үр дүнгүй болсон байна.
- Мөн “Мал эмнэлгийн гэрчилгээний систем” болон “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим систем”-ийг холбож уялдуулаагүй байна.

²⁵ “Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах журам”-ын 3.1.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээллийг нэгтгэн боловсруулах, баяжуулах үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

²⁶ 3.7.Мал эмнэлгийн салбарын төрийн байгууллагууд нь тухайн шатандаа бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг бүрдүүлж, нэгтгэн дүгнэх ба мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангана;

2.8.5 “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим систем”-ийг (<http://drug.mahis.gov.mn/>) Ооллинк ХХК 79.5 сая төгрөгөөр 2020 онд хөгжүүлсэн боловч ажлын даалгаврын дагуу 17 ажил хийхээр тусгаснаас малын эм бэлдмэл бүртгүүлэх, тусгай зөвшөөрлийн хүсэлтүүд зэрэг модулиудыг ашиглалтад оруулж бусад ажлуудыг хийгээгүй байхад систем хөгжүүлэлтийн төлбөрийг бүрэн төлсөн байна.

2.8.6 Гэтэл ХХААХҮЯ 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Дижитал Медик ХХК-тай 241224/04-1039 дугаартай 99.0 сая төгрөгөөр шинээр “Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн бүртгэлийн систем” хөгжүүлэхээр гэрээ байгуулсан байна.

2.8.7 Энэ нь өмнөх систем, программ хангамжуудын судалгаа, ашиглалтын байдалд хяналт-шинжилгээ хийхгүйгээр дахин шинээр систем хөгжүүлэх шийдвэр гаргаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хяналт хариуцлагын тогтолцоо алдагдсан байгааг харуулж байна.

2.8.8 МЭЭГ-аас Дижитал Медик ХХК-тай байгуулсан 2019-2021 оны 212.5 сая төгрөгийн үнийн дүнтэй 6 гэрээнд туссан зарим программ хангамжийн бүрдэл хэсгүүд (систем, модулиуд, функцүүд) огт хийгдээгүй, зарим ажлыг дутуу хийсэн байна. Тухайлбал,

- Олон улсын цахим мал эмнэлгийн гэрчилгээний систем хөгжүүлэх 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн МЭЭГ/2021/11-28 дугаартай 55.9 сая төгрөгийн гэрээний ажлын даалгаварт заасны дагуу үндсэн 3 хэсгээс бүрдэх 46 дэд ажлыг хийх ёстой байсан боловч тус системийн андройд үйлдлийн систем дээр ажиллах хэсэг хийгдээгүй, дэд хэсэгт заасан ажлуудыг дутуу хийсэн,
- Мал эмнэлгийн нэгдсэн системийн сайжруулалт, тайлангийн модуль хөгжүүлэх 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн МЭЭГ/2021/11-27 дугаартай 51.5 сая төгрөгийн гэрээний ажлын даалгаварт заасны дагуу үндсэн 6 хэсгээс бүрдэх 58 дэд ажлыг хийх ёстой байсан боловч мобайл аппликейшн хийгээгүй, веб систем нь ажиллахгүй,
- Судалгааны модуль хөгжүүлэх 2020 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн МЭЭГ/2020/034 дугаартай 3.0 сая төгрөгийн гэрээний дагуу 9 хоногийн дотор буюу 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж, ажлыг хүлээж авсан боловч хийсэн ажил байхгүй, судалгааны модуль тодорхойгүй,
- Малыг эрүүл мэндийн үйлчилгээний модулиар, МЭНС-ийг хөгжүүлэх программ хангамж хийх 2021 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн МЭЭГ/2021/08-30 дугаартай 29.9 сая төгрөгийн гэрээний дагуу 6 хоногийн дотор буюу 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж, ажлыг хүлээж авсан боловч хийсэн ажил байхгүй,
- Эрүүл хүнс платформ хөгжүүлэх 2019 оны 12 сарын 23-ны өдрийн МЭТШ/2019/11011 дугаартай 18.0 сая төгрөгийн гэрээний дагуу хийсэн платформ байхгүй,
- Малыг өвчлөлийн талаар мэдээлэл цуглуулах, нэгтгэх веб болон хөдөлгөөнт программ хөгжүүлэх 2019 оны 10 сарын 24-ны өдрийн МЭТШ/2019/11013 дугаартай 54.0 сая төгрөгийн гэрээний дагуу нэгтгэсэн веб болон хөдөлгөөнт программ байхгүй,

2.8.9 Дээрх ажлуудыг захиалагч талаас хүлээн авч санхүүжилт олгосон албан тушаалтнуудад хариуцлага тооцож, гүйцэтгээгүй ажлын төлбөрийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор аудитаар шийдвэрлэлээ.

2.9 Систем хөгжүүлсэн компани төрийн байгууллагын системийг ашиглаж үйлчилгээний тариф тогтоон орлого олсон байна.

2.9.1 Мал эмнэлгийн ерөнхий газар 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн МЭГС-2018/11/15 дугаартай мал эмнэлгийн нэгдсэн системийн засвар үйлчилгээний гэрээг Дижитал Медик ХХК-тай 2018 оны 11 дүгээр сарын 15-наас 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл байгуулж 4.1-т “Программ хангамжийн засвар үйлчилгээний төлбөрт аймаг болон нийслэлийг нэг нэгж болгон авч үзэж гэрээгээр зохицуулах болно” гэж заажээ.

2.9.2 Тус гэрээний заалтыг үндэслэн мал эмнэлгийн нэгдсэн систем ашигласны төлбөр гэж ямар нэгэн гэрээгүйгээр “Дижитал Медик” ХХК 2023 оны 9 дүгээр сараас эхлэн мал эмнэлгийн нэгдсэн системийн хэрэглэгчид болох малын эмч нараас гар утасны апплейкшнээр дамжуулан тус бүр жилийн 0.12 сая төгрөгийн төлбөр авсан байна.

2.9.3 Махны үйлдвэрийн систем нь хоёр үндсэн интерфейстэйгээр ажиллаж байна. Үүнд:

- Нэгдүгээр интерфейс нь Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) болон аймаг, орон нутгийн хяналтын байцаагч нар ашигладаг бөгөөд тухайн интерфейсээр дамжуулан махны үйлдвэрийн хяналтын мэдээлэлд хандалт хийх, хяналт баталгаажуулах, мал эмнэлгийн гэрчилгээ олгох зэрэг функцүүдийг хэрэгжүүлдэг.
- Хоёрдугаар интерфейс нь махны үйлдвэрийн дотоод үйл ажиллагааг хянах, зохион байгуулах зориулалттай бөгөөд үйлдвэрүүд өөрсдийн үйл ажиллагаанд ашигладаг.

2.9.4 МЭЕГ-аас махны үйлдвэрүүдэд тус системийг заавал ашиглах шаардлага тавьж уг системд нэвтэрч, үйлчилгээ авахын тулд “Дижитал Медик” ХХК-д жилийн 1.2 сая төгрөг хүртэлх хэмжээний үйлчилгээний хураамж төлсөн байна.

2.9.5 Аудитаар цуглуулсан нотлох баримтад үндэслэн 2023 оноос 2024 он хүртэлх хугацаанд мал эмнэлгийн нэгдсэн системийг ашигласан аймаг, орон нутгийн 34 аж ахуйн нэгжээс 23.3 сая төгрөг, 305 хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс (МЭҮН) 35.8 сая төгрөг, нийтдээ 339 байгууллагаас 59.0 сая төгрөгийн төлбөрийг “Дижитал Медик” ХХК авсан байна.

2.9.6 Мөн ХХААХҮЯ-ны захиалгаар 2021 онд “Сүү бэлтгэлийн систем”-ийг Дижитал Медик ХХК хөгжүүлж 2023 оноос системд бүртгэлтэй 40 орчим сүүний үйлдвэрүүдээс төлбөр авсан байна.

2.9.7 Системийн төлбөр нь тухайн ААН-ийн үйлдвэрийн хүчин чадал болон хамрах хүрээнээс шалтгаалан ялгаатай тогтоож, жижиг үйлдвэрээс 0.4 сая төгрөг, дунд үйлдвэрээс 1.3 сая төгрөгийн төлбөр авдаг бол том үйлдвэрээс авах төлбөрийн хэмжээ тодорхойгүй байна.

2.9.8 Сүү бэлтгэлийн системийн сайжруулалт, хэвийн ажиллагааг хангах, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мөшгөлтийн системтэй холбох хөгжүүлэлт хийх гэрээг Дижитал Медик ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 18.0 сая төгрөгийн үнийн дүнтэй байгуулсан байна.

2.9.9 Тус гэрээний ажлын даалгаварт заасны дагуу нэмэлтээр болон шинээр хийх 16 ажлыг тусгаснаас аналитик тооцоолол, шинжилгээний модуль хөгжүүлэх, и-баримтын системтэй холбох, бэлчээрийн мэдээллийг өргөтгөх, малчдын байршлыг тогтоох зураглал гаргах, газрын зураг дээр агуулахын үлдэгдэл, худалдааны тоон мэдээг хянах, газар зүйн байршлаар үлдэгдлийг хянах зэрэг ажлуудыг хийгээгүй байна.

2.9.10 Мал эмнэлгийн ерөнхий газар гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул, ажлын даалгаврын дагуу систем хөгжүүлсэн эсэхийг хянаж, шалгахгүйгээр гэрээ дүгнэсэн акт үйлдэж, хөгжүүлээгүй системд төлбөр төлсөн байна.

2.9.11 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2²⁷-т заасан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төрийн өмч /систем/-ийг Дижитал Медик ХХК ашиг олох зорилгоор эзэмшиж байна.

2.10 Хүнсний аюулгүй байдлын хангах лабораторийн нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна.

2.10.1 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж²⁸, удирдах чиг үүрэгтэй боловч мэдээллийн урсгалын тогтолцоо бүрдээгүй, систем хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

2.10.2 Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори /ХАБҮЛЛ/, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори /УМЭАЦТЛ/, Гаалийн төв лаборатори /ГТЛ/ тус бүр цахим системтэй байна. Үүнд,

- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Лабораторийн мэдээллийн тогтолцооны систем (LIMS)

²⁷ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

²⁸ 15.1.Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори ажиллана.

- Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн цахим систем (LIMS)
- Гаалийн төв лабораторийн цахим систем (CAIS)

2.10.3 Төрийн, орон нутгийн болон хувийн лабораториуд хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтэд хийсэн шинжилгээний дүнгийн мэдээллийг нэгдсэн санд оруулаагүй байгаа нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим алдагдаж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2²⁹, 15.4³⁰-д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй, хяналт, хариуцлага алдагдсан байна.

2.10.3 ХАБҮЛЛ-ийн (LIMS) систем нь Дижитал Медик ХХК 2018 онд 129.9 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, 2019 онд ашиглалтад оруулсан байна. Тус систем лабораторийн шинжилгээ, сорилтын мэдээллийг бүртгэх, удирдах, хянах зорилготой ба 21 аймаг, нийслэлийн 3 лаборатори ашиглаж, шинжилгээний явц болон үр дүнг мэдээллийн сан хэлбэрээр бүрдүүлж байна.

2.10.4 Тус системийн тасралтгүй хэвийн үйл ажиллагаа, хөгжүүлэлтийн төлбөрт 71.5 сая төгрөг төлсөн ба 2020-2024 онд байгуулсан нэмэлт хөгжүүлэлтийн гэрээнд дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал,

- 2020 онд гэрээ байгуулахгүйгээр 13.2 сая төгрөгийг Дижитал медик ХХК-д шилжүүлсэн,
- 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн гэрээний 4.2-т заасны дагуу хийсэн ажлыг дүгнээгүй, 7.4-т “ Энэ гэрээг тухайн оны төгсгөлд гэрээнд дүн шинжилгээ хийж баталгаажуулснаар цаашид хийх ажлын төлөвлөгөө, дараа оны гэрээ байгуулах эрх үүснэ” гэж тусгасан боловч дүн шинжилгээ хийгээгүй, Мөн тус гэрээнд гэрээний хугацааг тусгахдаа 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилнэ гэж өмнөх хугацааг оруулан тооцож гэрээ байгуулан 13,2 сая төгрөгийг шилжүүлсэн, гэрээ байгуулсан өдрөөс өмнөх 7 сарын төлбөр буюу 7.7 сая төгрөгийг нөхөж олгосон,
- 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан гэрээний 4.2-т заасан ажлыг бүрэн шалгаж хүлээж аваагүй, Тус гэрээг байгуулахаас өмнөх хугацаа буюу 2022 оны 1 сараас хойш хугацаа тооцож 3.3 сая төгрөгийг шилжүүлсэн,
- 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 09-001 дугаартай гэрээний 4.2-т заасан ажлыг бүрэн шалгаж хүлээж аваагүй, 2023 оны гэрээг 2022 оны 05 сарын 18-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээ байгуулахаас өмнөх хугацаа буюу 2023 оны 1 сараас хойших хугацааг оруулан тооцож төлбөрийг шилжүүлсэн, гэрээний хугацааг бичээгүй “2023 оны .. сарын ...-аас эхлэн 2023 оны дугаар ... сарын ... ний өдөр” гэрээ байгуулсан, гэрээ байгуулсан өдрөөс өмнөх 4 сарын төлбөр буюу 4.4 сая төгрөгийг нөхөж олгосон,
- 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 09-001 дугаартай гэрээний 4.2-т заасан ажлыг бүрэн шалгаж хүлээж аваагүй, гэрээг 2024 оны 05 сарын 27-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээ байгуулахаас өмнөх хугацаа буюу 2024 оны 1 сараас хойших хугацааг оруулан тооцож 4.4 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн, гэрээ байгуулсан он, сар, өдрийг бичээгүй байна.

2.10.5 Дижитал медик ХХК-д гэрээ байгуулсан хугацаанаас өмнө, урьдчилан 33.0 сая төгрөгийг гэрээнд заасан ажлыг шаардлага хангаж хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж дүгнэхгүйгээр шилжүүлсэн байна.

2.10.6 ХАБҮЛЛ-ийн лабораторийн мэдээллийн системийн (LIMS) ажиллагаанд дараах сул тал үүсэх эрсдэлтэй байна. Тухайлбал,

- Систем нь бусад төрийн байгууллагын мэдээллийн системүүдтэй холбогдоогүй, мэдээлэл солилцох API эсвэл вебсервисийн боломж хангалтгүй,
- Java болон RESTful технологид суурилсан ч микросервис архитектур, контейнер сууриар шинэчлэгдээгүйгээс хөгжүүлэлтийн уян хатан байдал, өргөтгөх боломж хязгаарлагдмал,
- Хэрэглэгчийн эрхийн хяналт байгаа ч хоёр шатлалт баталгаажуулалт, SSL шифрлэл, аюулгүй байдлын аудит, халдлага илрүүлэх систем зэрэг орчин үеийн хамгаалалтын арга хэмжээ нэвтрүүлээгүй нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлтэй,
- Системийн ачаалал даах чадвар болон олон хэрэглэгчийн зэрэгцээ хандалттай үед ажиллах байдалд үнэлгээ, тест хийгдээгүй тул ачааллын үед гацалт, удаашрал үүсэх магадлалтай,
- Мэдээлэл нөөцлөх болон сэргээх ажиллагааны давтамж, технологи, хариуцсан бүтэц тодорхой бус байгаагаас системийн хяналт сул байна.

²⁹ 15.2.2.энэ хуулийн 15.4-т заасны дагуу ирүүлсэн шинжилгээний дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, удирдах;

³⁰ 15.4. Энэ хуулийн 15.3-т заасан лаборатори шинжилгээний дүнгээ мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ.

2.10.7 Мөн системийн технологийн бүтэц нь харьцангуй хуучирсан, мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн шаардлагыг бүрэн хангаагүй, мэдээллийн системүүд хоорондын уялдаа холбоо сул байгаа нь цаашдын тогтвортой ажиллагаа, өргөтгөл, мэдээлэл солилцоо, аюулгүй байдлын хувьд эрсдэл дагуулах нөхцөл бүрдүүлж болзошгүй байна.

2.10.8 Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн Мал эмнэлгийн лабораторийн цахим системийг 2016 онд Швейцарын хөгжлийн агентлагийн “Малын эрүүл мэнд” төслийн 72.2 сая төгрөгийн санхүүжилтээр Дижитал Медик ХХК хөгжүүлж, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори болон 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид нэвтрүүлсэн байна.

2.10.9 Тус лабораторийн цахим системийг хариуцан ажиллаж байгаа мэргэжилтэн нь мэргэжлийн бус, малын эмч мэргэжилтэй хүн ажиллаж байгаа нь системийн зохих ёсны ажиллагаа, засвар үйлчилгээ, хөгжүүлэлт болон мэдээллийн аюулгүй байдлын баталгаажуулалтад эрсдэлийг бий болгож байна.

2.11 Лабораторийн шинжилгээний дүнг цахим системд засварлаж, өөрчлөх тохиолдол цөөнгүй байна.

2.11.1 ХАБҮЛЛ-ийн мэдээллийн тогтолцооны системээс (LIMS) 2022 онд 91, 2023 онд 137, 2024 онд 136, УМЭАЦТЛ-ийн цахим системээс 2022 онд 399, 2023 онд 334, 2024 онд 349 удаа шинжилгээний үр дүнг буцааж өөрчилсөн байна. Үүнд:

- Сорьцын хэмжээ системд буруу оруулсан;
- Бүтээгдэхүүний нэршил, үйлдвэрлэсэн улсын мэдээлэл алдаатай;
- Шинжилгээ хариуцсан байцаагчийн нэр дутуу эсвэл оруулаагүй;
- Хүчинтэй хугацаа буруу бичигдсэн;
- Үр дүнг дахин тооцож гаргах;
- Шинжилгээний төрөл болон үзүүлэлтийн ангилал буруу сонгогдсон;
- Дутуу үзүүлэлттэй шинжилгээ илгээсэн тул нэмэлтээр үзүүлэлт оруулах шаардлага үүссэн зэрэг,

2.11.2 Дээрх нөхцөл байдал нь MNS ISO/IEC 17025:2017 стандартын 7.11.3³¹-т заасан шаардлагыг хангахгүй, өгөгдлийн найдвартай байдал, дээж хадгалалт, давтан шинжилгээ хийхэд хугацаа алдах, шинжилгээний үр дүн бодитой, үнэн зөв гарч байгаа эсэхэд эрсдэл үүсгэж байна.

2.12. Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, эм, хэрэгслийн аюулгүй байдлыг хянах, малын дархлаажуулалтын эм бэлдмэлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.12.1 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2.6 “Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно”, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7.1.12 “Мал эмнэлгийн алба нь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага байна.” гэж заасны дагуу мал, эмнэлгийн байгууллага нь улсын стратегийн хүнс болох мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хангах чиг үүрэгтэй.

2.12.2 МАЭМтХ-ын 9.2 “Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална” гэж заасны дагуу жил бүр тархвар зүйн судалгааны үндсэн дээр бодитой төлөвлөж дархлаажуулалтыг хийхээр хуульчилсан.

³¹ "Лабораторийн мэдээллийн тогтолцоонд бүртгэгдэж буй мэдээлэл нь алдаагүй, бүрэн, үнэн зөв байх шаардлагатай"

2.12.3 МЭЕГ 2022-2024 онд үндэсний хэмжээнд нийт 21 төрлийн мал, амьтны халдварт өвчний эсрэг вакцин худалдан авснаас 18 өвчний эсрэг вакциныг Биокомбинат ТӨҮГ-аас, бусад 3 өвчний эсрэг вакциныг импортоор худалдан авсан байна.

2.12.4 МЭЕГ нь Биокомбинат ТӨҮГ-ийн вакцины агуулахыг түрээсэлдэг боловч тус агуулахын хүчин чадал, багтаамж улсын нөөц болон өөрсдийн үйлдвэрлэсэн вакцин био бэлдмэлийг хадгалахад хүрэлцэхгүй, агуулахын стандартын шаардлага хангахгүй, хөргөх хэрэгслээр тоноглогдсон боловч зохих хэмд хөргөж чаддаггүй мөн хадгалах горимын тэмдэглэл хөтөлж, хадгалах нөхцөлд хяналт тавьдаггүй байна.

2.12.5 2021 онд 21 аймгийг 405.3 сая төгрөгийн өртөг бүхий хөргүүрийн өрөө, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр хангасан, үүнээс МЭЭСБУЛ, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж ажиллахгүй байна.

2.12.6 Мөн МЭЕГ нь хөлдөөгч, хөргүүртэй зориулалтын тээврийн хэрэгслээр хангагдаагүй, түрээсийн тээврийн хэрэгслээр био бэлдмэлийг орон нутагт хүргэхдээ аймгуудыг бүсчилж, дунджаар 2-3 хоногт хүргэдэг ба энэ хугацаанд тээвэрлэлтийн горимд хяналт тавьсан бүртгэл хөтөлдөггүй, хүйтэн хэлхээний хэмийн хэмжилт хийх зориулалттай баталгаажуулсан термометр байхгүй байна.

2.12.7 2022 онд ХХААХҮС-ын 2022 оны А/204 тоот тушаалаар Бог малын мялзан өвчинтэй тэмцэх стратеги" боловсруулж, 2023 он гэхэд мялзан өвчингүй улс болох зорилтын хүрээнд 3 үе шаттай 44 арга хэмжээ хэрэгжүүлж, 354.6 сая төгрөгийн үнэ бүхий 3 сая тун вакцинаар дархлаажуулсан боловч тус онд 12 аймгийн 54 суманд 99 голомт бүртгэгдэж, үйлчилгээний зардал 2023 онд 22.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж өмнөх оноос 3.9 дахин өссөн боловч дархлаажуулалт үр дүнгүй болсон байна.

Хүснэгт 12. Дархлаажуулалтын зардал 2022-2023 он

Зардлын төрөл	2022 он (тэрбум.төг)	2023 он (тэрбум.төг)	Өсөлт (тэрбум.төг)	Өсөлтийн хувь (%)
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13.3	25.4	12.1	90.6%
Үйлчилгээний хөлс	7.7	30.5	22.7	291.2%

Эх сурвалж: Дархлаажуулалтын гүйцэтгэл

2.12.8 Мөн төлөвлөлтийг буруу хийснээс улсын нөөц болон өмнөх онуудад хуримтлагдсан 0.5 сая тун буюу 114.4 сая төгрөгийн үнэ бүхий вакцин бэлдмэлийн хугацаа дууссан байна.

2.12.9 МЭЕГ-ын даргын 2023 оны А/58 дугаар тушаалаар баталсан “Вакцин, био бэлдмэлийг хүлээн авах, хүлээлгэн өгөх, тээвэрлэх явцад баримтлах” журмыг мөрдөж ажиллаагүй, хүйтэн хэлхээний горим алдагдсанаас вакцин био бэлдмэлийн чанар муудах, малын дархлаажуулалт үр дүнгүй болох эрсдэл өндөр байна.

2.13 Сүхбаатар, Ховд аймагт бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт үр дүнгүй болж 280.8 сая төгрөгийн вакцин, бэлдмэл, 396.7 сая төгрөгийн үйлчилгээний хөлс, нийт 677,6 сая төгрөгийн хохирол учирсан байна.

2.13.1 2024 онд малын бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нийт 11.3 сая толгой төл мал дархлаажуулалтад хамруулахаар төлөвлөснөөс 10.9 сая төл малыг хамруулсан байна.

2.13.2 Тус ажлын хүрээнд тарилгыг 19 аймгийн 816 үйлчилгээний нэгж гүйцэтгэж, 2,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 11,4 сая тун вакцин зарцуулж, үйлчилгээний хөлсөнд 4.3 тэрбум төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 13. 2022-2024 онд малын бруцеллөз өвчнөөс сэргийлэх вакцинд хамрагдсан малын тоо, улсын төсвөөс зарцуулсан зардал

он	Аймгийн нэр	Хамрагдсан төл мал	Зарцуулсан вакцин /Тарих тун 1мл буюу 1тун/	Нийт вакцин, шингэлэгчийн үнэ /мян.төг/	Үйлчилгээний хөлс /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
2022 он	Сүхбаатар аймаг	963,135.0	963,135.0	156,027.9	254,464,350.0	254,620,377.9
	Ховд аймаг	681,486.0	681,486.0	110,400.7	177,933,900.0	178,044,300.7
	Улсын хэмжээнд	12,703,403.0	12,703,403.0	2,057,951.3	3,331,518,350.0	3,333,576,301.3
2023 он	Сүхбаатар аймаг	963,717.0	963,717.0	211,054.0	254,989,250.0	255,200,304.0
	Ховд аймаг	456,844.0	456,844.0	100,048.8	120,746,600.0	120,846,648.8
	Улсын хэмжээнд	12,155,828.0	12,155,828.0	2,662,126.3	3,206,512,600.0	3,209,174,726.3
2024 он	Сүхбаатар аймаг	380,983.0	389,420.0	85,283.0	147,015,500.0	147,100,783.0
	Ховд аймаг	673,833.0	676,500.0	148,153.5	249,706,700.0	249,854,853.5
	Улсын хэмжээнд	10,990,321.0	11,386,202.0	2,493,578.2	4,341,880,500.0	4,344,374,078.2

2.13.3 Тус дархлаажуулалтын дараах үр дүнг УМЭАЦТЛ-иос 2024 онд малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хийсэн вакцины тандалтаар Сүхбаатар аймаг 0 хувь буюу үр дүнгүй, Ховд аймаг 25 хувьд нь эерэг бие илэрч, улсын дундаж 62.8 хувьтай гарч тус дархлаажуулалт үр дүнгүй болсон байна.

Хүснэгт 14. Малын бруцеллёз өвчний эсрэг дархлаажуулалтын дараах үр дүнд хийсэн тандалт судалгааны дүн. УМЭАЦТЛ, 2024 он

Удталгааныг дүн: УМОНД 131, 2024 он						
№	Аймгийн нэр	Сумын нэр	Авсан дээж	Эерэг сорьц	Сум %	Аймаг %
1.	Архангай	Булган	112	97	86.6%	87.4%
		Өндөр-Улаан	112	92	82.1%	
2.	Булган	Гурванбулаг	112	112	100%	99.5%
		Баяннуур	112	112	99.1%	
3.	Ховд	Мянгад	112	13	11.6%	25%
		Буянт	112	43	38.4%	
4.	Увс	Наранбулаг	112	74	66%	71%
		Тариалан	112	6	5%	
5.	Сүхбаатар	Асгат	112	-	0	0%
		Сүхбаатар	112	-	0	
6.	Сэлэнгэ	Алтанбулаг	112	87	77.6%	75.4%
		Баянгол	112	82	73.2%	
7.	Дундговь	Говь-Угтаал	112	90	80.4%	81.3%
		Дэлгэрцогт	112	92	82.2%	
	Улсын дундаж					62.8%

2.13.4 Мөн төлөвлөгөөт дархлаажуулалтыг 2022, 2023, 2024 онд тус тус тухайн оны эхний улиралд баталсан, тархвар зүйн судалгааны үндсэн дээр бодитой төлөвлөөгүй, урьдчилан сэргийлэх вакциныг өвчин тус бүрээр хийвэл зохих цаг хугацаанд нь дархлаажуулж чадаагүй нь МАЭМТХ-ын 9.2³²-т заасныг зөрчсөн тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.13.5 Мал, амьтны дархлаажуулалтыг 2024 онд өмнөх оноос нэмэгдүүлсэн боловч Засгийн газрын 2018 оны 225 дугаар “Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах

³² “Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

тухай” тогтоолоор баталсан “Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт өвчин”-ний жагсаалтад багтсан өвчлөл 2022-2024 онд өсөж, зарим өвчин шинээр бүртгэгдэж, тархалт буураагүй байна. Тухайлбал:

- Олон улсын худалдаанд саад хориг үүсгэдэг гоц халдварт өвчин болох “Хонины цэцэг” өвчинд 2023 онд 4,335 мянган толгой мал, 2024 онд 15,966 мянган толгой малд 3.6 дахин нэмэгдүүлэн дархлаажуулсан боловч өвчлөл буураагүй нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тодруулбал: 2023 онд 6,308 мянган толгой мал өвчилсөн бол, 2024 онд 11,386 мянган толгой мал өвчилж, өмнөх оны мөн үеэс 80.5%-аар өссөн байна.
- Улсын төсвөөр санхүүжүүлж буй дархлаажуулалтын зардал 2024 онд өмнөх оны мөн үеэс 40.48% буюу 325.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, халдварт өвчин 2024 онд өмнөх оноос 63.2%-аар, шимэгчтэх өвчний халдвар 47.8%-аар тус тус нэмэгдсэн байна.

2.13.6 Мөн Монгол Улсад 1952 онд бүртгэгдсэн Ямааны годрон өвчин 2024 онд Дорноговь аймгийн Хатанбулаг суманд бүртгэгдэж, 15033 мянган толгой мал өвчилж устгасан байна. Сүүлийн жилүүдэд уг өвчлөлтэй холбоотой тандалт судалгааны үр дүнд ямааны годрон үүсгэгч илрээгүй тул дархлаажуулалтын төлөвлөгөө, улсын нөөцөд тус вакцины нөөцийг бэлдээгүй байна.

2.14 Вакцин худалдан авахдаа хууль зөрчсөн байна.

2.14.1 МЭЕГ 2024 онд *шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах* малын халдварт өвчний вакцины худалдан авах ажиллагааг зохион байгуулж гадаадын үйлдвэрлэгч байгууллагаас худалдан авсан байна.

2.14.2 Тус худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчсөн байна. Үүнд:

- Үнэлгээний хорооны хурлаар тус 3 вакцины техникийн тодорхойлолтыг баталсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 12.1³³, 50.2³⁴-т заасныг тус тус зөрчсөн,
- Үнэлгээний хорооны 2 гишүүнийг чөлөөлсөн боловч нөхөн томилоогүй ТБОНӨХБАҮХАТХ-ын 50.7³⁵-т заасныг зөрчсөн, Үнэлгээний хорооны гишүүдийн ирц дөрөвний гурваас бага байхад хуралдаж шийдвэр гаргасан нь 51.3³⁶-т заасныг зөрчсөн,
- Худалдан авах ажиллагаанд оролцогч байгууллага нь тендерийн баталгааг цахим системээр ирүүлээгүй, тендер нээхээс татгалзах үндэслэл үүссэн байхад сонгон шалгаруулалтыг үргэлжлүүлж 23.3³⁷ дах заалтыг тус тус зөрчсөн байна.

2.14.3 Үнэлгээний хороо нь *Шүлхий, Үхрийн арьс товруутах* өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчний вакцин худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт боловсруулахдаа ДМАЭМБ-ын итгэмжлэгдсэн олон улсын лавлагаа лабораториор баталгаажсан вакцин худалдан авах шаардлагыг тусгасан, харин *Бог малын мялзангаас* сэргийлэх өвчний вакцин худалдан авах ажиллагаанд тус шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 12.4³⁸-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал,

³³ 12.1. Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

³⁴ 50.2. Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

50.2.1. тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах;

50.2.2. тендерийг нээх, хянан үзэх, үнэлэх;

50.2.3. захиалагчид энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх.

³⁵ 50.7. Үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон, энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан үүргээ зөрчсөн бол захиалагч түүнийг үнэлгээний хорооны гишүүний үүргээс чөлөөлж, шинэ гишүүн нөхөн томилно.

³⁶ 51.3. Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно.

³⁷ 23.3. Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг энэ хуулийн 22.7-д зааснаар ирүүлээгүй нь тендер нээхээс татгалзах үндэслэл болно.

³⁸ 12.4. “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно

- *Бог малын мялзанаас сэргийлэх өвчний вакцины техникийн тодорхойлолтод: AU-PANVAC” (African Union - Pan African Veterinary Vaccine Centre) буюу Африкийн Холбооны харьяа малын вакцины чанар хяналтын төв болон “CIRAD” (Centre de coopération internationale en recherche agronomique pour le développement) Францын хөдөө аж ахуйн судалгааны байгууллагын гэрчилгээтэй байх гэж тусгайлан шаардлага тавьж нэг байгууллагад давуу эрх олгосон байна.*

Хүснэгт 15. Худалдан авалтын мэдээлэл

ХАА-ны нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Үзүүлэлтүүд	Dollvet	Hester biosciences Africa	Шалгарсан байгууллага, шалтгаан
Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцин худалдан авах	2,806.6	Тендерийн үнийн санал	2,799.5 /сая.төг/ 828,000 /USD/	2,789.3 /сая.төг/ 825,000 /USD/	“Hester biosciences africa limited” /нийт үнийн санал бага, нийлүүлэх барааны тоо их /
		Нийлүүлэх барааны тоо	18,0 сая тун, нэг бүрийн үнэ 155,5 төгрөг	18,2 сая тун, нэг бүрийн үнэ 153,2 төгрөг	
Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх олон улсын лавлагаа лабораториор баталгаажсан peetling омгоор үйлдвэрлэсэн вакцин худалдан авах	2,420.5	Тендерийн үнийн санал	2,366.7 /сая.төг/ 700,000 /USD/	2,405.6 /сая.төг/ 711,500 /USD/	“Dollvet Biotechnology Joint Stock Company” /нийт үнийн санал бага нийлүүлэх барааны тоо бага, ДМАЭМБ-ын зөвшөөрөлтэй/
		Нийлүүлэх барааны тоо	2,2 сая тун нэг бүрийн үнэ 1,075,7 төгрөг	2,5 сая тун нэг бүрийн үнэ 962,2 төгрөг	

2.14.4 Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах нийлүүлэгчийн сонгон шалгаруулах 11,629.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд ОХУ-ын “FGBI ARRIAN” компани 10,5 сая тун, нэг бүрийн үнэ 1,081 төгрөг нийт үнийн санал 11,617.4 сая төгрөгөөр ирүүлж хамгийн сайн тендерээр шалгарч тус вакциныг нийлүүлсэн байна.

2.14.5 МЭЕГ дээрх вакциныг худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлээгүй, техникийн тодорхойлолтыг хуулийн шаардлагын дагуу боловсруулаагүй үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТХ, журмыг зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

2.15 Хүнсний сүлжээнээс түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах ажил хэрэгжихгүй байна.

2.15.1 ХБАБХТХ-ийн 8 дугаар зүйлд³⁹ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд хүнсний сүлжээнээс татан авах, устгах талаар хуульчилсан. Үүнд:

- *хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл гарсан;*
- *тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүйн үзүүлэлтийг хангаагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг хяналт шалгалтаар тогтоосон;*
- *тухайн импортолсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулын талаарх сэрэмжлүүлэг олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн.*

2.15.2 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”-ын 3⁴⁰-т дотоодод үйлдвэрлэсэн, импортолсон хүнсний түүхий, эд бүтээгдэхүүн эрүүл ахуйн болон аюулгүй байдлын үзүүлэлтийн шаардлага хангаагүй, олон улсын мэдээллийн сүлжээгээр аюулын

³⁹ 8.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл тэдгээрийг хүнсний сүлжээнээс буцаан авна.

⁴⁰ Шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээлэх

талаар сэрэмжлүүлэг гарсан бол хяналтын байгууллага олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэрэглэгчдэд мэдээлэх үүрэгтэй боловч тус ажил хэрэгжихгүй байна.

2.15.3 Мөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах үйл ажиллагааг 24 цагийн дотор зохион байгуулж⁴¹, тухайн бүтээгдэхүүнийг бүртгэх ёстой боловч лабораториуд бүтээгдэхүүнээс дээж авахдаа цуврал, сериал дугаар зэрэг тодорхойлолтын мэдээллийг цахим бүртгэлийн системд бүртгэхгүй байгаагаас хэрэгжих боломжгүй байна. Тухайлбал,

- Тухайн хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн хэмжээг тогтоох боломжгүй тул хяналт, эрсдэлийн үнэлгээ хийхэд бэрхшээлтэй;
- Хүнсний бүтээгдэхүүний бохирдол сүлжээний анхан шатны үйлдвэрлэл, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдаалах аль үе шатанд үүссэн эсэхийг тогтоох боломжгүй,
- Гарал үүслийн мөрдөн тогтоолт хийх боломжгүй болсноор аюултай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэгчдэд хүрэх өндөр эрсдэлтэй,
- Шинжилгээний үр дүнг лавлагаа лабораторид давтан шинжлэх, харьцуулсан үнэлгээ хийх боломжгүй,
- Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүн хэрэглэгчдэд хүрэх эрсдэл нэмэгдэж, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэж байна.

2.15.4 Эдгээр шалтгаануудын улмаас хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулах, илэрсэн зөрчилд бодитой, нотолгоонд суурилсан хариу арга хэмжээ авах төлөвлөгөө, үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байна.

2.15.5 Тус журмын 4.3.2⁴²-т заасны дагуу хүнсний бүтээгдэхүүн татан авах шийдвэрийг 2 цагийн дотор гаргах, 4.3.6⁴³-т заасан мэдээллийн сан бүрдүүлж хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах зэрэг ажлуудыг хэрэгжүүлээгүй байна.

2.15.6 Мөн ХБАБХТХ-ийн 8.11⁴⁴-т заасан мэдээллийн санг бүрдүүлж, нийтэд мэдээлээгүй, импортын болон дотоодын гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг бодитой хянах, эрсдэлийг бууруулах хяналтын байгууллагын хариуцлагын тогтолцоо сул, баталгаажуулалтын байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.16. Импортоор оруулж ирж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналт тогтолцооны өөрчлөлтөөс үүдэлтэй буурч, холбогдох хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажил удаашралтай байна.

2.16.1 Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүний импорт сүүлийн жилүүдэд нэмэгдэж 2024 онд 276.7 сая тн-д хүрч 2022 оноос 62.1 хувиар өссөн байна. Гэвч импортын өсөлттэй уялдан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах хяналт шалгалтын тогтолцоо нь эрх зүйн зохицуулалт, хяналтын арга зүйн өөрчлөлтийг бүрэн хийгээгүй нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн хэрэглээнд нийлүүлэгдэх, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

2.16.2 МУЗГ-ын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүргийг Гаалийн байгууллагад нэгтгэж, 504 албан хаагч болон Цагааннуур, Боршоо, Булган, Арцсуурь, Бургастай,

⁴¹ 4.2.2. хяналтын байгууллагын шийдвэрийг үндэслэн өөрт хамаарах хүнсний сүлжээний дараагийн үе шатнаас шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг 24 цагийн дотор багтаан татан авах үйл ажиллагааг зохион байгуулж, энэхүү журмын хавсралтад заасан “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх маяг” бүртгэлийг хөтлүүлнэ;

⁴² энэхүү журмын 3.1.3, 3.1.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах тухай албан ёсны шийдвэрийг 2 цагийн дотор багтаан гаргана

⁴³ татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, уг мэдээллийн санг хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглана.

⁴⁴ Хяналтын байгууллага энэ хуулийн 8.2-т заасны дагуу татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ.

Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайт дахь хилийн боомтын хяналтын итгэмжлэгдсэн лабораторийг Гаалийн ерөнхий газрын харьяанд шилжүүлсэн.

2.16.3 2022 оноос импортын хүнсний бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтыг Гаалийн байгууллага хэрэгжүүлж улсын хилээр нэвтрүүлсэн бараа бүтээгдэхүүний 15 орчим хувийг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эзэлж байна.

2.16.4 Гаалийн байгууллагын хяналт шалгалтын цахим систем (CAIS) нь эрсдэлийг урьдчилан тооцоолж хяналт шалгалтын үйл явцыг хөнгөвчлөх, хууль сахин мөрдөлтийн түүх, статистик мэдээлэл зэрэг урьдчилан оруулсан өгөгдөлд тулгуурлан гаалийн хяналтын төлөв сонгогдож хяналт шалгалт хийж байна.

Хүснэгт 16. Гаалийн байгууллагын эрсдлийн удирдлагын (CAIS) автомат системийн төлөв

Төлөв	Шалгалтын төрөл	Эрсдлийн ангилал	Төлөв өөрчлөх боломж
Улаан	Бичиг баримтын + Биет шалгалт	Өндөр эрсдэлтэй	Заавал биет болон баримт бичгийн шалгалт
Улбар шар	Зөвхөн бичиг баримтын шалгалт	Дунд эрсдэлтэй	ГУАБ улбар шарыг улаан төлөвт оруулна.
Ногоон	Шалгалт хийхгүй	Бага эрсдэлтэй, хөнгөлөлттэй	Боломжгүй

2.16.5 Гаалийн байгууллага дараах нөхцөл байдлын улмаас Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁴⁵, 13.2⁴⁶-т заасан импортын хүнсний бүтээгдэхүүнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна. Үүнд:

- “CAIS” цахим системийн эрсдэлийн шалгуур тодорхой бус, ил тод байдал хангагдаагүй;
- Хяналтын төлөв өөрчлөх эрх зөвхөн “улбар шар” төлөвт хязгаарлагдсан;
- Засгийн газрын 2014 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Импортын барааны эрсдэлийг тодорхойлох шалгуур”-тай CAIS системийн шалгуур үзүүлэлт уялдаагүй;
- “Ногоон” төлөвт хамрагдсан бараанд санамсаргүй түүврийн аргаар хяналт шалгалт хийх зохицуулалт байхгүй;
- “Ногоон” төлөвөөр аюулгүй байдлын шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн импортлох эрсдэлтэй;
- Лабораторийн шинжилгээний үзүүлэлтийн хүрээ хязгаарлагдмал, ГУБ-ын дүгнэлт нь бүтээгдэхүүний онцлог, аюулгүйн үзүүлэлтэд тулгуурладаггүй,
- Эрх бүхий байгууллагын баталсан аюулгүйн үзүүлэлтүүдийг бүрэн хамруулдаггүй,
- Шинжээч-ГУБ хүнсний бүтээгдэхүүнд дүгнэлт гаргахдаа бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ, хууль, техникийн зохицуулалт, хадгалах нөхцөл, тээвэрлэлт, сав баглаа боодол, шошгын мэдээлэл, экспортлогч орны чанарын баталгаажуулалтын баримт бичиг, аюулгүйн үзүүлэлт зэрэг шалгуур үзүүлэлтийг үндэслээгүй,

Хүснэгт 17. Импортийн хүнсний өөрчлөлт /2022-2024 он/

№	Барааны нэр	2022 он	2023 он	2022-2023он өөрчлөлт	2024 он	2023-2024 он өөрчлөлт
1	Мах, махан бүтээгдэхүүн /тн/	30,410.6	36,187.6	+18.9%	41,343.4	+14.2%
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн /тн/	12,790.6	14,112.9	+10.3%	14,302.37	+1.3%
3	Шувууны өндөг /мян.ш/	186.5	183.5	-1.6%	98.3	-46.4%
4	Хүнсний ногоо /тн/	42,382.9	48,879.1	+15.3%	64,179.6	+31.2%
5	Улаанбуудайн гурил /тн/	426.6	11,142.1	+2512%	63,664.9	+471%

⁴⁵ Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийнэ.

⁴⁶ Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна.

“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ҮР ДҮН”						
6	Боловсруулсан хүнс /тн/	33,455.6	28,610.1	-14.5%	33,074.4	+15.6%
7	Гурилан бүтээгдэхүүн /тн/	41,836.3	43,137.1	+3.1%	48,422.2	+12.3%
8	Давс, натри, далайн ус /тн/	9,421.5	12,429.9	+31.9%	11,745.2	-5.5%

2.16.6 Монгол улсад 2022 онд 170.7 сая тн, 2023 онд 194.5 сая тн (+13.9% өсөлт), 2024 онд 276.7 сая тн (+42.2% өсөлт) хүнс импортлогдсон бөгөөд 2024 онд улаан буудайн гурил, хүнсний ногооны импорт огцом өссөн байна.

Хүснэгт 18. Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хяналт шалгалтад хамрагдсан тоон үзүүлэлт. 2022-2024 он

№	Хяналтын чиглэл	2022 он		2023 он		2024 он	
		Хэмжээ	Зөрчил	Хэмжээ	Зөрчил	Хэмжээ	Зөрчил
1	Мал эмнэлгийн хяналт /тн/	18,510.0	0	23,789.4	0	23,600.3	3
	Мал эмнэлгийн хяналт /ш/	4250 тун /вакцин/		165920 ш		566886ш	
2	Ургамал хорио цээрийн хяналт	153,666.0	9	154,943.0	18	223,617.0	1
3	Хүнсний чанар, стандартын хяналт	143,776.6	6	105,322.4	10	95,703.3	3
4	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт	67,517.4	3	115,601.0	8	151,856.8	8
	Нийт /тн/	383,470.0	18	399,655.8	36	494,777.4	15

2.16.7 Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь мал эмнэлэг, ургамал хорио цээр, эрүүл ахуй халдвар хамгаалал, хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд чанар, аюулгүй байдлын хяналт шалгалт хийж, импортын хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 2024 онд өмнөх оноос 23%, 2022 онтой харьцуулахад 29%-иар өссөн, үүнээс ургамал хорио цээр, мал эмнэлгийн хяналтын чиглэлд хамаарах бараа бүтээгдэхүүний импорт хамгийн их өссөн байна.

2.17 Анхан болон давтан шинжилгээний үр дүнгийн зөрүүтэй байдал нь импортын хүнсний чанар аюулгүй байдлын хяналт, баталгаажуулалт алдаатай байгааг харуулж байна.

2.17.1 Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хяналт шалгалтаар илрүүлсэн, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүний нэр төрлийг 2022-2024 оны хооронд харьцуулж үзвэл:

- Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн 4,3%
- Ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн 40,6%
- Бэлэн хүнсний бүтээгдэхүүн, ундаа, согтууруулах ундаа, тамхины төрлийн бүтээгдэхүүн 55,1% -ийг эзэлж байна.

2.17.2 Ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний зөрчил 2022-2023 онд дийлэнх хувийг эзэлж байсан бол 2024 онд огцом буурсан байна.

Хүснэгт 19. Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хяналт шалгалтаар илрүүлсэн, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний шийдвэрлэлт. 2022-2024 он

№	Шаардлага хангаагүй бүтээгдэхүүний зөрчлийн утга	Шийдвэрлэлт	Зөрчлийн тоо	Тайлбар
1	Гадаад хорио цээртэй шавьж	Нэвтрүүлсэн	6 (21.4%)	Давтан шинжилгээгээр илрээгүй

	Гадаад хорио цээртэй шавьж	Устгасан	2 (7.1%)	2023 онд 171.4 тн, 2024 онд 23.8 тн цагаан будаа,
	Гадаад хорио цээртэй шавьж илэрсэн	Шийдвэрлээгүй	3 (10.7%)	Шүүхийн маргаантай, шийдвэрлээгүй, /2022 онд 357.2 тн цагаан будаа/ 2023 онд 119 тн/
2	Дотоод хорио цээртэй шавьж илэрсэн	Нэвтрүүлсэн	15 (53.6%)	Мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлтэд хамруулж, торгох шийтгэл оногдуулсан
3	Хөгц мөөгөнцөр, бусад бохирдуулагч илэрсэн	Устгасан	2 (7.1%)	2022 онд 10 тн саримс, 2023 онд 20 тн саримс, цагаан будааг устгасан
	Нийт		28 (100%)	

2.17.3 2022-2024 оны хооронд илрүүлсэн, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний зөрчлийн утгыг харьцуулж үзвэл 39.3 хувийг гадаад хорио цээртэй шавьж, түүний өндөг авгалдай, үхсэн хэлбэрээр, биеийн хэсэг, 53.6 хувьд дотоод хорио цээртэй шавьж, 7.1 хувьд хөгц мөөгөнцрийн бохирдол илэрсэн байна.

2.17.4 Дээрх аюулгүй байдлын шаардлага хангаагүй ургамлын гаралтай импортын бүтээгдэхүүний зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг харьцуулж үзвэл:

- 75 хувийг Монгол улсын хилээр нэвтрүүлсэн,
- 14.2 хувийг устгасан,
- 10.7 хувийг түр саатуулж шүүхийн маргаантай, эцэслэж шийдвэрлэгдээгүй байна.

2.17.5 Ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс авсан дээжид хийсэн лабораторийн шинжилгээгээр гадаад хорио цээртэй шавьж илэрч дахин хяналтын дээж авч шинжилгээнд хамруулахад өмнөх шинжилгээний үр дүнгээс зөрүүтэй буюу аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан үр дүн гарсан тохиолдол 21.4 хувь байна. /Улаанбаатар хот дахь Гаалийн газрын Хорио цээрийн албаны “Эерэг сорьцын 2022-2024 оны шийдвэрлэлтийн тайлан/

2.17.6 Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хяналт шалгалтад хамрагдаж буй бүтээгдэхүүний дээж ХАБҮЛЛ-ийн ургамал хорио цээрийн лабораторид шинжилгээнд хамрагдаж, тус бүтээгдэхүүний түүвэр болон хяналтын дээжийг дахин шинжлэхэд үр дүн зөрүүтэй гарч байгаа нь лабораторийн шинжээчийн үр чадвар, ашиглаж буй багаж хэрэгслийн чанарын шаардлага, шинжилгээнд зориулж түүвэр дээж авч буй ажиллагаа болон хяналтын дээж авах, загвар дээжийг шинжлүүлэх зэргээр маргаан бүхий дээжийн төлөөлөх байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах эрсдэлтэй байна.

2.17.7 ГЕГ-ын даргын 2024 оны А/422 дугаар тушаалаар “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам” батлагдсан байх боловч уг журамд аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг давтан шинжилгээнд хамруулахдаа загвар болон хяналтын журмаар авсан дээжийн алинд нь маргаан таслах шинжилгээ хийлгэх, мөн тушаалын хавсралтаар “Дээжийг хадгалах хугацаа, нөхцөл”-ийг журамласан байх боловч загвар дээжийг хадгалах, хамгаалах, хэрэглэх талаар зохицуулаагүй, давтан шинжилгээнд хамрагдаж байгаа хяналтын дээж нь өмнөх дээжийг төлөөлөх чадвартай эсэх нь тодорхойгүй, лабораторийн шинжилгээний үр дүнгийн зөрүү, үл тохиролыг илрүүлэх, залруулах арга хэмжээ тодорхойгүй байна. Тухайлбал:

- Улаанбаатар хот дахь Гаалийн газрын ГУБ нь импортын мах, махан бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийхдээ Амьтан, ургамал, түүхий эдийн импортын гэрчилгээ бичиж хилээр нэвтрэх зөвшөөрөл өгсөн байна. УМЭАЦТЛ-ийн шинжилгээний үр дүнд үндэслэн дүгнэлт бичихдээ шинжлүүлээгүй үзүүлэлтүүд болох хүнд металл, цацрагийн бохирдлыг аюулгүй түвшинд байна гэж алдаатай дүгнэсэн байна.

2.17.8 Энэ нь гаалийн хяналтын бүсүүдэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэгтэй хорио цээрийн ахлах байцаагчийг томилж ажиллуулаагүй, хяналт сул байх нөхцөлийг бий болгож байна.

2.18 Гаалийн байгууллагад аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг шийдвэрлэх үе шатанд хяналт тавих тогтолцоо бүрдээгүйгээр хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл өндөр байна.

2.18.1 2022-2024 онд Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хорио цээрийн хяналт шалгалтаар ургамлын гаралтай импортын хүнсний бүтээгдэхүүнд илрүүлсэн нийт зөрчлийн 53,6%-д дотоод хорио цээртэй шавж илэрсэн байна.

2.18.2 Гаалийн байгууллага нь уг зөрчлийг мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл, устгал хийлгэж, зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу торгох шийтгэл оногдуулан хилээр нэвтрүүлсэн байх боловч уг шийдвэрийг гаргахдаа бүтээгдэхүүнд халдваргүйтгэл, шавж устгал хийлгэсний дараах химийн хортой бодисын үлдэгдлийн шинжилгээ хийлгээгүй байна.

2.18.3 Энэ нь хүнсний бүтээгдэхүүн химийн хорт бодисоор бохирдох, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн импортлогдох эрсдэлийг үүсгэж байна.

2.18.4 Шаардлага хангаагүй ургамлын гаралтай бүтээгдэхүүний 14.3%-д устгах арга хэмжээ авсан байна.

2.18.5 Шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, шүүхийн шатанд маргаантай байгаа тохиолдол нь бараа бүтээгдэхүүний жингээр хамгийн их (476.2 тн) хувийг эзэлж байна.

2.18.6 Энэ нь хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тодорхой биш, Гаалийн тухай хууль тогтоомжид хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангуулах талаар зохицуулалтыг тусгаагүйгээс шийдвэр гаргах ажиллагааг удаашруулж байна.

2.18.7 Гаалийн тухай хуулийн 19.2-т “Гомдолд дурдсан шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байх хангалттай үндэслэл байгаа, эсхүл тухайн шийдвэрийг биелүүлснээр үлэмж хэмжээний хохирол учрахаар бол гомдлыг хүлээн авсан гаалийн байгууллага, албан тушаалтан уг шийдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно” гэж заасныг үндэслэл болгож аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүний шийдвэрлэлтийг тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авч байгаа нь дараах эрсдэл бүхий нөхцөл бүрдүүлж байна.

- Удаан хугацаагаар битүүмжилснээс хадгалах нөхцөл алдагдал, хадгалалтын хугацаа дууссанаас бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал алдагдах
- Гадаад хорио цээртэй шавж хил дамжин халдварлах, өсөж үржиж Монгол улсад нэвтэрч хүрээлэн буй орчны бохирдол үүсгэх
- Хэрэв бүтээгдэхүүн шаардлага хангасан талаар тогтоогдвол Аж ахуйн нэгжид эдийн засгийн хохирол учрах эрсдэлтэй байна.

2.18.8 Мөн импортын хүнсний бүтээгдэхүүнд заавал тодорхойлох чанар, эрүүл ахуйн болон аюулгүйн үзүүлэлтүүдийн хамрах хүрээг тогтоогоогүй, бүтээгдэхүүний бохирдуулагчийн эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаа хийдэггүй, шинжилгээний үзүүлэлтийг нэр төдий, цөөн үзүүлэлт сонгож, хязгаарлагдмал хүрээнд шинжлүүлж байна. Тухайлбал,

- Шинэ Зеланд улсаас 2025 оны 4 сард импортлогдсон 23 тонн алиманд Улаанбаатар хот дахь Гаалийн газар хяналт шалгалт хийхдээ алимны дээжид ХАБҮЛЛ-д зөвхөн хөнөөлт шавж, хачиг илрүүлэх шинжилгээ хийлгэж, пестицид, хүнд металлын шинжилгээ хийлгээгүй байна.

2.18.9 Гэтэл жимс жимсгэнэ нь ХАБҮЛЛ-иас 2024 онд хийсэн тандалт судалгаагаар пестицидийн эрсдэл өндөр болохыг тогтоосон байхад бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ, онцлогийг харгалзан үзэж шинжилгээний үзүүлэлтийн хамрах хүрээг тогтоохгүй байна.

2.18.10 ХАБҮЛЛ, УМЭАЦТЛ-ийн шинжилгээний хариу 14-21 хоногт буюу удаж гардгаас түргэн гэмтэж муудах, хадгалалтын нөхцөл шаарддаг хүнсний бүтээгдэхүүнийг Гаалийн түр бүсэд 3 хоногоос дээш хугацаанд хадгалах боломжгүй, Гаалийн бүсэд байрлах агуулахын хүрэлцээ хангамж бага байдгаас бүтээгдэхүүнийг төлөөлөх дээжийг шинжилгээнд хамруулсан боловч шинжилгээний хариу гараагүй байхад хяналтаас чөлөөлөх, ХАБҮЛЛ болон УМЭАЦТЛ нь шинжилгээний үр дүнгийн хуудсанд цуврал, серийн дугаарыг тэмдэглэж бичдэггүйгээс хяналтаас чөлөөлөгдсөн, аюулгүй байдлын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг буцаан татан авах боломжгүй байна.

2.19 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.19.1 Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” сэдэвт 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 24 зөвлөмж өгснөөс 45.8 хувь буюу 11 зөвлөмж хэрэгжиж, 54.2 хувь буюу 13 зөвлөмж хэрэгжээгүй байна.

2.19.2 Монгол Улсын Их хурлын анхааралд толилуулсан дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- “Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тус зөвлөлийн тайланг тогтсон хугацаанд авч хэлэлцэн, үр дүнг тооцож байхад анхаарлаа хандуулах”.

2.19.3 Монгол Улсын Засгийн газарт өгсөн дараах 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- “Засгийн газар болон яам, агентлагууд хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээг авч, хариуцсан ажилдаа хайхрамжгүй хандсан, үүргээ биелүүлээгүй эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллах”;
- Монгол Улсын Засгийн газарт “Хүнсний тухай хуулиар үүрэг болгосон “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах, хянах журам”, “Стратегийн хүнсний үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг урамшуулал, тэдгээрийг олгох журам”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, хүнсний аюулгүй байдлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, хүнсний хангамж, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах”.

2.19.4 Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд өгсөн дараах зөвлөмж хэрэгжээгүй байна.

- “Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах”;

2.19.5 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд өгсөн дараах 6 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- “Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмыг батлан мөрдүүлж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах”;
- “Малын эрүүл мэнд болон Малын эмийн нэгдсэн бүртгэл, хяналтын системийг уялдуулж, боловсронгуй болгох”;
- “Кодексын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Олон улсын хууль, эрх зүйн хорооноос гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн манай улсад мөрдөж байгаа зарим стандартыг шинэчлэх, хуульд тусгаагүй чухал ач холбогдолтой нэр томъёо, тодорхойлолтыг хуульд нэмж тусгах”;
- “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг боловсруулж батлан мөрдүүлэх”;
- “Хүнсний чанар, аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораториудын бүртгэлийн системийн уялдааг хангаж, хяналтын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх төрийн холбогдох бусад байгууллагын системтэй уялдуулах”;
- “Хүн амын хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол олгох талаар цогц ажлыг зохион байгуулж, үр дүнг үнэлж тооцох”;

2.19.6 Мөн лабораториудын үйл ажиллагаа, итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотой засч сайжруулах, шийдвэрлэх шаардлагатай дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- “Итгэмжлэлийн гэрчилгээний хугацаа дууссан төрийн болон хувийн хэвшлийн лабораториудын зөрчлийг арилган, лабораторийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөц, урвалж бодисыг шууд өртөг зардалтай нь уялдуулсан үнэ тарифын зохицуулалт хийж, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээг хугацаанд нь хийх, урсгал зардлаа өөрөө санхүүжүүлэх бололцоог бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг бүрэн хангахуйц шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх”.

2.19.7 Эрүүл мэндийн яаманд өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- “Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмыг батлан мөрдүүлж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах”;

2.19.8 Үндэсний статистикийн хороонд өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- “Хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын статистик мэдээг олон улсын түвшинд нийцсэн аргачлалаар, үнэн зөв, бодитой тооцох” зэрэг зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

2.19.9 Аудитаар өгсөн зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй байгууллага, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт

1. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл болон Засгийн газар болон яам, агентлагууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй, шаардлагатай эрх зүйн актыг шинэчлэн батлаагүйгээс дэвшүүлсэн бодлого, зорилт бодит үр дүнд хүрээгүй, хүнсний аюулгүй байдал хангагдаагүй хэвээр байна.
2. Төрөөс баримталж буй урт хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилттой нийцээгүй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн нь хүнсний аюулгүй байдлын бодлогын уялдаа, залгамж чанарыг алдагдуулж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах нөхцөл болсон байна.
3. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн бодлого, зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүйгээс хүнсний бие даасан байдал алдагдсан хэвээр, бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хүрээнд бий болох эерэг өөрчлөлт хангалтгүй, цаашид гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нэмэгдэх эрсдэлтэй байна.
4. Монгол Улсын Кодексын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа нь хүнсний аюулгүй байдал, экспортын боломжийг нэмэгдүүлэх, шинэ стандарт нэвтрүүлэхэд чухал үүрэгтэй ч зохион байгуулалт, үйл ажиллагаа хангалтгүй, уялдаа холбоо сул байгаагаас олон улсын хүнсний стандартыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажил удаашралтай байна.
5. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
6. Хүнсний аюулгүй байдлыг хянах төрийн байгууллагуудын дунд чиг үүргийн давхардал, үүрэг, хариуцлагын тодорхойгүй байдал үүсч, хүнсний аюулгүй байдлын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна.
7. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори чиг үүрэг бүрэн хэрэгжүүлдэггүй, хүнсний аюулгүй байдлыг хянах, мэдээллийг бүртгэх цахим системүүд хөгжүүлж, ашиглаж эхэлсэн хэдий ч нэгдсэн мэдээллийн сан үүсээгүй, бүх шатанд уялдсан цахим хяналтын системгүй байна.
8. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хийгдэж буй шинжилгээний дүнгүүдийг нэгтгэн, мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх, түүнийг удирдах тогтолцоо бүрэн бүрдээгүй, мэдээллийн урсгал, уялдаа холбоо хангалтгүй байна.
9. Хүнс, хүнсний түүхий эд бүтээгдэхүүн, хүнсний сав баглаа боодолд сорилт, шинжилгээ, баталгаажуулалт хийж буй лабораториуд нь батлагдсан аюулгүйн үзүүлэлтүүдийг бүрэн шинжилж чадахгүй, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.
10. Хүнсний салбарт мөрдөж буй стандартын 23 хувь нь хуучирч өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон, орчин үеийн багажийн шинжилгээний аргачлалын стандарт дутагдалтай байна.
11. Гаалийн байгууллага импортын хүнс, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, сав баглаа боодолд хяналт тавих эрх зүйн орчин бүрдээгүй, хүнсний аюулгүй байдлын эрсдэлд суурилсан хяналт хэрэгжүүлэхгүй байна.
12. Улсын болон гадаадын зээлийн хөрөнгөөр барьсан хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийх лабораторийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглаагүй шинжилгээ хийгээгүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.
13. УМЭАЦТЛ-ийн ашиглаж буй арга зүй, шинжилгээний аргачлалуудыг Стандартын техникийн хороогоор баталгаажуулаагүй байгаагаас шалтгаалан лаборатори хоорондын шинжилгээний дүнгийн зөрүү, итгэмжлэлийн шаардлагад нийцэхгүй, олон улсын хэмжээнд тохирлын баталгаажуулалтын үр дүн хүлээн зөвшөөрөгдөхгүй байх эрсдэл үүсч байна.

14. Олон улсын (Codex Alimentarius, Европын комиссын ЕС No.1881/2006, ЕС No.2073/2005) стандарт, журмуудад туссан бохирдуулагч бодисын ихэнх үзүүлэлтэд шинжилгээ хийгдэхгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлын хяналт, үнэлгээний бүрэн байдалд сөргөөр нөлөөлж, хяналтын тогтолцооны үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.
15. Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний бохирдуулагч үзүүлэлтүүдэд хийж буй шинжилгээ хангалтгүй, эрсдэлийн үнэлгээ 2022 оноос хойш хийгдээгүй, мөн аюулгүйн үзүүлэлтүүдийг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчлээгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлын хяналт, үнэлгээг бүрэн, бодитой хийх боломж хязгаарлагдаж өндөр эрсдэлтэй бохирдуулагч илрэхгүй байх, үндэсний стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилт хангагдахгүй байх, хяналтын тогтолцооны үр нөлөө буурах эрсдэлтэй байна.
16. Хүнсний сав баглаа боодол болон хүнстэй харьцах материалуудаас хүнсэнд шилжих химийн бодисын шинжилгээ Монгол Улсад хийгдэхгүй байгаа нь эдгээр бүтээгдэхүүнд хяналтгүй байдал үүсгэж, хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлж байна.
17. Хүнсний бүтээгдэхүүний сорилт, шинжилгээ хийж буй лабораториудын барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавх болон арга зүйн хэрэгжилт нь MNS ISO/IEC 17025:2018 стандартад нийцэхгүй байгаа нь лабораторийн үндсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, шинжилгээний чанар, итгэлцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
18. МЭЕГ нь вакцины агуулахын стандартын шаардлагыг хангаагүй, хүчин чадал болон хадгалалтын нөхцөл дутагдалтай агуулахыг ашиглаж байгаа нь улсын нөөц болон үйлдвэрлэсэн вакцин, биобэлдмэлийг зохих горимоор хадгалах боломжийг хязгаарлаж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
19. Импортын хүнсний бүтээгдэхүүний хэмжээ огцом өссөн хэдий ч хяналт, шалгалтын тогтолцоо эрх зүй болон арга зүйн хувьд бүрэн шинэчлэгдээгүй нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн хэрэглээнд нийлүүлэх, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
20. Хүнсний аюулгүй байдлын хяналттай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тодорхой бус байгаа бөгөөд Гаалийн тухай хууль тогтоомжид хорио цээрийн хяналт, хүнсний аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг тусгаагүй нь шийдвэр гаргах үйл явцыг удаашруулж, хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.
21. ХАБҮЛЛ болон УМЭАЦТЛ-ийн шинжилгээний хугацаа удаан, шинжилгээний хариуд цуврал, серийн дугаар тэмдэглэдэггүй зэрэг зохион байгуулалтын сул талууд нь түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний хяналт, хадгалалт, буцаан татан авах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Зөвлөмж:

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд:

1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргаж, тэдгээрийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх чиг үүргээ бүрэн үр дүнтэй хэрэгжүүлэх;
2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүнсний аюулгүй байдлын талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлох;
3. Хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар жил бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах ажлыг тогтмол хэрэгжүүлэх;
4. Хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын талаарх тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах чиг үүргээ хэрэгжүүлэх ;

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд:

1. Богино хугацааны бодлогын баримт бичиг нь дунд, урт хугацааны бодлогын зорилтод хүрэхээр тухайн жилд хэрэгжүүлэх, арга хэмжээний төлөвлөлт бүхий баримт бичиг байх бөгөөд ХБТТУтХ-ын - 5.1-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах нэгдмэл цогц, харилцан уялдаатай байх зарчмыг хэрэгжүүлэх.
2. "Улсын Их Хурлаас батлан гаргасан хүнсний аюулгүй байдлын талаарх тогтоолыг хэрэгжүүлэхдээ үндсэн зорилгыг бүрэн хангахуйц бодитой арга хэмжээг төлөвлөн, үр дүнг тооцож хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хуулийн зохицуулалт болон чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй болсон төсөл, арга хэмжээг холбогдох дээд шатны байгууллагад тухай бүр мэдэгдэн, шаардлагатай шийдвэр, арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.
3. Бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг зорилтот түвшинд нийцүүлэн үнэн зөв тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийх, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтмол тооцож, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хүнсний аюулгүй байдлын индекс тооцох аргачлалыг боловсруулж мөрдөх.
4. СТЗТүтХ-ийн 6.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж, гол нэрийн 16 төрлийн хүнсний бүтээгдэхүүний техникийн зохицуулалтыг боловсруулж ажиллах.
5. Кодексын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл, бараа бүтээгдэхүүний кодексын салбар зөвлөлүүдийг байгуулж, зөвлөлийн дүрэм батлах.
6. Хүнсний тухай хуулийн 15.3-т заасан мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн багийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дэргэд байгуулах.
7. Хүнсний тухай хуулийн 18.5-д заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх.
8. Мал аж ахуйн нэгдсэн систем болон мал эмнэлгийн гэрчилгээний системийн өгөгдлийн уялдаа холбоог (API холболт) бүрэн хангаж, мэдээллийн давхардал, зөрүүг арилгах, статистикийн мэдээллийн бодит байдлыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах, аймаг, сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн мэдээлэл оруулах хариуцлагыг дээшлүүлж, бүртгэлийн чанарыг сайжруулах.
9. “Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем”-ийн мэдээллийн бүрдүүлэлтийг сайжруулж, орон нутгийн мэргэжилтнүүдийн мэдээлэл оруулах үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, мэдээлэл цуглуулалтыг Excel файлаар бус системээр бүрэн хангуулах арга хэмжээ авч, системийн үр нөлөө, мэдээллийн бодит байдлыг хангаж ажиллах.
10. Газар тариалангийн нэгдсэн мэдээллийн сангийн программ хангамжийн хөгжүүлэлттэй холбоотой гэрээний шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, мобайл аппликейшнийг

ашиглалтад оруулах, мөн ГЕГ, ЦЕГ, ХАБҮЛЛ, ҮСХ, ХААДС зэрэг холбогдох байгууллагуудын мэдээллийн системүүдтэй уялдаа холбоог бүрдүүлж ажиллах.

11. “Сүү бэлтгэлийн системийн сайжруулалт, хэвийн ажиллагааг хангах, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мөшгөлт”-ийн системтэй холбох хөгжүүлэлтийн 2021 оны 01/24 дугаартай гэрээний ажлын даалгаварт заасан аналитик тооцоолол, шинжилгээний модуль хөгжүүлэх болон бусад гүйцэтгээгүй ажлуудыг бүрэн хэрэгжүүлж, гэрээний үүргээ биелүүлэн системийн бүрэн ажиллагааг хангаж ажиллах.

Эрүүл мэндийн яаманд:

12. Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн 6.2, 8.1.3-т заасан шаардлагын дагуу нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн ажиллах журмыг баталж, зөвлөлийн үйл ажиллагааг шуурхай эхлүүлэн зохион байгуулах

Мал эмнэлгийн ерөнхий газарт:

13. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлж, дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд, тандалт судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажиллах.
14. MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангах үүднээс шинжилгээний аргачлалын стандартуудыг шинэчлэн баталгаажуулах, хүчингүй болсон болон зөрүүтэй стандартуудыг хүчингүй болгох, лабораторийн үйл ажиллагааг итгэмжлэлийн хүрээнд нийцүүлэх арга хэмжээ авч ажиллах.
15. Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн цахим системийн хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээ, хөгжүүлэлт болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд мэргэжлийн мэдээллийн технологийн ажилтныг томилж, хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх.
16. Лабораторийн мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор сорьцын анхан шатны мэдээллийн бүрдүүлэлт, хяналтыг сайжруулах, мэдээлэл буруу, дутуу бүртгэгдэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын механизм нэвтрүүлэх, MNS ISO/IEC 17025:2017 стандартын 7.11.3-т заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллах

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд:

17. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний лавлагаа лабораторийн мэдээллийн удирдлагын найдвартай байдлыг хангах зорилгоор зориулалтын лабораторийн цахим системийг хөгжүүлж, мэдээллийн аюулгүй байдал, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, гараар мэдээлэл оруулахаас гарах алдаа, давхардлыг арилгах, ажлын үр ашиг, мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах
18. Лавлагаа лабораторийн шинжилгээний үр дүнгийн сорилтын хуудаст итгэмжлэгдсэн болон итгэмжлэгдээгүй үзүүлэлтийг тодорхой ялган, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тэмдэглэх, MNS ISO/IEC 17025:2018 стандартын 7.8.1.1, 7.8.2-т заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллах

Стандарт, хэмжил зүйн газарт:

19. СТЗТҮИтХ-ийн 25.3.2-т заасан үндэсний стандартыг батлах, бүртгэх, албан ёсны эхийг хадгалах чиг үүргээ хэрэгжүүлж, ашиглах хугацаа дууссан стандартуудыг хүчингүй болгож, үндэсний стандартыг олон улсын стандартын түвшинд шинэчлэн хөгжүүлэх, олон улс, бүс нутгийн болон хоёр талын стандартчиллын хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг авч ажиллах
20. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори болон сүлжээ 23 лабораторийг нэгтгэж зохион байгуулалтын шинэчлэлийг нарийвчлан журмаар

- зохицуулж, Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолын нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, шинэчлэх арга хэмжээг авч ажиллах
21. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар лабораторид пестицид, хүнд метал, хор судлалын шинжилгээ хийх шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж, оношлуураар хангах,
22. MNS 4377:1996 болон бусад үндэсний стандарт аргачлалыг бүрэн мөрдөж, лабораторийн хүчин чадлыг стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээг авч ажиллах.
23. Хүнсний сав, баглаа боодлоос шилждэг Phthalates, Bisphenol A (BPA), Styrene зэрэг хүний эрүүл мэндэд хор нөлөөтэй бодисуудыг шинжлэх стандарт аргачлалыг боловсруулах;

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид:

24. ХАБҮЛЛ-ийн бүтэц, орон тоо, ажлын байрны нэршилд нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтыг баталж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 2.2 дахь заалтыг бүрэн хангаж ажиллах
25. Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, оношлуурын хүртээмжийг нэмэгдүүлж, шинжлэх чадавхийг бэхжүүлж, хими, хор судлал, цацрагийн болон пестицидийн шаардлагатай үзүүлэлтүүдийг бүрэн шинжлэх арга хэмжээг авч ажиллах
26. Хүнсний бүтээгдэхүүний бохирдлыг илрүүлэх, аюулгүйн үзүүлэлтийг бүрэн шинжлэх боломжийг бүрдүүлж, ХБАБХТХ-ийн 18.1.3-д заасан импортын болон дотоод үйлдвэрлэлийн хүнсний техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг бүрэн дүгнэх боломжийг хангах арга хэмжээг авч ажиллах
27. Сүлжээ лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, шинжилгээний арга, багаж төхөөрөмжийн нийцлийг хянах, лабораторийн шинэ аргачлал боловсруулах, шинжилгээний аргын баталгаажуулалтыг хийж ХБАБХТХ-ийн 15.2.5, 15.2.6-д заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
28. Стандартын улсын үзлэгийн дүгнэлтээр өгсөн хянаж шинэчлэх шаардлагатай шинжилгээний аргын 28 стандартыг шинэчилж батлуулах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах
29. Сорьцын анхан шатны мэдээллийн бүрдүүлэлтийг сайжруулж, LIMS системд оруулах мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хангаж, MNS ISO/IEC 17025:2017 стандартын 7.11.3-д заасан шаардлагыг бүрэн ханган ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Гаалийн ерөнхий газарт:

30. Аюулгүй байдлын шаардлага хангаагүй хүнс, амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд биет болон баримт бичгийн шалгалт хийх, мэдээлэх, буцаах, дахин боловсруулах, устгах арга хэмжээг хэрэгжүүлэх ГУБ/эрх бүхий албан тушаалтнуудын өдөр тутмын удирдлага, хяналтыг зохицуулах журам, заавар, аргачлалыг боловсруулж, мөрдүүлэх
31. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шинжилгээ хийхдээ аюулгүйн үзүүлэлтүүдийг бүрэн хамруулж, сорилтын дүн болон магадлан шинжилгээний дүгнэлтэд тус бүтээгдэхүүний техникийн зохицуулалт, шаардлага, зөвшөөрөгдөх хэмжээг үндэслэн харьцуулсан үнэлгээ хийж, пестицидийн болон бусад аюулгүйн үзүүлэлтийг иж бүрэн шинжлэх, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13.2-т заасан шаардлагыг хангаж ажиллах
32. Архи, согтууруулах ундаа, тамхи, тамхины бүтээгдэхүүнд багажийн шинжилгээ хийхдээ батлагдсан аюулгүйн бүх үзүүлэлтийг хамруулж, ХБАБХТХ-ийн 13.2-т заасан шаардлагыг хангаж ажиллах
33. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанарын болон аюулгүйн үзүүлэлтүүдийг заавал болон сонгох байдлаар бүтээгдэхүүний эрсдэл болон аюулгүйн үзүүлэлтүүдтэй

уялдуулж хамрах хүрээг тогтоож, журамлах, батлагдсан аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг бүрэн сонгож шинжлэх, ХБАБХтХ-ийн 18.1.3-т заасныг хэрэгжүүлж ажиллах

34. ХАБҮЛЛ болон УМЭАЦТЛ-д шинжлүүлсэн импортын хүнсний шинжилгээний хариуг цахим системээр авах нөхцөлийг бүрдүүлж, шинжилгээний үр дүнг үнэн зөв, бодитой, хараат бус байдлыг хангаж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилын дүнтэй нийцүүлэн дүгнэлт гаргах;

Аудитын тайлангийн төсөлд холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:

№	Тайлангийн төслийн дугаар, утга	Асуудал хариуцсан байгууллага, нэгж	Гаргасан санал, тайлбар	Аудитын тайлбар
1	Тайлангийн төслийн 1.1.7 "Алсын хараа 2050"-ын 2.5.14-т илчлэг транс тос, чихэр давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг хязгаарлахаар тусгасан ч ХХААХҮЯ сахар, чихрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дотоодын хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны банкуудад хүүгийн хөнгөлөлттэй зээл олгож, тухайн чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлж бодлогын уялдааг хангахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.	ХҮҮБХЗГ	Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд жимс, жимсгэнийн ундаа, шүүс, цай, ус үйлдвэрлэгч 11 аж ахуйн нэгжид нийт 63.0 тэрбум төгрөгийн зээлийг дараах зориулалтын хүрээнд олгогдсон нь сахар, чихрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэхээргүй байна. Үүнд: - хүүхдийн хоол хүнсний хэрэглээнд зориулан ногоо жимс жимсгэний тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах, - хүүхдэд зориулсан импортыг орлох бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх, - үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Сахар, чихрийн зүйлсийн 2024 оны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ (167.7 мянган тонн)-г 2023 оны тоо хэмжээ (150.4 мянган тонн)-тэй харьцуулахад 11.3%-иар өссөн бол 2025 оны 10 сарын импортын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.1%-иар буурсан байна.	Саналыг хүлээн авах боломжгүй /Алсын хараа 2050- урт хугацааны бодлогын баримт бичигт 2.5.14-т илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг хязгаарлахаар туссан байхад дунд болон богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэхдээ энэ талаар дэмжсэн олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь бодлогын хувьд зөрчилдөж байгаа талаар тусгасан болно/
2	Тайлангийн төслийн 1.1.8 дээрх бодлогыг хэрэгжүүлснээр чихэрлэг бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх нөхцөл бий болж, чихрийн хэрэглээг бууруулах бодлогын арга хэмжээг татварын бодлогоор хязгаарлаагүй байна. Мөн хэрэгжүүлсэн арга хэмжээ нь элсэн чихэр боловсруулах дотоодын үйлдвэр байгуулахад чиглээгүй, үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлээгүй тул МУ элсэн чихрийн түүхий эдийн хангамжийн хувьд импортын хамааралтай хэвээр байна.	ХҮҮБХЗГ	Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын 5.4.4-д Элсэн чихрийн боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ тусгаж бодлогын хувьд дэмжсэн боловч арилжааны банкны шаардлагыг хангаж зээл авах аж ахуйн нэгж байгаагүй тул зээл олгогдоогүй байна. Зээл олгогдоогүй асуудлыг тайлагнасан тус аудитаар арилжааны банканд хичнээн аж ахуйн нэгж хүсэлт өгөөд, яагаад шаардлага хангахгүй байгаа, ямар асуудлаас болсон зэргийг нягтлаагүй, цаашид үүнийг яах талаар зөвлөмж байхгүй.	

3	Тайлангийн төслийн 1.1.9 Төрөөс баримталж буй урт хугацааны бодлогын арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал: Мексик, Чили, Их британи зэрэг улсууд сахар, транс тос агуулсан бүтээгдэхүүнд ОАТ ногдуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байна	ХҮҮБХЗГ	Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.6-т чихэр, сахар орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усанд онцгой албан татвар ногдуулах заалтыг тусгасан байна. Үүнд: - 100 мл-т 0-5 гр чихэр, сахар орлуулагч агуулвал онцгой албан татвар ногдуулахгүй. - 100 мл-т 5 граммаас дээш чихэр, сахар орлуулагч агуулбал литр тутамд 2027 онд 500 төгрөг, 2028 онд 525 төгрөг, 2029 оноос 550 төгрөгийн онцгой албан татвар ногдуулахаар заасан байна. Энэхүү заалт 2027 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан чихэрлэг ус, ундаа үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн судалгааг гарган 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 02/2014 тоот албан бичгээр Татварын ерөнхий газарт хүргүүлж ажилласан. https://legalinfo.mn/mn/detail/434	Саналыг хүлээн авах боломжгүй /Аудитын хамрах хүрээг 2022-2024 оны хооронд хамааруулан шалгасан бөгөөд 2025 оны байдлаар манай улсад сахар, транс тос агуулсан бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах зохицуулалт хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээгүй байна./
4	Тайлангийн төслийн 1.2.6 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 4 эрх зүйн баримт бичиг батлагдсан байна.	ХҮҮБХЗГ	УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 4 хууль тогтоомж батлагдсан байгааг дурдаж, найруулгын хувьд өөрчлөх.	Саналыг хүлээн авах боломжгүй
5	Тайлангийн төслийн 1.2.7 бусад 14 эрх зүйн барим бичгийг батлаагүй, үзэл баримтлал, хууль журмын төслийг боловсруулах ажил хэрэгжээгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, зохицуулалт хангалтгүй байна	БТГ, ХҮҮБХЗГ	УИХ-ын 36 дугаар тогтоол нь Хүнсний аюулгүй байдлын хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр нэмэгдүүлэх тогтоол, энэ тогтоолын хүрээнд батлуулах 14 эрх зүйн орчин батлуулаагүй гэдгээр Хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдээгүй гэж дүгнэсэн өрөөсгөл дүгнэлт юм. Хүнсний аюулгүй байдал гэдэг маань хангамж, хүртээм, шимт байдал, чанар болон аюулгүй байдал гэх ойлголтоос бүрдэхийг анхаарах. ХХААХҮЯ нь 2023-2025 онд нийт 2 хууль, 1 журам, 1 техникийн зохицуулалт, 1 аргачлал, 2 заавар, 1 зөвлөмж, 8 хуулийн үзэл баримтлал батлагдсан бол одоогийн байдлаар 4 хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж байна. Иймд тус дүгнэлтийг өөрчлөх.	Саналыг хүлээн авсан /1.2.7 дах хэсгийг бусад 14 эрх зүйн барим бичгийг батлаагүй, үзэл баримтлал, хууль журмын төслийг боловсруулах ажил хэрэгжээгүй байгаа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, зохицуулалт хангалтгүй байна. гэж өөрчлөв /

6	Тайлангийн төслийн 1.4 Хүнсний аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээний хэрэгжилийг үнэлэхэдээ нотлох баримтад үндэслээгүй, хяналт-шинжилгээ үнэлгээг бүрэн хийгээгүй, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй	ХШҮДАГ	УИХ-ын 36 дугаар тогтоолын 2023 оны 06 дугаар сарын үнэлгээ зөвхөн ХААХҮЯ-ны хариуцах ажлын үнэлгээ байсныг удирдлагад танилцуулан дахин тус тогтоолыг хэрэгжүүлэх 7 яам, 14 газарт хамаарах 5 чиглэлийн 114 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж зөвлөмжийг дээрх газруудад хүргүүлсэн. Тухайн үед ХШҮ-г Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг баримтлан хийсэн. 2025 оны 01 дүгээр сард хяналт-шинжилгээ хийх арга зүйд өөрчлөлт орж ЗГ-ын 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх журам"-ыг баримтлан хэрэгжсэн, хэрэгжээгүй гэсэн үнэлгээ өгөхөөр тусгагдсан. Гэтэл тус баримт бичиг нь тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичиг тул энэ журмыг баримтлах боломжгүй байсан. ЗГХХГ-аас энэ тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийх зааврыг 2025.05 сард өгч холбогдох үнэлгээ хийгдсэн. 2025 оны 03 дугаар сарын үнэлгээ бол яамны дотоодод хийсэн хяналт шинжилгээ байсан. Бүх арга хэмжээний нотлох баримтуудыг нэг бүрчлэн ХШҮДАГ-аас аваагүй болно. Иймээс бодит үнэлгээ болоогүй гэж үзэж байна.	Саналыг хүлээн авах боломжгүй /ДАХШҮГ-ын тайлангийн нотлох баримтыг unelgee.gov.mn буюу төрийн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системд оруулдаг болно, ХХААХҮЯ-ны ХШҮ-ны тайланд үндэслэн аудитын үнэлгээг хийсэн талаар эх сурвалжийг дурдсан, аудитын талбарын үе шатны хугацаанд хамаарахгүй/
7	Тайлангийн төслийн 1.4.3 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” гэсэн тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг “Хүнсний аюулгүй байдлын индекс”-ийн үзүүлэлтээр үр дүнг тооцохоор баталсан гэсэн байна.	БТГ	Олон улсад "Хүнсний аюулгүй байдлын индекс"-ийг - хүнсний хангамж, - хүртээмж, - чанар аюулгүй байдал - тогтвортой байдал, нөөц гэсэн 4 үндсэн шалгуураар, 28 үзүүлэлтийг ашиглан тооцож байна. МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүнс, хүнсний аюулгүй байдлын чиглэлийн хууль, тогтоомж, стандартад "ХАБ-ын индекс" гэсэн нэр томьёо, манай яаманд энэ аргачлалыг батлах эрх зүйн үндэслэл тусгагдаагүй. Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ны А/165 дугаар тушаалаар “Хүнсний нөөц, хангамж, хүртээмж, шимт байдал, аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг баталсан. Энэхүү аргачлалаар нийт үндсэн 18 томъёоллоор 21 үзүүлэлтээр тооцож байна. Хэрэв тус нэр томъёо шаардлагатай эсэхийг үндэслэлтэй гаргах.	Саналыг хүлээн авах боломжгүй / Эх сурвалж. “Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл аудитын тайлан” /

8	Тайлангийн төслийн 1.5.3 дах заалтад: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18.1.1-д хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавих төрийн чиг үүргийг хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр хуульчилсан боловч тус чиг үүргийг ЭМАЭ төрийн захиргааны төв байгууллага эрүүл ахуй, халдвар хамгаалалтын хяналтыг хэрэгжүүлэхдээ хяналт шалгалтын давхардал үүсгэсэн байна. гэжээ	СХХ	3. Тайлангийн төслийн 1.5.3 дах заалтад Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18.1.1-д хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавих төрийн чиг үүрэг нь ойлгомжгүй, хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага гэсэн салаа утгаар зохицуулагдсан, хяналтын чиглэл бүр хүнсний аюулгүй байдалд ямар чиг үүрэгтэй хяналт тавих нь тодорхойгүй байна. Мөн хүнсний гаралтай хордлого халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулах хоол, хүнсний бохирдлын шалтгаант хордлого, халдварыг хэрхэн тодорхойлох, эрсдэл үүссэн үед салбар хооронд болон олон улсын сүлжээнд мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгааг тусгах;	Саналыг хүлээн авсан Тайлангийн 1.5.3-д өөрчлөлт оруулав.
9	Тайлангийн төслийн 1.5.4 ХАБ-ыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг гэсэн эргэн харах	БТГ, ХАБҮЗ-ийн нарийн бичиг	Хүнсний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Монгол Улсад хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл /цаашид "Үндэсний зөвлөл гэх"/ Засгийн газрын дэргэд ажиллах бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга Монгол Улсын Ерөнхий сайд байна.” гэж заасан бөгөөд тус бүтцийн нэгж нь хүнсний аюулгүй байдлыг хянах шууд чиг үүрэггүй байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтыг Төрийн хяналт, шалгалтын тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан төрийн байгууллагууд хэрэгжүүлдэг. Мөн уг дүрслэлд ХХААХҮЯ-ны хяналтын бус чиг үүрэгтэй газар, нэгжийг тусгасан байна. Иймээс төслийн 1.5.4-ийн Дүрслэл 1. Хүнсний аюулгүй байдлыг хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг гэснийг өөрчлөх эсвэл хасах шаардлагатай.	Саналыг хүлээн авах боломжгүй
10	Тайлангийн төслийн 1.5.14 ХХААХҮЯ-ны СХГ нь ХБАБХТХуулийн 8.11-д заасан "Хяналтын байгууллага энэ хуулийн 8.2-т заасны дагуу татан авсан хүнсний түүхий д, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ" гэсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүй, мэдээллийн сан бүрдүүлээгүй,	СХХ	Хяналтын байгууллага нь зөвхөн ХХААХҮЯ-ны СХГ биш бөгөөд ЭМЯ-ны СХГ, ГЕГ-ын Хорио цээрийн хэлтэс, СХЗГ, ХАБҮЛЛ, БЯ-нд хүртэл хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хоолны асуудал, хяналт хамаардаг тул татан авахуулсан түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийн сан үүсгэх, нийтэд мэдээлэх чиг үүрэг дээрх байгууллагуудад бүгдэд хамааралтай байдаг, хуулийн тодорхой зохицуулалт байхгүй тул тус дүгнэлтийг өөрчлөх нь зүйтэй;	Саналыг хүлээн авах боломжгүй

	нийтэд мэдээлээгүй байна. гэжээ			
11	Тайлангийн төслийн 1.6 ХАБҮЗ хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна, зөвөлийн үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, салбар хоорондын уялдаа, ХШҮ-ний тогтолцоо сул байна.	БТГ, ХАБҮЗ-ийн нарийн бичиг	Уг аудит нь 2024 оны үйл ажиллагаанд хийгдэж, тайлан нь тухайн цаг үед хамаарна гэж ойлгож байна. Өнгөрсөн цаг хугацаанд тус Үндэсний зөвлөлийн хуульд заасан зарим чиг үүрэг хэрэгжээгүй үндэслэл, шалтгааныг тогтоож, цаашид сайжруулах дүгнэлт, зөвлөмж гарах ёстой гэж үзэж байна. Хүнсний тухай хуулийн 18.2."Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэг бүхий нарийн бичгийн дарга орон тооны байна." гэж заасан боловч энэ албан тушаалд бие даасан орон тооны хүн томилогдож байгаагүй бөгөөд бүтэц, орон тооны хязгаарлагдмал байдлаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох референт давхар хариуцан ажиллаж ирсэн. Өөрөөр хэлбэл Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, холбогдох яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулах, судалгаа хийлгэх, бусад оролцогч талуудтай хамтран ажиллах зэрэг хуульд заасан чиг үүргийг үндсэн ажлаас гадна давхар хариуцан хэрэгжүүлэх боломжгүй байсан гэж үзэж байна. Иймээс хүнсний экспорт, импортын зохицуулалтын зайлшгүй шаардлагын дагуу хуульд заасан хугацаанд шийдвэр гаргадаг байх талтай. Түүнчлэн, Үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөө гаргах, шинжээчдийн баг байгуулах, судалгаанд шаардлагатай зардлыг төсөвт тусгуулж, өдөр тутмын үйл ажиллагааг хангах, нэгдсэн тайлан боловсруулах, Улсын Их Хурал, ҮАБЗ-д танилцуулах ажлууд хийгдээгүй нь мөн орон тооны нарийн бичгийн даргыг бие даасан байдлаар томилж байгаагүйтэй холбоотой байх боломжтой тул хийсэн дүгнэлтээ эргэн харах. Өөрөөр хэлбэл: ХАБҮЗ чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзэж байгаа бол шалтгаан нөхцөлийг тодорхой тусгах.	Саналыг хүлээн авах боломжгүй
12	Тайлангийн төслийн 1-р бүлэгт: ... "Хүнсний аюулгүй байдал алдагдсан" хэвээр байна гэжээ	СХХ	1. Тайлангийн төслийн дотоодын үйлдвэрлэл, импортын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг харьцуулсан хүснэгтийн дундаж хувийг харьцуулаад “Хүнсний аюулгүй байдал алдагдсан хэвээр” гэж дүгнэх нь учир дутагдалтай байна. Тухайлбал 72%-ийн тослогтой цөцгийн тос нь импортынх нь маргарин, дотоодын үйлдвэрлэл нь амьтны гаралтай цөцгийн тос харьцуулагдсан, загасны дотоодын үйлдвэр Хөвсгөлд байдаг, Сэлэнгэ, Архангай аймагт загас агнуурын зөвшөөрөл олгогддог статистик мэдээлэлд тодорхой тусгагдаагүй байна Хүнсний хангамжтай холбоотойгоор экспорт, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх асуудлаар ихэвчлэн бодлогын бичиг баримтад тусгагдсан тул хүнсний аюулгүй байдал гэснийг хүнсний хангамж, нөөц гэж нэрийг өөрчлөх;	Хүлээн авсан. /Хүнсний бие даасан байдал алдагдсан хэвээр байна гэж өөрчлөв/

13	Тайлангийн төслийн 1.9.6-д ХБАБХТХуулийн 17.2.2 "хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стндартад нийцүүлэн тогтоох", 17.2.3 "хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшинг тогтоож, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох" гэж заасныг хэрэгжүүлээгүй. гэжээ	СХХ	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17.2-т зааснаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудал бөгөөд хориглосон хүнсний нэмэлтийн жагсаалт гаргах, хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэхийг хориглох талаар шийдвэр гаргах нь зүйтэй байна. Эрүүл мэндийн Сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/182 дугаар тушаалаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 468 аюулгүйн үзүүлэлтийг шинэчлэн баталсан байгаа.	Саналыг хүлээн авах боломжгүй Аудитын хамрах хугацаанд хамааралгүй
14	Тайлангийн төслийн 1.10 Стандартын улсын үзлэгийн зөвлөмжийн үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тодорхой бус, хүнсний салбарын стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын 63 % нь хэрэгжээгүй байна	ХҮҮБХЗГ	Стандартын улсын үзлэгийг 2022 онд зохион байгуулж, 30 стандартыг шинээр боловсруулах (2022 онд -10, 2023 онд 11, 2024 онд 9), 153 стандартыг шинэчлэн боловсруулах (2022 онд -6, 2023 онд 86, 2024 онд 45, 2025 онд 16), 50 стандартыг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 2022 онд нэр бүхий 10 стандарт, 2023 онд 5, 2024 онд 6 стандарт, нийт 21 стандартыг шинээр боловсруулж, батлуулсан ба стандартын улсын үзлэгийн шийдвэрийг 70%, харин шинэчлэн боловсруулахаар шийдвэрлэсэн нийт 153 стандартаас 2022 онд 6, 2023 онд 9, 2024 онд 7, 2025 онд 2, нийт 24 стандартыг шинэчлэн боловсруулж, стандартын улсын үзлэгийн шийдвэрийг 15.7%, хүчингүйд тооцохоор шийдвэрлэсэн 50 стандартыг бүгдийг хүчингүй болгож, стандартын улсын үзлэгийн шийдвэрийг 100% хэрэгжүүлж ажилласан бөгөөд салбарын стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох ажил 62%-ийн хэрэгжилттэй байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.7, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасны дагуу Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг 2022 онд, Сүү бэлтгэл, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг техникийн зохицуулалтыг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор шинэчлэн боловсруулж, батлуулсан. Мөн 2025 онд Ундны сүү. Техникийн ерөнхий шаардлага MNS 0219:2025, Малын түүхий сүү. Техникийн ерөнхий шаардлага MNS 4228:2025, Исэг сүүн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MNS 4229:2025, Сүүн ундаан. Техникийн ерөнхий шаардлага MNS 7081:2025, Ингэний ариутгасан сүү. Техникийн ерөнхий шаардлага MNS 7080:2025 гэсэн 5 стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж, сүү, сүүн бүтээгдэхүүний стандартын хороогоор хэлэлцүүлж, батлуулаад байна. Ургамлын гаралтай хүнсний стандартын техникийн хорооны	Саналыг хүлээн авах боломжгүй

			2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар дараах стандартыг хэлэлцүүлж батлуулаад байна. Үүнд: Чацарганын тосны стандарт /шинээр боловсруулсан/, савласан цэвэр усны стандарт /шинэчлэн боловсруулсан/, лоолийн стандарт /шинээр боловсруулсан/, Зараа (салад навч) -ны стандарт /шинээр боловсруулсан/	
15	Тайлангийн төслийн 2.1.4, 2.1.6-д Хүнсний бүтээгдэхүүнд аюулгүй байдлын хамгийн олон үзүүлэлтийг (22) ХАБҮЛЛ шинжлэхээр магадлан итгэмжлэгдсэн боловч батлагдсан үзүүлэлтийн 20 орчим хувийг шинжлэхгүй бна. СХЗГ болон МЭ-ийн харьяа аймаг орон нутгийн сүлжээ лабораториуд батлагдсан аюулгүйн үзүүлэлтийн 75-85 хувьд шинжилгээ хийж чадахгүй байна	СХХ	7. Тайлангийн төслийн 2.1.4, 2.1.6-д төсөв санхүүжилт хангалтгүй, хүний нөөц дутагдалтай, урвалж бодис байхгүй зэргээс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хор судлал, хүнд металл, хүнсний нэмэлт, бохирдуулагч, үлдэгдлийн шинжилгээг бүрэн тодорхойлохгүй, аюулгүй үзүүлэлтийн шинжилгээг бүрэн хийхгүй байна.	Саналыг хүлээн авах боломжгүй
16	Тайлангийн төслийн 2.19.5-д: ХХААХҮЯ-нд өгсөн дараах 6 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	СХХ	Төслийн 2.19.5 заасан шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмыг батлан мөрдүүлэх чиг үүрэг нь Хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалтад зааснаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамаардаг тул хасах; Мөн Хүнсний тухай хуулийн 9.1.1, 9.1.2 дахь заалтад "...хүн амын зохистой хоололт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах" нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамаардаг тул хүн амын хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол олгох асуудлыг хасах нь тус тус зүйтэй байна.	Саналыг хүлээн авах боломжгүй ЭМЯ-тай хамтран батлах шаардлагатай

		ХШУДАГ	МУ-ын ерөнхий аудиторын 2025.08.22-ны өдрийн 2524 тоот албан бичгээр хугацаандаа хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж ирүүлэх тухай албан бичигт УАГ-аас 2021 онд хийгдсэн "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн" сэдэвт аудитаар өгсөн 3 зөвлөмж хэрэгжээгүй байна гэж ирүүлснийг тус газраас хэрэгжилтийг гарган сайдын 2025.09.17-ны өдрийн 01/2754 тоот албан бичгээр ерөнхий аудиторт хаяглан хүргүүлсэн байна. Иймд хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно. Гэтэл өөр бусад яам, байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлыг нэмж 6 зөвлөмж хэрэгжүүлээгүй мэтээр ирүүлсэн ба дээрх албан бичгээр ирүүлсэн хэрэгжээгүй зөвлөмж, тайлангийн төсөлд туссан хэрэгжүүлээгүй зөвлөмж нь утга агуулгын хувьд зөрүүтэй байгааг нягтлан, үнэн зөв мэдээллийг тусгах,	Саналыг хүлээн авах боломжгүй
		БТГ	• Хүнсний тухай хуулийн 6.2-т “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу "Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам"-ын төслийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Журам батлах тухай" 344 дүгээр тогтоолыг батлуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760395118701 • Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлд стратегийн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлж болно гэж заасан. Иймд хөдөө аж ахуйд олгох дэмжлэг, урамшууллыг багасгах бодлого яригдаж буй энэ үед дээрх журмыг зайлшгүй гаргах шаардлага үүсээгүй болно. • Хариуцсан ажилдаа хайхрамжгүй хандсан, үүргээ биелүүлээгүй эрх бүхий албан тушаалтуудад хариуцлага тооцсон эсэх асуудал нь хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр дүнтэй болсон эсэхийг тооцоход ач холбогдол байсан эсэхийг эргэн харах.	Саналыг хүлээн авах боломжгүй
17	Тайлангийн төслийн Ерөнхий мэдээлэл бүлгийн хүснэгт 1. Хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний хангамж, түүний талаар	ХҮҮБХЗГ	Хүн амын хүнсний хангамжийн хувийг гол нэр төрлийн 16 бүтээгдэхүүнээр тооцсон бөгөөд зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг авч үзвэл, жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн буурцагт ургамлаар 99.98 хувь, сүүгээр 99.8 хувь, малын махаар 98.9 хувь, төмсөөр 95.9 хувь, өндгөөр 70.6 хувь, хүнсний ногоогоор 66.3 хувь, сахар, чихрийн зүйлээр 64.1 хувь, гурилан бүтээгдэхүүнээр 60.6 хувь, гурилаар 58.3 хувь, сүүн бүтээгдэхүүнээр 58.2 хувь хангасан бол импортын төрөл бүрийн будаа, загасаар 100.0 хувь, шувууны махаар 98.5 хувь, ургамлын тосоор 98.1 хувь, цөцгийн тосоор 97.2 хувь, жимс, жимсгэнээр 97.1 хувь хангаж байна. (Эх үүсвэр: Хүнсний аюулгүй байдлын статистикийн	Саналыг хүлээн авах боломжгүй

			үзүүлэлт, 2024 он) Улсын хэмжээнд, 2023 онд дотоодын үйлдвэрлэлээр хангасан бүтээгдэхүүний хүнсний хангамжийн дундаж хувь 74.6 байсан бол 2024 онд 77.3 хувь байна. Дээрх тоон мэдээллээс харахад улсын хэмжээнд дотоодын үйлдвэрлэлээс 77.3 хувь, импортоор 23 хувиар хангаж байгаа нь Монгол Улсын хүнсний хангамж тогтвортой хангагдаж байна. Өмнөх оны дүнтэй харьцуулахад 2.7 хувиар нэмэгдсэн байна. (Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүн (малын мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, буурцагт ургамал, өндөг, сахар, чихрийн зүйл)-ий 70-аас дээш хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан бол хүнсний хангамж тогтвортой хангагдаж байна гэж, харин дотоодын үйлдвэрлэлээр хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хувь 70-аас доош хувиар байвал хүнсний хангамж тогтворгүй байна гэж үзнэ.) (Эх үүсвэр: Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт 2023, 2024 он) Хүнсний хүртээмж хот, хөдөөгийн хэмжээнд харилцан адилгүй байдаг бөгөөд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, ургамлын тосыг улсын дунджаас давж, хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цэцгийн тос, сахар чихрийн зүйлийг улсын дунджаас давж хэрэглэж байна.													
18	Тайлангийн төслийн Хүснэгт 2.Гол нэрийн зарим барааны дундаж үнийн талаар	ХҮҮБХЗГ	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар ЗУРАГ 22 ХҮНСНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар <table><thead><tr><th>Тайлбар</th><th>2022</th><th>2023</th><th>2024</th></tr></thead><tbody><tr><td>Ерөнхий индекс</td><td>15.4</td><td>13.2</td><td>7.9</td></tr><tr><td>Хүнсний бараа, ундаа, үс</td><td>15.4</td><td>13.2</td><td>8.9</td></tr></tbody></table>	Тайлбар	2022	2023	2024	Ерөнхий индекс	15.4	13.2	7.9	Хүнсний бараа, ундаа, үс	15.4	13.2	8.9	Саналыг хүлээн авах боломжгүй
Тайлбар	2022	2023	2024													
Ерөнхий индекс	15.4	13.2	7.9													
Хүнсний бараа, ундаа, үс	15.4	13.2	8.9													
		Хүнсний аюулгүй байдал болон хэрэглээний үнийн түвшний өөрчлөлтийг Үндэсний статистикийн хорооны “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2024” эмхэтгэлийн Хүснэгт 22. Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар)–д тусгагдсан мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үнийн индекс нь хэрэглээний сагсанд багтдаг бараа, үйлчилгээний үнийн түвшин өмнөх оны ижил үеэс хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлдэг, олон улсын стандартад нийцсэн (CPI) хэмжүүр юм. ҮСХ-ноос үнийн жилийн өөрчлөлтийг тооцохдоо тухайн сарын үнийг өмнөх оны мөн сартай харьцуулдаг нь тооцооллын үндсэн аргачлал юм.	Саналыг хүлээн авах боломжгүй													

			$\% \text{Өөрчлөлт} = \left(\frac{[\text{CPI}]_{2024.12} - [\text{CPI}]_{2023.12}}{[\text{CPI}]_{2023.12}} \right) \times 100$ Энэхүү аргачлалын дагуу Хүнсний бараа, ундаа, ус дэд бүлгийн үнийн индексийн жилийн дундаж өөрчлөлтийг авч үзвэл: 2022 онд дунджаар 18.32 хувь, 2023 онд дунджаар 15.58 хувь, 2024 онд дунджаар 7.92 хувь болж тус тус буурсан байна. ҮСХ-ны 2022–2024 оны статистикийн мэдээллээр тухайн хугацаанд хүнсний үнийн өсөлт тогтвортой буурч, өрхийн худалдан авах чадварт үзүүлэх инфляцын дарамт мэдэгдэхүйц зөөлөрсөн, хүнсний хангамжийн тогтолцоо сайжирч буйг нотлон харуулж байна. 2022 он, 2023 оны хэдэн сарын үнийг 2024 оны 8 сарын үнэтэй харьцуулж дүгнэсэн нь тодорхойгүй.	
19	Тайлангийн төслийн 2.12.3 МЭЭГ 2022-2024 онд үндэсний хэмжээнд нийт 21 төрлийн мал, амьтны халдварт өвчний эсрэг вакциныг Биокомбинат ТӨҮГ-аас бусад 3 өвчний эсрэг вакциныг импортоор худалдан авсан байна.	МЭЭГ	Нийт 18 нэр төрлийн вакцинаас 6-7 нэр төрөл нь улсын төсөв буюу засгийн газрын 225 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад орсон өвчин Мал эмнэлгийн ерөнхий газрын төсөвт суугддаг. 11-12 нэр төрөл 21 аймаг, нийслэлийн мал эмнэлэг тухайн аймгийн ИТХ-аар оруулж аймгийн төсөвт буюу засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дүгээр хавсралтад орсон өвчин. 3 нэр төрлийн вакцин буюу иргэн хуулийн итгээд өөрөө санхүүжих буюу засгийн газрын 225 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад орсон өвчин. Тус бүр “Биокомбинат” ТӨХХК-тай нэг эх үүсвэрээс дотоодын нэг үйлдвэр гэрээ байгуулан худалдан авдаг. Засгийн газрын 225 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад орсон өвчин гоц халдварт шүлхий, бог малын мялзан, Үхрийн арьс товруутах өвчин гэсэн 3 нэр төрлийн вакциныг олон улсын лавлагаа лабораториор омог нь баталгаажсан вакциныг нээлттэй тендер шалгаруулалт зарлаж үйлдвэрлэгчээс нь сонгон шалгаруулалт хийж худалдан авсан.	Саналыг хүлээн авах боломжгүй
20	Тайлангийн төслийн 2.13 Сүхбаатар, Ховд аймагт бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт үр дүнгүй болж, 280.8 сая төгрөгийн вакцин бэлдмэл, 396.7 сая төгрөгийн үйлчилгээний хөлс, нийт 677.6 сая төгрөгийн хохирол учирсан байна.	МЭЭГ	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцины дараах хяналтыг Сүхбаатар, Ховд аймгийн тус бүр 2 сумын 28 малчин өрхөөс түүвэр дээж авч шинжилгээ хийсэн. Энэ хоёр аймгийн бүхэлд нь үр дүнгүй гэж үзэх хэмжих боломжгүй юм. Тухайн хоёр сумын хэмжээнд үр дүн муу гэж дүгнэж үзэх юм. Мөн аймаг болон Мал эмнэлгийн ерөнхий газраас вакцин, тарилгын технологи, иргэн малчинтай уулзаж асуумж судалгаа авах зэрэг бусад хяналт хийгдэж эцэслээгүй тайлан юм. Вакцины дараах хяналтыг дан ганц шинжилгээгээр эцэслэх боломжгүй юм. Цаашид энэ хяналт шалгалт дээр дараа дараагийн арга хэмжээг авч эцэслэх тул зөвлөмж болгож өгөхийг хүсэж байна.	Саналыг хүлээн авах боломжгүй

21	Тайлангийн төслийн 2.13.4 Мөн төлөвлөгөөт дархлаажуулалтыг 2022, 2023, 2024 онд тус тус тухайн оны эхний улиралд баталсан, тархвар зүйн судалгааны үндсэн дээр бодитой төлөвлөөгүй, урьдчилан сэргийлэх вакциныг өвчин тус бүрээр хийвэл зохих цаг хугацаанд нь дархлаажуулж чадаагүй нь МАЭМТХуулийн 9.2-т заасныг зөрчсөн тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв	МЭЕГ	Улсын төсөв 11 дүгээр сарын 15-ны өдрөөр УИХ-аар орж баталдаг. Мал эмнэлгийн ерөнхий газраас дараа оны захиалгыг 7 сараас эхлэн захиалга авч улсын хэмжээнд нэгтгэж хүргүүлдэг. Арга хэмжээний төсөв явуулсан саналаар батлагдсан тохиолдол (хасагдаж) байхгүй. Төсөв батлагдаж ирсний дараа төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөгөөг тухайн оны 1 дүгээр улиралд багтаан батлуулдаг. Төсөвт тааруулж өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хийдэг. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан дараа оны төлөвлөгөөг тухайн жилийн хоёр дугаар улиралд багтаан батлах боломжгүй байдаг. Бид хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг засгийн газрын гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамд санал оруулах талаар ахлах шинжээч нартай санал солилцож байгаа. Иймд энэ арга хэмжээ нь дээр зөвлөмж болгож өгнө үү.	Саналыг хүлээн авах боломжгүй
22	Тайлангийн төслийн 2.14 Вакцин худалдан авахдаа хууль зөрчсөн байна. 2.14.3, 2.14.5	МЭЕГ	Тайлбарыг хавсралтаар	
		ХШҮДАГ	Тайлангийн төсөлд ТНБД-ын 2024 оны 508 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд МЭЕГ-ын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины худалдан авах ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн нэгдсэн танилцуулгад туссан буюу тус хяналт шалгалтаар илэрсэн асуудал, авах арга хэмжээний саналыг татан авч оруулсан байх тул тайлангийн төслийн 2.14, 2.14.3, 2.14.5 дахь хэсгийг тайлангаас хасуулах саналтай байна. Учир нь: Тухайн хяналт шалгалтын тайланг удирдлагуудад танилцуулж, удирдлагаас МЭЕГ-т үүрэг чиглэл өгч, зөрчлийг арилгуулах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Иймд өмнөх дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн асуудлыг тус аудитын тайланд давхардуулан оруулах шаардлагагүй гэж үзэж байна.	Саналыг хүлээн авах боломжгүй /Шилэн дансанд 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг оруулаагүй, аудитын явцад худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль зөрчсөн байж болзошгүй үйлдлийн Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх үндэслэлтэй, 2024 оны Худалдан авах ажиллагааны архивыг 2025 оны эхний улиралд багтааж архивд хүлээлгэн өгөөгүй, нотлох баримтуудыг архивын баримт болгон бүрдүүлж, холбогдох албан тушаалтнаас нэмэлтээр баримт бичгээр баталгаажуулан хүлээн авсан баримт дээр дүгнэлт хийсэн болно /

Хавсралт 1."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлж, үр дүнг тооцох төсөл арга хэмжээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор баталсан					Хэрэгжих хугацаа	Хүрсэн түвшин	Аудитын үнэлгээ
№	Дугаар	Зорилтын нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хүрэх түвшин			
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:							
1	1.1.1	1.1.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит болон 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; Тарифын зохицуулалт хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын оновчтой бүтэц, тогтолцоо болон мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, бодлогын уялдааг хангасан хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Хуулийн төслийг боловсруулж, Үзэл баримтлалыг ХХААХҮ-ийн сайд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан ч дахин шинэчлэн батлах хэрэгцээ шаардлага үүссэн байна. УИХ-д хуулийн төслийн өргөн бариагүй.	30
2	1.1.2	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл болон холбогдох дүрэм, журмыг боловсруулах	Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн байна.	2023	Хуулийн төслийг 2022.04.14-нд өргөн мэдүүлсэн. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт орохоор шийдвэрлэх тухай ЗГ-ын хуралдаанаар хэлэлцсэн. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн төсөлд “Зохицуулах үйлчлэлтэй хүнс” бүлэг нэмж оруулах саналаа хүргүүлсэн ч 2022.04.22-2024.06.05-ны өдрийн хооронд тус хуульд нийт 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон ч энэ талаар зохицуулсан нэмэлт өөрчлөлт ороогүй байна.	50
3	1.1.3	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хүнсний сүлжээнд зохицуулагдаагүй үйлдвэрлэл, үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахтай холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Хуулийн төслийг боловсруулж, Үзэл баримтлалыг ХХААХҮ-ийн сайд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран 2 удаа баталсан байна. Үзэл баримтлалыг нэмж боловсруулах шаардлага үүссэн тул дахин санал авч төслийг шинэчилж байна. 2022.04.22-2024.06.05-ны өдрийн хооронд тус хуульд нийт 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон ч "Хүнсний сүлжээнд зохицуулагдаагүй үйлдвэрлэл, үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулах"-тай холбоотой нэмэлт өөрчлөлт	30

					ороогүй байна. УИХ-д хуулийн төслийн өргөн бариагүй.	
4	1.1.4	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хүнсний сүлжээний бүх үе шатанд зохистой дадлыг нэвтрүүлэх арга замыг тодорхой болгохтой холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	ХХААХҮ-ын сайд ЭМ-сайдын хамтарсан тушаалаар 2 заавар баталсан байна. ХХААХҮ-ын сайдын 2024 оны А/441 дүгээр тушаалаар зохистой дадал нэвтрүүлэх 1 зөвлөмжийг батлуулж, хэрэгжилтийг хангахаар төлөвлөгөө баталсан байна. Хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулаагүй. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд 2022.06.03-2024.06.05-ны өдрийн хооронд нийт 5 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон ч "Хүнсний сүлжээний бүх үе шатанд зохистой дадлыг нэвтрүүлэх арга замыг тодорхой болгохтой холбоотой" нэмэлт өөрчлөлт ороогүй байна.	30
5	1.1.5	Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний худалдааг дэмжих, хорио цээрийн нөхцөлийг сайжруулахтай холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Хууль батлагдсан байна.	100
6	1.1.6	Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Тариалангийн салбарын эрсдэлийг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолд нийт 147 хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгагдсанаас ХХААХҮ-ын сайдын эрхлэх асуудлын хүрээнд 5 хуулийг шинэчлэх, боловсронгуй болгохоор тус тогтоол батлагдсан байна. Арга хэмжээ 2022 оноос хэрэгжиж 2023 онд төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн ч үзэл баримтлалын төсөл боловсруулагдаагүй, тодорхой үр дүн гаргаагүй байна	10
7	1.1.7	Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний	2022	ХХААХҮ-ын сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд, ХЗДХ-ийн сайд 4 сайдын	30

			тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.		хамтарсан үзэл баримтлал, тогтоолын төсөл боловсруулсан ч дахин шинэчлэн батлах хэрэгцээ шаардлага үүссэн байна. Үр дүн гараагүй тогтоолын төслийн УИХ-д өргөн мэдүүлээгүй байна.	
8	1.1.8		Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийг чөлөөт зах зээлийн үнэ тарифтай уялдуулан тогтоохтой холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Хуулийн төслийн боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд 2022.11.11-2024.05.16-ны өдрийн хооронд нийт 3 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон боловч Баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийг чөлөөт зах зээлийн үнэ тарифтай уялдуулан тогтоохтой холбоотой нэмэлт өөрчлөлт ороогүй, төслийг УИХ-д өргөн бариагүй байна.	50
9	1.1.9		Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хүнсний давс олборлож, дотооддоо боловсруулахтай холбоотой зохицуулалт бүхий хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Үзэл баримтлалын төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас санал авах бичиг хүргүүлсэн. Үзэл баримтлалыг боловсруулаагүй, үр дүн гараагүй байна.	30
10	1.2.1	1.2.Хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд 2022.11.11-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна. 36 дугаар тогтоолын тус арга хэмжээний хүрээнд хуульд ямар өөрчлөлт оруулах талаар хүрэх түвшин тодорхой бус төлөвлөсөн, хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байх тул бүрэн хэрэгжсэн гэж үнэлэв.	100

11	1.2.2	боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгохтой холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	2023	ХХААХҮ-ын сайд, Боловсролын сайд, ХЗДХ-ийн сайд нар хамтарч үзэл баримтлалыг баталсан байна. 3 сайдын хамтарсан "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам"-ыг баталсан байна.	50
12	1.2.3		Хүнсний аюулгүй байдлыг хангах богино хугацааны мэргэжлийн сургалтад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийг хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулсан байна.	2023	Хүнсний аюулгүй байдлыг хангах богино хугацааны мэргэжлийн сургалтад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийг хамруулах эрх зүйн орчин бүрдээгүй, хууль болон холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, хуулийн төсөл, үзэл баримтлал батлагдаагүй байна.	30
13	1.2.4		Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт зэрэглэл тогтоох, хянах, баталгаажуулах, ил тод байдлыг хангах тогтолцоо, эрх зүйн орчныг бүрдүүлэх	Холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулж, бүрдсэн байна.	2022	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт зэрэглэл тогтоох, хянах, баталгаажуулах, ил тод байдлыг хангах тогтолцоо, эрх зүйн орчин бүрдээгүй, хууль болон холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, хуулийн төсөл, үзэл баримтлал батлагдаагүй байна.	30
14	1.3.1	1.3.Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах	Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах	Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулсан байна.	2023	Аргачлал батлагдсан байна.	100
15	1.3.2	боловсруулж батлуулах, хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг батлах /гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний техникийн	Хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг батлах /гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний техникийн	10	2024	"Сүүн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадал" болон "Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадал"-ыг тус тус батлуулсан байна. Тус техникийн зохицуулалт нь өмнө нь хүчин төгөлдөр үйлчилж байсан бөгөөд нэмэлт өөрчлөлт хийж шинэчлэн баталсан байна. 10 эрх зүйн актаас 2-ыг шинэчлэн баталсан байна.	20

			зохицуулалтыг боловсруулах/				
16	1.4.1	1.4.Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх	Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх	Журмыг батлуулж, цахим системд шилжүүлсэн байна.	2024	Зохион байгуулалтын арга хэмжээг авч Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Цар тахлын дараах орчинд хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” төслийн дэмжлэгтэйгээр журмын төслийг боловсруулсан байна.	70
17	1.5.1	1.5.Хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг боловсруулан батлах	Хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулах	Хот, суурин газрын хүнсний эрэлт, нийлүүлэлтийг тогтворжуулна.	2024	Журам батлагдсан байна.	100
18	1.6.1	1.6.Хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах	Хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хүнд металлын үлдэгдэл, хоруу чанар өндөртэй нянгийн бохирдлыг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах	4 төрлийн төлөвлөгөө батлагдсан байна.	2022-2023	Хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, 1. пестицид, 2. малын эм, 3. хүнд металлын үлдэгдэл, 4. хоруу чанар өндөртэй нянгийн бохирдлыг хянах, хяналтын төлөвлөгөөг батлаагүй байна.	0
Хоёр.Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:							
19	2.5.3	2.5.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх	Шаардлагатай тохиолдолд гол нэрийн хүнс үйлдвэрлэгчийн цахилгааны хэрэглээний зардлыг хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх	1	2024	Мах, сүү, гурил, цэвэр усны үйлдвэрүүдээс цахилгааны хэрэглээний судалгааг авч цахилгааны хэрэглээг хөнгөлөх, чөлөөлөх шаардлаггүй гэж үзсэн байна.	100

		үүсвэр, шатахуунаар тогтвортой хангах					
Гурав.Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:							
20	3.6.1	3.6.Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр уул уурхайн үйлдвэрийг түшиглэн азот, фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжилтийг хангах	Уул уурхайн ордыг түшиглэн азот, фосфор, калийн бордооны түүхий эдийн нөөцийг судлах, үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах	Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авч үйлдвэр байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	2023-2024	Үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг зарласан байна.	30
21	3.8.2	3.8.Стандартын шаардлага хангасан үр тарианы элеваторын багтаамжийг 20.0 мянган тонноор, төмс, хүнсний ногоог хадгалах механикжсан агуулах, зоорийн багтаамжийг 50.0 мянган тонноор тус тус бүсчилсэн байдлаар нэмэгдүүлэх	Тариалангийн баруун, зүүн бүсэд үр тарианы элеватор байгуулах	Тариалангийн баруун, зүүн бүсэд үр тарианы элеваторын багтаамжийг тус бүр 10.0 мянган тонноор нэмэгдүүлсэн байна.	2022-2024	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Дорнод аймгийн Хэрлэн сум, Увс аймгийн Баруунтуруун суманд элеваторын суурь байгуулах ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна. 2025 оны байдлаар Тариалангийн баруун, зүүн бүсэд үр тарианы элеваторын багтаамжийг 10.0 мянган тонноор нэмэгдүүлээгүй байна.	30
Дөрөв.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:							
22	4.3.4	4.3.Хот, суурин газрын ойролцоо,	Махны болон нарийн ноост	6.0 мянган махны болон нарийн ноост	2023	6.0 мянган махны болон нарийн ноост хонь бүхий аж ахуйг байгуулах талаар	0

		газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах	хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг байгуулахад дэмжлэг үзүүлэх	хонь бүхий аж ахуйг байгуулсан байна.		хийсэн арга хэмжээ байхгүй, үр дүнгүй байна.	
23	4.6.4	4.6.Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг	Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах	Баруун бүс, Хангайн бүс, Зүүн бүс тус бүрд лаборатори байгуулсан байна.	2022-2024	1. Азийн банкны "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах" төслөөр Сэлэнгэ аймаг дахь МЭГ-т 2 тэрбум төгрөгийн санхүүжилттэй лаборатори баригдсан байна. Аудитын баг Сэлэнгэ аймаг дахь МЭАЦЛ-ын шинэ барилга байгууламжтай танилцсан.	33.3

		нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах				/лабораторийн шинээр баригдсан барилга, байгууламжийг хүлээн авсан боловч тоног төхөөрөмж бүрэн суурилагдаагүй, уг барилга нь ажлын даалгавар болон холбогдох стандартын шаардлагад зарим талаар нийцээгүй нөхцөл байдалтай байв/ 2. Өвөрхангай аймагт хийсэн барилгын засвар болон тоног төхөөрөмж нийлүүлсэн талаар тайлагнасан байна. Энэ нь шалгуур үзүүлэлтэд хамаарахгүй, 1 лаботатори байгуулсан байна.	
24	4.6.5	санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа нь MNS5368:2018 стандартад 100 хувь нийцсэн байна.	2022-2024	100 хувь стандартын шаардлагад нийцүүлэх гол зорилтод хүрээгүй ч 2024 онд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа нь MNS5368:2018 стандартад хангаж ажиллаж байгаа эсэхийг урьдчилан судлах ажил хийгдсэн байна.	30
Тав.Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:							
25	5.1.1	5.1.Мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох	Мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх	1	2023	1. ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын 2022 оны А/218/А/146 дугаар хамтарсан тушаалаар "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг баталсан байна. 2022-2024 огы хооронд 16.2 тэрбум төгрөгийн урамшууллыг 1907 иргэн, аж ахуй нэгжид олгосон байна. 2. Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 118 дугаар тогтоолыг гарган хэрэгжилтийг зохион байгуулж, урамшуулал олгодог болсноор 12,1 тэрбум төгрөгийн урамшууллын 734 иргэн ААН-ийн хүсэлтийг хянан баталгаажуулсан байна. 3. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын дөрөвдүгээр бүлэгт: “Органик	100

						бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх дэмжлэг, урамшуулал” гэсэн 2 зүйл тусгагдсан байна.	
26	5.1.2		Гарал үүсэл баталгаажсан эрүүл малыг мал төхөөрөх үйлдвэрт, малын сүүг сүүний үйлдвэрт, өндөг, гахай, тахианы махыг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид урамшуулал, дэмжлэг олгох журмыг боловсруулан батлуулах	1	2023	5 төрлийн урамшуулал олгох эрх зүйн орчинг бүрдүүлсэн байхаар 1. Мал төхөөрөх үйлдвэрт 2. Малыг сүүг сүүний үйлдвэрт 3. Өндөг 4. Гахай 5. Тахианы мах нийлүүлсэн МААЭ-д Сүүний урамшууллыг журмыг баталсан. Мал төхөөрөх үйлдвэрт урамшуулал олгох эрх зүйн орчинг бүрдүүлээгүй. Өндөг, гахай, тахианы мах-д урамшуулал олгох хуулийн заалт байхгүй тул тогтоолоор олгох боломжгүй. Тогтоолын арга хэмжээг хуультай нийцүүлэн хэрэгжих боломжтойгоор төлөвлөөгүйгээс үнэн зөв үнэлэхэд хүндрэл үүсч байна.	50
27	5.2.1	5.2. Хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан ногоо, жимс, жимсгэнийн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах	Хоногт 5 тонны хүчин чадалтай үйлдвэр байгуулсан байна.	2023-2024	Хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан ногоо, жимс, жимсгэнийн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулахад нийт 9 аж ахуйн нэгж (Дархан-уул 1, Увс 2, Улаанбаатар 6)-д 11.57 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. 2023-2024 онд 11 аж ахуй нэгжид нийт 16.77 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Хөнгөлөлттэй зээлийн хяналтын гэрээ 4-5 жил, гэрээг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна. Гэрээг дүгнэх хугацаа болоогүй	50
28	5.2.2		Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй	Үйлдвэр байгуулсан байна.	2023-2024	Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулахад 2023 онд 9 ААН (Архангай 2, Дорноговь 1, Улаанбаатар хотод 6)-д 2023-2024 оны хооронд нийт 14 аж ахуй нэгжид 39.24 тэрбум төгрөгийн	70

			зээлийн дэмжлэг үзүүлэх			хөнгөлттэй зээлийг олгож дэмжлэг үзүүлэн ажилласан байна.	
29	5.2.3		Хүүхдэд зориулсан, импортыг орлох бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	Үйлдвэр байгуулсан байна.	2023-2024	Хүүхдэд зориулсан, импортыг орлох бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэхэд 2023-2024 оны хугацаанд 38 аж ахуй нэгжид 108.74 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Гэрээг дүгнэх хугацаа болоогүй	70
30	5.3.2	5.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах	Цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн үдийн хоолны нэг хүүхдэд ногдох зардлыг хоолны шимт байдал, инфляцын түвшинтэй уялдуулан өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тухай бүр бий болгох	1	2022-2023	ЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор ЗГ 2024 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолоор баталж эрх зүйн зохицуулалт бий болгосон байна.	70
31	5.6.1	5.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн цахим сан, тогтолцоог бий болгох	1	2022-2023	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн цахим сан үүсгэх ажлын даалгаврыг боловсруулсан байна.	30

		дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх					
--	--	--	--	--	--	--	--

Хавсралт 2. ХАБҮЛЛ болон УМЭАЦТЛ-ийн шинжилгээний үзүүлэлтүүд /2022-2024 он/

№	Лабораторийн нэр	Он	Нийт сорьцын тоо	Нийт шинжлэгдсэн үзүүлэлтийн тоо	Шаардлага хангаагүй үзүүлэлтийн тоо	Эерэг сорьцын эзлэх хувь	1 сорьцонд шинжлэгдсэн үзүүлэлтийн тоо
1	УМЭАЦТЛ-ийн Хүнсний эрүүл ахуй үлдэгдлийн шинжилгээний лаборатори	2022	5,171.0	29,490.0	201.0	0.7	5.7
		2023	8,101.0	70,251.0	263.0	0.4	8.7
		2024	7,662.0	67,940.0	136.0	0.2	8.9
	2022-2024 оны дундаж		6,978.0	55,893.7	200.0	0.4	7.7
2	ХАБҮЛЛ	2022	57,094.0	143,165.0	1,880.0	1.3	2.5
		2023	67,687.0	164,314.0	1,627.0	1.0	2.4
		2024	66,786.0	156,856.0	1,562.0	1.0	2.3
	2022-2024 оны дундаж		63,855.67	154,778.33	1,689.67	1.10	2.43

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 12 дугаар сарын 15 өдрийн 7... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар тогтоосон албан шаардлага, өгсөн төлбөрийн актын жагсаалт

/сая.төгрөг/

№	Зөрчил хариуцах		Хэрэгжүүлэх хугацаа	Мөнгөн дүн	Зөрчлийн товч утга
	Байгууллага	Албан тушаалтан			
Төлбөрийн акт					
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа	2026.06.30	105.0	МЗЭГ-аас нийт 105.0 сая төгрөгөөр Дижитал Медик ХХК-тай байгуулсан 4 гэрээний хүрээнд гүйцэтгэл нотлогдохгүй байна.
2	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Л.Баттөр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Үндэсний лавлагаа лабораторийн дарга Г.Оч	2026.06.30	95.2	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны жишиг тарифээс хэтрүүлэн, НЭМҮТ нь А/108 тушаалаар лабораторийн шинжилгээний тарифыг нэмэгдүүлж тогтоосны үндсэн дээр 2022.09.26–2024.12.31-ний хооронд 95.2 сая төгрөгийн орлого олсон байна.
Нийт дүн				200.2	
Албан шаардлага					
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	ХААХХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалсүрэн, ХААХХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, ХААХХҮЯ-ны Салбарын хяналтын газрын дарга Б.Батшагай	2026.06.30	-	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн ул мөрийг мөрдөн тогтоох журам батлах, татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, нийтэд мэдээлэх чиг үүргийг холбогдох байгууллага хэрэгжүүлээгүйгээс хүнсний аюулгүй байдлын хяналт, ил тод байдал хангагдаагүй байна.
2			2026.06.30	-	Стандартын улсын үзлэгээр шинэчлэх, шинээр батлах шаардлагатай гэж дүгнэсэн хүнсний аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг одоог хүртэл батлаагүйгээс үндэсний стандартын шаардлагыг олон улс, бүс нутгийн стандарттай нийцүүлэх талаар СТЗТҮТХ-д заасан зохицуулалт хэрэгжээгүй байна.
3			2026.06.30	246.8	Хүнс, хөдөө аж ахуйн салбарт мэдээллийн системүүдийг хөгжүүлэх, ашиглах явцад хувийн компанид давуу байдал олгон төлбөр тогтоож ААН-үүдийг хязгаарласан, системийн ашиглалт

					хангалтгүйгээс мэдээлэл бүрэн, бодитой бүртгэгдэхгүй болсон, мөн ижил төстэй системийг дахин хөгжүүлэх замаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж, гэрээний шаардлагад туссан интеграц, мобайл аппликейшн хөгжүүлэлт хийгдээгүй байна.
Нийт дүн				246.8	
4	Мал эмнэлгийн ерөнхий газар	Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа	2026.06.30	2,758.9	МЭЕГ нь дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд батлаагүй, тандалт судалгаанд үндэслэлгүй бодитой бус төлөвлөснөөс вакциныг цаг хугацаанд нь бүрэн дархлаажуулж чадаагүй, улмаар дархлаажуулалтын төсвийг үр ашиггүй зарцуулж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
5			2026.06.30	-	Мал эмнэлгийн сүлжээ лабораториудад үлдэгдэл бодис илрүүлэх шинжилгээний аргачлал, стандартуудыг СХЗГ-аар батлуулж, шинэчлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулаагүйгээс нэгдсэн стандарт, арга зүй бүрдээгүй, зарим аргачлал хүчингүй болсон хэвээр ашиглагдаж, улмаар лабораторийн шинжилгээний чанар, уялдаа хангагдаагүй бөгөөд холбогдох хуулиудад заасан шинжилгээний аргачлал боловсруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.
6			2026.06.30	246.2	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн болон мал эмнэлгийн нэгдсэн цахим системүүдийг хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө зарцуулж ажлыг хүлээн авсан боловч гэрээний даалгаварт туссан ихэнх модуль, дэд ажлууд хэрэгжээгүй, системүүд хоорондын уялдаа, мэдээллийн нэгдсэн бүртгэл бүрдээгүй, улмаар малын эмийн хэрэглээ, гарал үүсэл, хэрэглэгчийн талаарх иж бүрэн мэдээлэл бүрдүүлэх боломжгүй байна. Үүний зэрэгцээ хувийн компани төрийн системийг ашиглан хэрэглэгчдээс заавал төлбөр авч, төлбөр төлөөгүй

					тохиолдолд систем ашиглах эрхийг хааж байгаа нь төрийн мэдээллийн системийн ашиглалт, төсвийн хөрөнгийн үр ашиг, ил тод байдал хангагдаагүйг харуулж байна.
7			2026.06.30	792.0	Дархлаажуулалтын төлөвлөгөөг тархвар зүй, лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн оновчтой боловсруулаагүй, хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс вакцины хугацаа дуусч их хэмжээний санхүүгийн хохирол учирсан, мөн вакцины хадгалалт, тээвэрлэлт, тарилгын явц дахь хүйтэн хэлхээний гүйцэтгэлийн хяналт, бүртгэл, хэмжилтийг зохих журмын дагуу хэрэгжүүлээгүй нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.
8			2026.06.30	3,681.9	Сэлэнгэ аймгийн МЭГ нь лабораторийн барилга, тоног төхөөрөмжийг улсын комиссоор хүлээлгэн өгөөгүй, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж ашиглалтад оруулаагүй, хадгалалт, тохируулга, холболтын шаардлага хангаагүйгээс шинжилгээний үйл ажиллагаа явуулах боломж бүрдээгүй бөгөөд үүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг зөрчсөн байна.
9			2026.06.30	608.1	Дорноговь аймгийн МЭГ нь шинжилгээний тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж, холболт хийж ашиглалтад оруулаагүй, улмаар урвалж, оношлуурыг хугацаа дуусах хүртэл ашиглаагүйгээс шинжилгээний үйл ажиллагаа доголдож, төсвийн хөрөнгийн үр ашиг хангагдаагүй байна.
Нийт дүн				8,087.1	
10	Эрүүл мэндийн яам	ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын дарга О.Энхболд	2026.06.30	-	Хүнсний бүтээгдэхүүний хүнд металлын аюулгүйн үзүүлэлтийг үндэсний хэмжээнд нэг мөр мөрдөхүйц, олон улсын стандарт, өнөөгийн хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэн тогтоогоогүй, хэрэглэх нөхцөлийг тодорхойлоогүйгээс хуульд заасан чиг үүрэг

					хэрэгжээгүй байна. Мөн НЭМҮТ нь үндэсний аюулгүй байдалд хамаарах биологийн сорьцыг гадаад улсад шинжлүүлэхдээ холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоогүй, магадлан итгэмжлэгдээгүй үзүүлэлт, лабораториор тандалт, шинжилгээ хийсэн, лавлагаа лабораторийн хүчин чадал, итгэмжлэл хангалтгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлын тандалт, шинжилгээний тогтолцоо хууль, стандартын шаардлагад нийцээгүйг харуулж байна.
11	Стандарт хэмжил зүйн газар	СХЗГ-ын дарга С.Батбаатар, Нийслэлийн лабораторийн дарга Д.Эрдэнэтуяа	2026.06.30	-	Хүнсний тухай хуульд заасан шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмыг батлах үүргийг холбогдох яам хэрэгжүүлээгүй, мөн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг биелүүлээгүйгээс хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.
12			2026.06.30	-	НЭМҮТ нь хамтарсан сайдын тушаалаар баталсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жишиг хэмжээнээс хэтрүүлэн, журамд тусгагдаагүй лабораторийн шинжилгээнүүдэд нэмэлт тариф тогтоон төлбөр авч, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг зөрчсөн байна.
13			2026.06.30	64.0	СХЗГ нь лабораторийн тоног төхөөрөмжийг НТШ аргаар худалдан авахдаа техникийн тодорхойлолтод заасан шаардлага, зориулалтад нийцээгүй нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авснаар төрийн худалдан авалтын ил тод, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хангаагүй, техникийн тодорхойлолтыг хуульд заасны дагуу тодорхой, үндэслэлтэй боловсруулах үүргийг хэрэгжүүлээгүй байна.
14			2026.06.30	-	Шаардлага хангаагүй бүтээгдэхүүний талаарх мэдээллийг холбогдох төрийн байгууллагад тухай бүр хүргүүлдэггүй

15			2026.06.30	-	Батлагдсан АБ-ын үзүүлэлтүүдийг бүрэн шинжилдэггүй
Нийт дүн				64.0	
16	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	ХАБҮЛЛ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Нандин-Эрдэнэ, ХАБҮЛЛ-ын техникийн менежер Б.Арвинтулга	2026.06.30	-	Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори нь хуульд заасан лабораториудын шинжилгээний дүнг нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, удирдах, дүн мэдээллийг тухай бүр хүлээн авах чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүнсний аюулгүй байдлын тандалт, шинжилгээний мэдээлэл нэгдсэн, уялдаа холбоотой бүртгэгдэх тогтолцоо бүрдээгүй байна.
17			2026.06.30	-	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь LIMS программ хангамжийн үйлчилгээний гэрээ, гүйцэтгэлийг зохих ёсоор дүгнэлгүйгээр, гэрээ байгуулаагүй болон гэрээний хүчин төгөлдөр бус хугацаанд хамаарах 20.9 сая төгрөгийн төлбөрийг хувийн компанид шилжүүлсэн нь төсвийн хөрөнгийг үндэслэлгүй, хяналтгүй зарцуулсан зөрчилд тооцогдож байна.
18			2026.06.30	-	Дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний мэдээлэлд гарал үүсэл, ялгах тэмдэглэгээ, хадгалах болон хэрэглэж дуусах огноо зэрэг зайлшгүй бүрдүүлэх мэдээллийг тусгаагүйгээс хүнсний аюулгүй байдлын мэдээллийн санг хуульд заасан шаардлагын дагуу бүрэн, үнэн зөв хөтлөөгүй байна.
19	Гаалийн ерөнхий газар	Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал	2026.06.30	-	ХАБ-ын эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийдэггүй
20			2026.06.30	3,021.3	Чингис хаан ОУНБ ддахь Гаалийн газар нь лабораторийн барилга, тоног төхөөрөмжийг ашиглаагүй, урвалж оношлуур хугацаа дууссан
21			2026.06.30	3,011.4	Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын лабораторий итгэмжлэгдээгүй, чиг үүргээ хэрэгжүүлээгүй
22			2026.06.30	1,185.9	Замын-Үүд дэх Гаалийн газар нь лабораторийн тоног

					төхөөрөмжийг ашигаагүй, урвалж, оношлуур хугацаа дууссан
23			2026.06.30	1,005.0	Гаалийн төв лаборатори ХАБ-ын шинжилгээ хийгээгүй, тоног төхөөрөмжийг ашиглаагүй
24			2026.06.30	-	Хүнсний бүтээгдэхүүнийг иж бүрэн хяналт шалгалтад хамруулдаггүй
Нийт дүн				8,223.6	
25	Үндэсний итгэмжлэлийн төв	ҮИТ-ийн дарга С.Ням-Эрдэнэ	2026.06.30		Хүчингүй стандарт аргачлалаар итгэмжилсэн
26			2026.06.30		Шалгуур хангахгүй лаборатриудад итгэмжлэл олгосон
Нийт		Албан шаардлага	Дүн /сая төгрөг/	16,654.5	
		Төлбөрийн акт		200.2	